



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА БАЙДАЛ БА ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн

Улаанбаатар 2020

Хянан тохиолдуулсан: Д.Дуламсүрэн
Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён
гэрээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар

Нэгтгэсэн: Л.Нарантуяа
Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён
гэрээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар
Ц.Сэлэнгэ
Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён
гэрээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар

Цаасны хэмжээ: В5
Хэвлэлийн хуудас: 6
Хэвлэсэн тоо: 1000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Авлигын эсрэг олон улсын өдөр жил бүрийн 12 дугаар сарын 09-ний өдөр тохиодог. 2005 онд дэлхийн улс орнуудын удирдагч нар Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн орж, гарын үсэг зурах бага хурлыг Мексикийн Мерида хотноо зохион байгуулж байжээ. Дэлхийн улс орнуудын өндөр албан тушаалтнууд гарын үсгээ зурсан энэ өдрийг Авлигын эсрэг олон улсын өдөр хэмээн НҮБ албан ёсоор тунхагласан юм.

Манай улсын хувьд НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцид 2005 онд нэгдэж, мөн оны 10 дугаар сарын 27-нд Конвенцийг соёрхон баталснаар Монгол Улс авлигын эсрэг олон улсын үйл хэрэгт хөл нийлүүлэх болсон. Авлигын эсрэг хуулийн дагуу Авлигатай тэмцэх газар байгуулагдсанаас хойш манай улс Авлигын эсрэг олон улсын өдрийг 13 дахь удаагаа тэмдэглэж байна.

Жил бүрийн энэ өдрийг угтаж Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, идэвх санаачилгыг өрнүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулдаг. Тухайлбал, 2016 онд “Авлига ба хүний эрх” бага хурал, 2017 онд “Авлигын эсрэг чуулган”, 2018 онд “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” хэлэлцүүлгийг тус тус амжилттай зохион байгуулж байсан.

Харин 2019 оны энэ өдөр Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбооны төлөөллүүд “Шударга байдал ба олон нийтийн

илтгэл” сэдвийн дор хуран цуглаж, хуулийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, түүнчлэн энэ цаг үед нийгмийн шаардлагыг харгалзан тулгарч буй хүндрэл бэрхшээл, бодит нөхцөл байдал, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь хууль эрх зүйн болон практик хүндрэл, түүнийг хэрхэн шийдвэрлэх, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар хэлэлцэж, санал бодлоо солилцов.

Хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчид мэргэжлийн өндөр ёс зүйтэй байж, хуулийн хүрээнд хараат бусаар, аливаад алагчлалгүйгээр хандан шийдвэр гаргаж ажиллах нь хуулийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, түүнийг хадгалах гол гарц гэдгийг оролцогч, илтгэгчид онцлон хэлэлцсэн чухал ач холбогдолтой зөвлөгөөн болсон юм.

Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулсан энэхүү зөвлөгөөнд шүүх эрх мэдлийн болон хууль зүйн салбарт ажиллаж байгаа мэргэшсэн албан хаагч, өмгөөлөгч, багш-судлаачид оролцож, өнөөгийн бодит нөхцөл, цаашдын бодлого, үйл ажиллагааны талаар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлснийг эмхтгэн олны хүртээл болгож байна.

Энэхүү эмхтгэлд орсон илтгэлийн агуулга, үзэл санаа, шийдэл нь авлигын эсрэг үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, хууль зүйн салбарын шударга ёсны үнэмлэмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж, эрдэмтэн судлаач, оюутан суралцагчийн судалгааны хэрэглэгдэхүүн болно гэдэгт найдаж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ НЭЭЖ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВААГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм зочид оо,

Хатагтай, ноёд оо,

Мэргэжил нэгт нөхөд өө,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая!

Юуны өмнө Олон улсын авлигын эсрэг өдөр зохион байгуулж буй хуулийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд хүрэлцэн ирсэн Та бүхэнд талархал илэрхийлье.

Дэлхийн улс орнууд мөнгө угаах, хар тамхи болон хүн худалдаалах, зэвсгийн наймаа, авлига, терроризм зэрэг хор уршиг ихтэй, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд онцгойлон анхаарч, тэдгээрийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх чиглэлээр нэгдсэн арга аргачлал боловсруулан, үр дүн гаргахад чармайн ажиллаж байна.

Дээр дурдсан гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд эрх зүйн болон санхүү, эдийн засгийн өндөр түвшний мэдлэг, ур чадвар, туршлага шаардагддаг бөгөөд мэргэжлийн шинжээчдийн оролцоо чухал юм. Ялангуяа эрх мэдэлтэй “цагаан захтнууд”-ын үйлддэг авлигын гэмт хэрэг нь цаг хугацаа, хүч хөрөнгө шаарддаг, дотоод, гадаадын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын нягт хамтын ажиллагааны үндсэн дээр илэрч шийдвэрлэгддэг онцлог гэмт хэрэг.

Мөрдөн шалгах чиглэлээр сүүлийн үед илрүүлж байгаа гэмт хэргүүдийн арга барил, хэв шинжийг авч үзэхэд өндөр зохион байгуулалттай, бусад хэлбэрийн гэмт хэргүүдтэй хавсарсан шинжтэй, хаалттай, нууц далд байдалд үйлдэгдэж байна.



Энд би хоёр зүйлийг хэлмээр байна. Нэгдүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллаараа авлига, албан тушаалын гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар шалгадаг боловч хавсарсан шинжтэй бусад гэмт хэргийг тухайлбал, мөнгө угаах, хууль бус санхүүжилт, сонгуулийн санал худалдаж авах зэрэг гэмт хэрэг нь хуулийн бусад байгууллагад харьяалагддаг.

Энэ утгаараа хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, амьд харилцаа нь гэмт хэргүүдийг илрүүлж, шалган нотлоход чухал үүрэгтэй. Гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэхэд нотлох баримтыг цаг алдалгүй цуглуулах, хурдтай ажиллахыг нийгэм, цаг үе, нөхцөл байдал шаардаж байна.

Гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгө, орлогыг оффшор бүсэд байршуулах, гуравдагч этгээдэд шилжүүлэх зэргээр санхүүгийн бүтцийг өргөн хүрээнд ашиглан гадаад улсад нуун далдалж байгаа нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулж, цаг хугацаа ихээхэн шаардагддаг.

Сүүлийн үед шалгагдаж байгаа Эрдэнэт үйлдвэр, Оюутолгой,

Хөгжлийн банк гэх мэт манай улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлж байгаа зарим хэргүүдийг шалгах явцад гадаад улсын хууль сахиулах, санхүүгийн мэдээллийн, мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх зэрэг хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллаж байгаа боловч нотлох баримтыг тэр бүр бүрэн дүүрэн, шуурхай олж авч чадахгүй байгаа нь олон нийтийн шүүмжлэлийг дагуулж байна. Иймд улс дамнасан гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэхэд гадаад улсын хуулийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах зайлшгүй шаардлага мөн тулгарч байгааг энд дурдах нь зүйтэй.

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартын хэрэгжилтээрээ Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах олон улсын байгууллага /ФАТФ/-ын саарал жагсаалтад орсныг та бид мэдэж байгаа. Энэ нь манай улс уг асуудлыг зохицуулж буй эрх зүйн орчноо эргэж харах, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, ажлын арга барилаа өөрчлөх, шинэчлэх хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байна. Эхний ээлжинд Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдлаа. Цаашид уг асуудлаар ойлголтоо нэгтгэх, хамрах хүрээг оновчтой тогтоох, мэдээлэл солилцох, мөрдөн шалгах болон хяналтын үйл ажиллагааг уялдуулах, технологийн дэвшилтэт арга хэрэгслийг нэвтрүүлэх, албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, олон улсын туршлага, практикаас нэвтрүүлэх ажилд ахиц гарган ажиллах шаардлагатай байна.

Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр ахиц дэвшил гарч байгаа. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Авлигын гэмт хэрэг гэсэн

бүлэг байгаа бөгөөд гадаад улсын төрийн албан хаагчдыг хахуульдах, албаны эрх нөлөөгөө урвуулан ашиглах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, дураараа аашлах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зэрэг холбогдох зохицуулалт хуульд тусгалаа олсныг онцлон хэлмээр байна. Гэвч хэрхэн хэрэглэх болон хамрах хүрээ нь тодорхой бус байгаагаас эрч далайцтай ажиллаж чадахгүйд хүргэх сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй байна.

Хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны талаар хууль тогтоогч, шийдвэр гаргагч, иргэд, олон нийт, хууль сахиулагчид зэрэг бүх түвшиндээ бодитой, үнэн зөв ойлголттой болох шаардлага байгаа нь харагдаж байна.

Хууль тогтоомжийг өөрт ашигтай байдлаар өөрчилж, хууль тогтоомжоор давуу байдал олгосон гэж олон нийт бухимдаж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нийтээрээ шүүн хэлэлцэж, гэмт хэрэгтнүүдэд ял завших боломж, гарцыг хаахыг нийгэм хүлээж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нотлох, хариуцлага хүлээлгэх ажиллагаанд өөрчлөлт хийх, цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд хяналт тавих, олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн сантай болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд холбогдох төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа нь хамтын ажиллагааг сайжруулах нэг алхам хийгдэж байна гэж үзэж болно.

Нөгөө талаас, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад бодитой, үр дүнтэй, бүтээлчээр хамтран ажиллахыг хаа хаанаа анхаарч ажиллах нь зүйтэй байна. Өнөөдрийн хурдацтай хөгжиж буй орчин үеийн технологийг

ашиглах, авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэхэд шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах шаардлагатай байгаа. Нийгэмд анхаарал татсан, нийтийн ашиг сонирхлыг хохироосон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх чиглэлээр хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж ажиллахыг уриалж байна.

Хоёрдугаарт, сүүлийн үед иргэд, олон нийтийн зүгээс төрийн байгууллагуудын шударга байдалд эргэлзэж, төрд итгэх итгэл алдарч байгаа талаар ярьж, бичих нь ихэслээ. Иргэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад хариуцлага тооцохыг шаардах боллоо.

Бид шүүх, хуулийн байгууллагуудын нэр хүнд олон нийтийн дунд унасныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Энэ цаг үед нийгмийн шаардлагыг харгалзан тулгарч буй хүндрэл бэрхшээл, бодит нөхцөл байдлын талаар зөвлөлдөн, бодлого, стратеги, арга механизмаа ярилцах боломжийг олгохоор Авлигатай тэмцэх газраас санаачлан бусад байгууллагатай хамтран Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг “Шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвийн дор зохион байгуулж байна.

Нийгэмд авлигын шинжтэй мэдээлэл түгээмэл тархахын зэрэгцээ иргэд, олон нийт Авлигатай тэмцэх газраас, прокуророос, шүүхээс багагүй мэдээллийг шаардах боллоо.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийн 5-д зааснаар бид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж байна.

Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах үйл ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-т зааснаар хэрэгт хяналт тавьж буй прокурор эрүүгийн хэргийн нотлох баримтад дүгнэлт хийж, эргэлзээгүй нотлогдсон, хэргийг цаашид шалгаж шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянаж, дээд шатны прокурорт танилцуулснаар олон нийтэд мэдээлж ирсэн ба хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж олон нийтэд мэдээлэхийг хориглодог.

Үүнийг иргэд, олон нийт ойлоогоүйгээс хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг шаарддаг. Иргэд мөрдөн шалгасан эрүүгийн хэрэг, прокуророос шүүхэд шилжүүлсэн хэрэг, шүүхээр таслан шийдвэрлэсэн хэргийн талаарх мэдээллийг шалгасан, хянасан, шийдвэрлэсэн байгууллагаас нь авч дүгнэлт хийхийг илүүд үзэж байна. Энгийн жишээг дурдвал Авлигатай тэмцэх газар, цагдаагийн шалгасан, прокурорын шүүхэд шилжүүлсэн, шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тооноос дүгнэлт хийж, тухайн байгууллагуудад дүн тавьж байна. Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах үйл ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-т дурдагдсан эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээлэх зааварчилгаа, журмыг хууль сахиулах байгууллагууд хамтран сууж, шинэчлэн боловсруулж, иргэдэд мэдээлэл давхардуулахгүй, бодит нөхцөл байдалд тулгуурласан мэдээлэл хүргэдэг болох нь зүйтэй.

Гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд хэрхэн мэдээлэх ажил шат

шатандаа харилцан ойлголцож, тогтож хэвшээгүй, мэдээлэл хаалттай байгаа нь иргэдийн хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх итгэл буурах үндсэн шалтгаан болж байна. Иймд холбогдох байгууллагууд гэмт хэрэг, зөрчлийн талаар цаг алдалгүй олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах, ялангуяа мэдээлэл түгээх оновчтой арга хэлбэрийг тодорхойлж, нэвтрүүлж, хэвшүүлэх нь нэн чухал гэж үзэж байна.

Авлигын эсрэг хуульд албан хаагч авлигын талаархи мэдээллийг Авлигатай тэмцэх газарт мэдээлэх үүрэгтэй байхаар, иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгч болохоор заасан ба мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах талаар зохицуулалт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх, гэмт хэргийг илрүүлэх, нотлоход дэмжлэг үзүүлсэн иргэнийг урамшуулах, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй байна. Энэ чиглэлээр Авлигатай тэмцэх газраас Шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж, УИХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.

Авлигатай тэмцэх газрын дэргэд авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус Олон нийтийн зөвлөл, Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд тухайн нутаг дэвсгэр дэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Иргэний зөвлөл ажиллаж байгааг мэднэ.

Хуулийн байгууллагуудын дэргэд ажиллаж буй орон тооны бус зөвлөлүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, уялдуулах замаар хууль сахиулах байгууллагын нэр хүнд, итгэлийг олон нийтийн дунд нэмэгдүүлэх боломж байгааг дурдах нь зүйтэй.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах” зорилтын явц 36,8 хувьтай байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм аа. Иймд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, 2022 онд биелэлтийг нь бүрэн хангахын тулд хуулийн байгууллагуудын идэвх санаачилга, хамтын ажиллагаанд далайцтай өөрчлөлт хийж, ахиц гаргахад анхаарч ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгарч буй хууль эрх зүйн болон практик хүндрэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн шийдэлд хүрэх шаардлага байгаа учраас энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

Өнөөдрийн хэлэлцүүлэг нь хуулийн байгууллагуудын бүх талын оролцоог хангасан, олон нийтэд энэ чиглэлээр үнэн бодит мэдээлэл, ойлголтыг өгөх ач холбогдолтой арга хэмжээ болно хэмээн үзэж байна. Ийм учраас Та бүхэн тавьж байгаа илтгэлд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр өөрсдийн санал бодлоо илэрхийлнэ гэдэгт найдаж байна.

Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, байгууллага хооронд мэдээлэл солилцох боломж нөхцөлийг

бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, хэрэглээнд оруулах, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд шинэ арга технологи, стандартуудыг нэвтрүүлэхийн зэрэгцээ иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх, хамтран ажиллах механизмыг

бүрдүүлэх, гэмт этгээдэд ял завших боломж олгохгүйгээр тохирсон ял шийтгэлийг оногдуулах зэрэг шударга ёс, хууль дээдлэх зарчмыг чанд сахин ажиллахаас бидний ажлын үр дүн шууд хамаарах болно гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсье.
Анхаарал тавьсанд баярлалаа.

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛИЙГ ОЛОХ НЬ

Илтгэгч: Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах комиссар Ч.Жаргалбаатар



Дэлхийн улс орон бүр авлигатай тэмцэх хүсэл сонирхлоо хүн төрөлхтөнд зарлаж мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх сүлжээг байгуулсаар байна. Цагийн аясаар тун удахгүй хулгайлагдсан хөрөнгө байрших газаргүй, хулгай хийсэн этгээд орогнох газаргүй болох цаг айсуу гэдэгт би итгэдэг.

“Шударга байдал ба олон нийтийн итгэл” хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнд оролцож тулгамдсан асуудлаа хэлэлцэн ярилцаж, гарах гарц боломжийг эрж байгаа Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсье.

“Монгол бол Түвд биш” гэсэн нийтлэлд дурдсан **“Хүүхэд насанд айлын хоол амттай ч ээжийн хийсэн хоол илүү сайхан, хүний нутгийн хөгжил, өнгө үзэмж нүд унагам сайхан ч миний эх орон түүнээс ч илүү сайхан. Тийм ээ, монголчууд бид ардчилсан нийгэмд эрх, эрх чөлөөгөө бүтэн эдэлж яваа хөгжиж буй орны иргэд”** гэсэн ишлэлээр илтгэлээ эхэлье.

Бүх зүйл болохгүй бүтэхгүй байгаа юм биш, болж байгааг ярихгүй, харин болохгүй байгаа, хийдэл үгүйсгээд байгаа нөхцөл байдал, хийдлийг засаж залруулах нь бидний үүрэг юм.

Зарим хүмүүний хууль бус, амар хялбар аргаар хөрөнгө мөнгөтэй болж тансаг амьдрах гэсэн аминч үзэл, нийтийн албан тушаалтны бусадтай барьцах сэтгэлгээ, эрх мэдэлд хүрэх гэсэн харалган зорилго, өргөсөн тангаргаа умартсанаар Монгол хүний эрх ашиг, улсынхаа үндэсний аюулгүй байдалд бодит хохирол учруулж байгааг баримтаар нотлох, гэмтэй бол зэмтэй байх ардын сургаал, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаад байгаа нөхцөл байдалд дүгнэлт хийхийг хичээлээ.

Нэг. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн гэж тодорхойлсон хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, гэмт үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэдий ч хүссэн үр дүн гарахгүй, авлигын индекс сүүлийн 10 жилд 36-39 гэсэн оноогоор нэг л байрандаа

байсаар байна. Бид социалист онолоор хүмүүжиж, төлөвшсөн, одоо цагт лебирал онол гэсэн шүтээнтэй. Энэ хоёр онол нь харшлаад урагш хоёр алхаад буцаж нэг алхаад байгаа нь улс төрчдийн төлөвшил, авлигатай тэмцэх хүсэл сонирхолтой нь шууд хамааралтай.

Хууль тогтоох байгууллагаас тодорхойлсон ялын хэт хөнгөн бодлого, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэлтэй зохицуулалт гэмт этгээдүүдэд давуу байдал олгож, улс төрийн сонголтын онол цэцэглэн хөгжиж эдийн засгийн онолын хэтийдсэн дүр төрх илэрч (төрийн алба, бизнес хэмээх ойлголтууд тус тусдаа ойлголт бөгөөд зоосон мөнгөөр төсөөлбөл зоосны 2 тал гэж тодорхойлж болох боловч манай улсын хувьд зоосны 2 талдаа бус нэг талд багтаж), улс төрч бүхэн бизнес эрхлэгч, баялаг бүтээгч бүр улс төрч болсон. Ялагч бүхнийг авах сэтгэлгээ давамгайлж, төрийн үйлчилгээ ялсан намын өнгөөр сүлрээд, намын томилгоотой нийтийн албан тушаалтнууд иргэндээ бус намдаа, гишүүддээ үйлчилдэг, баялагийн тэгш хуваарилалт алдагдаж, шударга ёс сүүмийсээр байна гэж хувьдаа дүгнэн хардаг. Баялаг бүтээгч нараа дэмжиж байна гээд өршөөл, уучлал үзүүлдэг, баялаг бүтээгч нь бараа бүтээгдэхүүнээ борлуулах үедээ татвараа тооцоолж өртөг тодорхойлоогүй, татвараа хасаад арилжаа хийсэн гэж бодож байна уу? **Татвар шингээсэн өртгөөр борлуулалт хийчихээд байхад яалаа гэж өршөөл, уучлал үзүүлээд байгаа юм бэ?**

Монгол Улсын дархан хил Замын-Үүд дэх гаалийн хяналт шалгалт хийдэг гаалийн улсын байцаагч нарын судалгааг авч танилцахад жижиг 76, төрийн өндөр албан тушаалтан нарын хамаарал бүхий хүмүүс ихэвчлэн

томилогдон ажиллаж байгаа нь тодорхой ажиглагдсан. Томоохон гэж нэрлэгдээд, иргэдийг бухимдуулаад байгаа хэргүүдийн ил эх сурвалжаас нь Та бүхэн татан авч судалгаа хийгээд үз. Улс төрчдийн эрх ашиг шингэсэн, улс төрийн шийдлүүд байх нь элбэг. Гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг олон нийтэд таниулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, гэм буруутай этгээдүүдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах, нийтийн албан тушаалтнуудыг улс төрчдийн нөлөөллөөс ангид байх соёл төлөвшүүлэх, төрийн алба хаагч нарын чадавхийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч нар хуулийн дагуу хууль, эрх зүйн туслалцаа үзүүлдэг, ёс зүйн болон мэргэжлийн алдааг гаргасан хүмүүст хариуцлага тооцдог механизм бүрдүүлэх, хуулийн нэг мөр ойлгож хэрэгжүүлэх чадавхид суралцуулах, хууль сахиулагч нарын ур чадварыг нэмэгдүүлж, ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан тогтоосноор гэмт үйлдлийг бүрэн илрүүлэх, хариуцлага шударгаар оногдуулах, шударга ёс тогтох үндэс бүрдэнэ.

Хуулийн хийдэлт зохицуулалт бүрийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл, судалгаа, танилцуулга хүргүүлсээр байгаа хэдий ч засаж залруулах ажилд ахиц дэвшил гарсангүй ээ. Бид дотоод нөөц бололцоогоо ашиглан судалгаа явуулж бодит нөхцөл байдлыг тодорхойлохоор **эрх мэдэл булаацалдсан**, буруугаа бусдад нялзаасан, эрх хэмжээ нь хязгаарлагдаад ирэхээр матрын нулимс унагалаа, ашиг сонирхлын зөрчил бүхий дүгнэлт хийсэн гэх мэтээр шүүмжлэл өрнүүлж мохоодог. Авлигатай тэмцэх газарт хуулиар харъяалал тогтоож өгсөн нийтийн албан тушаалтан нарын үйлдсэн хэрэгт мөрдөн шалгах

ажиллагаа явуулдаг болохоор эрх мэдэлтнүүд өөрсдийнхөө хууль бус үйлдлийг шалгах ажиллагаанд саад хийх зорилгоор хийдэл бүхий зохицуулалтыг хуульчлан өгч өөртөө нөхөддөө дархлаа тогтоосон гэж үзэхээс өөр тайлбар олдсонгүй ээ.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлсэн, хүний эрхийг баталгаатай эдлүүлэх оролдлого хийсэн гэж зарим хүмүүс тайлбар хийж байгаа. Энэ бол төөрөгдөл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бол оролцогч, тэдний өмгөөлөгч, прокурор, шүүх гээд хангалттай олон хүний хяналт доор явагддаг ажиллагаа.

Төсвийн үргүй зарлагыг бууруулах, авлигын хэрэгт холбогдсон төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцохыг иргэд хүсэмжилж буй энэ цаг хугацаанд бидний тулгамдсан асуудлыг Азийн хөгжлийн банкаас анхааран үзэж, Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх үйлсэд зориулан техникийн туслалцаа үзүүлэх, бодит нөхцөл байдлыг судлан урхаг байгаа газар, үндэс суурийг олж тогтоохоор судалгааны ажлаа эхлүүлсэн явдалд талархаж байгаагаа илэрхийлье.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Дубуйн гэрээ, Утаа, Асем, ЖДҮ, Эрдэнэтийн үйлдвэрийн 49% гэж нэрлэгдсэн нийтийн эрх ашгийг илтэд хөндсөн үйлдлүүдийг иргэд шүүн ярилцаж байхад нөлөө бүхий этгээдүүд энэ цаг хугацаанаас хойш төрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг нь 1 жилээр ухрааж, хахууль өгсөн гэмт үйлдлээ илчлэн ирсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг үгүй хийж, хэд хэдэн удаа Өршөөл үзүүлэх тухай хууль батлан, Эрүүгийн хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулж амжив.

Монгол Улсад бүртгэгдэж байгаа нийт гэмт хэргийн 0,6%-ийг эзэлдэг албан тушаалтнаас албан тушаалын байдлаа ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүдийн шийдвэрлэлт үнэхээр учир дутагдалтай байна. Эдийн засгийн эрх чөлөөнд хүрч чадсан, улс төрд нөлөө тогтоосон хүмүүсийн үйлдэл нь урхагтай, хохирол нь их хэдий ч хуулийн хийдэл, гадаад оронд гарч амьдрах зэрэг ядмагхан аргачлалаар ял завших, олж авсан хууль бус давуу байдлаа хадгалах, шударга ёс тогтоох гэсэн нийтийн албан хаагч нарт өш хонзон санадаг, элдвээр гүтгэн доромжилдог нөхцөл байдал үүсээд удлаа. Дэлхийн улс орнуудын төр Ард иргэдээ аз жаргалтай амьдруулж чадаж байгаа эсэхийг “АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС”, “АВЛИГЫН ИНДЕКС” гэсэн 2 судалгааны үзүүлэлтээр тодорхойлдог. Бид сүүл мушгисаар явааг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Францын нийслэл Парис хотод болсон FATF-ийн хурлаар тодорхойлж, Монгол Улсыг *саарал* жагсаалтад бүртгэсэн шийдвэрээ дэлхий нийтэд зарлав. Монгол улсад авлига газар авсан, албан тушаалтны дур зорго нэмэгдсэн гэдгийг ард иргэд хүлээн зөвшөөрч, судалгааны дүнгээр баталгааждаг байгаа нь энэ.

Азийн сангийн 2019 онд хийсэн судалгаагаар Монгол Улс дахь авлигын хэрэг шийдвэрлэлтийн хувь 23.89 хувьтай байгаа нь Япон, БНСУ зэрэг өндөр хөгжилтэй улсууд болон БНХАУ-ын онцгой бүс Хонг Конгтой харьцуулахад харьцангуй бага байгааг тодорхойлжээ. Тэд шалгасан бүх хэргийн тоогоо бус, зөвхөн мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтээр судалгаа тайлангаа гаргадаг бол бид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргээс тоон үзүүлэлтээ гаргаж буй асуудал нь Монгол Улсын

нэр хүндийг олон улсын түвшинд унагах, иргэдийн итгэлийг бууруулах илтгэлцүүр болсон байх үндэслэлтэй, бас анхааран үзэх өнцөг гэдгийг дурдаж байна.

Хүссэн үр дүн гарахгүй, нийгмийн бухимдал газар авсаар байгааг судлан үзэх нь шаардлага, тулгамдсан асуудал. Дэлхийн олон улсын судлаачид бидэнд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг сонсоод гайхсан, шоолсон дүр төрхийг харуулдаг (хээл хахууль авч байгаа фактыг дуу-дүрс бичлэгээр бэхжүүлээд шүүхэд хүргүүлэхээр яг хэдэн төгрөг хахуульд өгч байгааг тогтоо, тэр даруй үйлдлийг таслан зогсоох үүргээ хэрэгжүүлсэнгүй..., хахууль өгөгч нь авагч талынхаа дарамтад ороод шүүх хурал дээр мэдүүлгээсээ буцахаар мэдүүлийг үнэлэх, дүгнэлт өгөх боломжгүй гэж дүгнэж шийдвэр гаргаж байгаа асуудал, хахууль өгсөн авсан этгээдүүд шүүх дээр үгсээд худал мэдүүлэг өгөхөөр цагаатгасан шийдвэр гаргасан) бөгөөд би одоо ч тэр төрхийг мартаж чадаагүй явна. Бурууг бусдаас хайх, бусдад нялзаах нь цагаа олсон зүйл биш.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэл, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй орнуудтай харилцах, мэдээлэл солилцох, нотлох баримт гаргуулан авах гээд ярилцвал барагдахгүй хүндрэл бэрхшээл байгаа бөгөөд хүнээс хамааралтай олон асуудал ч байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан "...гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх зорилт"-ийг хангахад хуулийн зарим зүйл заалтууд харшилж зөвшөөрлийн зохист харилцаа алдагдсан, зарим процессийг хуульчлаагүй байдал нь мөрдөн шалгах ажиллагаа удаашрах, гэм буруутай этгээдүүд ял завшиж,

хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд бодит хүндрэлүүд болоод байна.

Эдгээрээс хамгийн их анхаарал татаж байгаа асуудлын нэг нь **“бүрэн эрх, халдашгүй байдал” улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн тухай асуудал** болж байна. “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, адил байна, хүний эрхийн байдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй шалгууруудыг “үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол” гэж Монгол Улсын “Үндсэн хууль”¹-д хуульчилж өгсөн атлаа хүний эрхэлж байгаа ажил, албан тушаал зэргээр ялгаварлаж, аль нэг хэсэгт нь давуу эрх олгох, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлсөн хууль байсаар байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн², Төрийн албаны зөвлөлийн гишүүд, шүүгч нар гээд халдашгүй байдал, бүрэн эрхтэй хүн олон хүн байна. Шүүх засаглал ажлаа хийж, шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа яагаад тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, удирдлагаас зөвшөөрөл хүсэх ёстой юм бэ. Азийн иргэдийн онцлог бол “элэгний онол”-ын илрэл ихтэй. Нэг нэгнээ хамгаална, нөгөө эрх тэгш байх зарчим алдагддаг, мөрдөн шалгах шуурхай ажиллагаа удааширч бодит нөхцөл байдлыг тогтоох баримт сэлт үрэгдэх, оргон зайлах нөхцөл болж

1. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үзэх. 1992 он

2. Комиссын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Комиссын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нээжлэг хийхийг хориглоно

байгааг өнөөдөр өрнөж байгаа олон улсад эрэн сурвалжлах ажиллагаа явуулж байгаа баримтаас харагдана.

Эрх зүйн хэм хэмжээний эрэмбэ талаас нь авч үзвэл салбарын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн тодорхой зохицуулалтыг хязгаарласан ноцтой зөрчил юм.

Тухайн төрлийн гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг бүрэн ойлгож таньж чадаагүй байдал, гэмт хэргүүдтэй тэмцэх эрх зүйн орчин хязгаарлагдмал, оногдуулах ял шийтгэл хэт хөнгөн байгаагаас үүдэн тухайн тэмцэл тодорхой үр дүнд хүрэхгүй байна гэж үзэх үндэслэл тодорхойлогдож байна.

Хоёр. Монгол Улсын Авлигатай тэмцэх газар байгуулагдаад 13 дах жилтэйгээ золгож байна. Энэ цаг хугацаанд олон тооны хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, олон хүнд холбогдох хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэдий ч хуулийн хийдэл, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чадвар, эдийн засгийн эрх чөлөөнд хүрсэн, улс төрд нөлөөгөө тогтоосон зарим хүмүүсийн овжин үйл ажиллагаанаас үүдэн олон хүн ял завшиж нийгэмд бухимдал төрүүлсэн, нийтийн алба хаагчдыг авлигач, 60 тэрбумыхан гэсэн ерөнхий нэрээр тодорхойлсон он жилүүд байлаа.

Улс төрч бүр авлигатай тэмцэх ажлыг №1 гэж тодотгон түүнтэй тэмцэхээ лоозогнож, байгаа хэдий ч Монгол Улсад хар тамхи, авлига хэмээх сөрөг үзэгдэл газар авч байгааг доорх тоон үзүүлэлтээс харж болно. Тэмцээд байгаа хэрнээ эерэг хандлага илрэхгүй байгаа 2 асуудал нь нийгмийн хор аюул ихтэй, улс үндэстнийг мөхөөдөг аюултай тул жишин ярих болно. Өнөөдөр яригдаж байгаа тоо бол бүртгэгдсэн хэргийн тоо, илрээгүй, нуугдмал хэргийн статистик мэдээлэл ямар түвшинд байгааг таах, тооцоолох

боломжгүй.

Сүүлийн 5 жилийн дотор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 617 бүртгэгдэж, 1337 хүн холбогдон шалгагдсан, албан тушаалтнаас албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн гэмт хэргийн талаар 3518 гомдол, мэдээлэл иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн 1823 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3077 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 553 хэргийг шүүхэд шилжүүлэх санал гаргаж 1079 хэргийг хаах санал прокурорт гаргасан. Шүүхэд шилжүүлсэн хэргээс 229 хүнд холбогдох 216 хэрэг шийдвэрлэгджээ.

Олон тооны хэрэг хэрэгсэхгүй болж цагаандаж байгаа үндэслэл нь 2006, 2009, 2015 онуудад батлагдсан Өршөөл үзүүлэх тухай хууль, 2015 оны 08 дугаар сарын 07-ний өдөр батлагдсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, 2008, 2009, 2012, 2014 онуудад батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2015 онд батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Эдгээр хуулийн зарим тодорхойлолт, нэр томъёо оновчтой бус, олон зохицуулалт хийдэлтэй, хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх боломжгүй, олон салаа утга агуулгатай байдал, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлага хөнгөн, хөөн хэлэлцах хугацаа хэт богино байгаа нь шууд нөлөөлсөн гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн хийдэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд байгаа олон хийдэл, хуулийг нэг мөр ойлгох нэгдмэл ойлголт алдагдсан, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын боловсон хүчний нөөц хангалтгүй байдал мөрдөн шалгах

ажиллагаанд сөргөөр нөлөөлж гэмт этгээдүүд зэм хүлээхгүй байгаа өнөөгийн бодит дүр төрх нийгэмд бухимдал төрүүлж, олон нийтийн төрд итгэх итгэл буурсаар байна. Өнөөдөр бид энэ үйл явцын ирээдүйн хор уршгийг яагаад урьдчилан тооцохгүй байна вэ?

Нийгмийн толь болох сэтгүүл зүйн салбарт зарим нэг сэтгүүлч нар хаалтын гэрээ гэх нэртэй өвчин тусаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дүрд хувирч, нийгмийн эмч болсон шүүх засаглал ялзарч, өвчнийг анагаагч эмч нар бизнес эрхлэгч болж хувирлаа. Энэ бүхний буруутан нь НАМ төвтэй улс төрийн тогтолцоо, хэтийдсэн Ардчилал буюу ялагч бүхнийг авдаг тогтолцооны гажгаар тайлбарлагдана. Эрх мэдэл олж авах, эрх мэдлээ хадгалах гэсэн аминчхан үзэлтэй хүмүүс сонгуульд ашиглах мөнгө, хөрөнгө бий болгох ажилдаа нийтийн албан тушаалтан нарыг татан оролцуулж намын санхүүжилт нэрээр, хандив нэрээр авлига нэхдэг буруу жишиг гэмт хэргийн шалтгаан болсон байхыг үгүйсгэхгүй.

Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь гаалийн газрын ганцхан гарц дээр 30 хоног хяналт тогтооход 60 тонн даацтай машинд ачсан цахилгаан бараа нэг айлын хэрэгцээний аяга таваг болж, суудлын авто машинд ачсан 1500 ширхэг гар утас хоосон машинаар тоологдож, татвар төлөгдөөгүй, гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй барааг гаалийн улсын байцаагч нар алба хаагчдын гарцаар зөөвөрлөж, авлига аваад ажлаа зохих ёсоор хийхээс татгалзсан хүмүүс үйлдэл дээрээ баригдсан даруйдаа халаасан дахь мөнгөөрөө бороо оруулж, эрх мэдэл танилгүй иргэд 14 хоногоор бараагаа шаглуулж, аргаа бараад авлига өгдөг, танил талтай хүмүүсийн бараа гэрлийн хурдаар нэвтэрнэ. Тухайн гэмт үйлдлийг газар дээр нь илрүүлээд мөрдөн шалгах

ажиллагаа явуулж байхад маргааш өдөр нь томилогдон ажиллаж байгаа этгээд үйлчилгээ авч байгаа иргэнээс хахууль аваад, мөрдөгчийн байгаа газрыг зааж тойрч явахыг зөвлөж байгаа нь бэхжүүлэгдсэн баримтаас харж болно.

Эрүүгийн хариуцлага хүлээсэн хэдхэн хүн нь хөнгөн ял шийтгэл хүлээгээд хуулийн дагуу ажлаа хийсэн төрийн алба хаагч нарын нэр төрд халдах, гутаан доромжлох биед нь халдахыг завдана. Нийтийн албанд ял шийтгэгдсэн этгээдүүд дахин томилогдоод байгаа асуудал өнөөдөр бидний ярьж байгаа бухимдалд хүч нэмсээр байна.

Хууль сахиулах чиг үүргийг ял шийтгүүлсэн хүмүүс гүйцэтгэж, тангарагтаа үнэнч байх амлалтаа зөрчсөн, улс үндэстнийхээ эрх ашгийг умартаж хувийн эрх ашгаа тэргүүндээ тавьсан хүмүүс хүний эрх ярьж, өмөөрөгчийн дүрд хувирч, бусдын өмнөөс ярих боллоо. Энэ бүхний үр дүн гэмт этгээдийг ял завшуулах, хууль бус үйлдлийг дэмжих, хөгжин цэцэглүүлж хувийн эрх ашигтаа баригдсан хүмүүс Монгол Улсын тусгаар тогтнол, монгол хүний эрүүл мэндээр дэнчин тавьж төрөөс, төсвөөс хөрөнгөжсөөр байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт **найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял** шийтгэхээр хуульчилсан бол 18.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол **таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял**, мөн зүйлийн 3 дахь хэсэгт

“Энэ гэмт хэргийг соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял” оногдуулахаар хуульчилсан.

Мөн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн 24.1 дүгээр зүйлд Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн “Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилсан, сонгох санкц нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Хүнийг хордуулсан этгээд хөнгөн ял шийтгэл хүлээх, зүйлчиллийн маргаан өрнүүлэх боломж үүсэж байгаа нь энэхүү жишгээр илрэн гарна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн иргэний учруулсан хохирол, албан тушаалтан албан тушаалаа ашиглан үйлдсэн гэмт хэргийн хохирол, нийгмийн хор аюул ижил байхад оногдуулах ял нь ялгамжтай байна. Иймд Эрүүгийн хуулийн хариуцлагын хэм хэмжээг эргэн харж Эрүүгийн хуулийн зорилгод нийцүүлэх шаардлага тулгараад байна.

Энэ бүхнийг ярихаар ажлаа хийж чадахгүй шалтаг хайлаа, эрх мэдэлд дурлагсад, матрын нулимс унагалаа, батлагдсан хуулийг шүүмжлэхгүй хэрэгжүүл гэсэн шаардлага тавьж бичдэг. Энэ бүхэн иргэдийн итгэлийг үгүй хийж байгаа юм.

Дүгнэлт. Аливаа зүйлийн мөн чанарыг харж дүгнэж байх нь зайлшгүй, гэтэл өнөөдөр бид уран цэцэн үгэнд итгэдэг, харагдах байдалд итгэдэг. Цалингаас суутгаж байгаа татвараа хараад би ямар олигтойхон татвар төлөх биш гэж итгэнэ, гэтэл танаас ус рашаан ашигласан, хотын иргэний татвар, НӨАТ гэх мэтээр алхам тутамдаа татвар төлж байгаагаа мэддэггүй. НӨАТ бол бүртгэл, хяналтын систем байхаар бүтээгдсэн болохоос шууд татвар биш шүү дээ.

Баялаг бүтээгч нараа дэмжиж байна гээд өршөөл, уучлал үзүүлдэг. Нөгөө баялаг бүтээгч нь бараа бүтээгдэхүүнээ зарах үедээ татвараа тооцоож өртөг тодорхойлоогүй, татвараа хасаад арилжаа хийсэн гэж бодож байна уу. Татвараа шингээсэн өртгөөр борлуулалт хийчихээд байхад өршөөл, уучлал үзүүлээд байгаа үндэслэлийг зөвтгөх үндэслэлгүй асуудал. Томоохон хэргүүдийг Та бүхэн судлаад үз. Улс төрчдийн эрх ашиг шингэсэн, улс төрийн шийдэлүүд байх жишээтэй.

Авлига бүх нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлдөг байхад өгөгч, авагч 2-ын асуудал гэж ойлгоно, хахууль өгч байгаа нэгнийг хараад, авлига өгчихөөд баярлаад байгаа асуудал.

Утаатай тэмцэнэ гэсэн лоозон бүх нийтэд илээр 20 жил амь бөхтэй байж олон нийтийн албан тушаалтан л хөрөнгөжсөн, утаатай тэмцэх мөнгөөрөө шинэ жил тэмдэглэнэ, хөрөнгө худалдаад авна, гадаад улсад томилолт нэрээр зугаацна, хариуцлага тооцно гэхээр гэмт хэргийн

шинж оновчтой бус байгаа байдал нөлөөлнө, хууль тогтоогч нар гэмт хэргийн шинжийг ойлгомжтой болгоод шударгаар хариуцлага оногдуулаад ирэх цагт, бүрэн эрх, халдашгүй байдал гэсэн нөмрөгтэй, нам бүлэглэлийн эрх ашиг шингээсэн “Хамтын шийдвэр” нэртэй том хамгаалалтын бамбайг үгүй хийснээр иргэд төрд итгэх итгэл нэмэгдэж, Монгол хүн, Монгол гэр бүл аз жаргалтай амьдрах үндэс бүрдэнэ гэж үзнэ.

Энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг олон нийтэд таниулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, гэм буруутай этгээдүүдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах, нийтийн албан тушаалтнуудыг улс төрчдийн нөлөөллөөс ангид байх эрх зүйн орчин бий болгох, төрийн албан хаагч нарын чадавхийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч нар хуулийн

дагуу өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг, ёс зүйн болон мэргэжлийн алдааг гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдог механизм бүрдүүлэх, хуулийн нэг мөр ойлгож хэрэгжүүлэх чадавхид суралцуулах, хууль сахиулагч нарыг ур чадварыг нэмэгдүүлж, ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан тогтоосноор гэмт үйлдлийг бүрэн илрүүлэх, хариуцлага шударгаар оногдуулах, шударга ёс тогтох үндэс бүрдэнэ.

Гутранг хүн бэрхшээлийг даван туулах сонирхолгүй, шалтаг хайдаг, чин хүсэлтэй хүн гарц хайдаг гэсэн тайлбар ихээр хийх боллоо, эрүүгийн эрх зүйн харилцаа бол төсөөтэй хэрэглэгддэггүй, гарц хайж хүний эрхийг зөрчиж, бусдын эрхэд шууд халдах нь гарц биш. Тиймээс хийдэлтэй эрх зүйн хэм хэмжээг өөрчлөн оновчтой болгох ёстой гэсэн шаардлага тавьж байгааг тунгаан бодно буй за.



АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Илтгэгч: Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Р.Батнасан



Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Шинэчлэн баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэх мэт авлигын 11 төрлийн гэмт хэргийг хуульчилсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-т зааснаар дээрх гэмт хэрэгт болон авлигын гэмт хэргийг шалгах явцад илрүүлсэн “Мөнгө угаах” гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар хуульчилсан.

Мөн Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяалал

тогтоох тухай” А/67 дугаартай тушаалаар Авлигатай тэмцэх газрын шалгаж байгаа аймагт үйлдэгдсэн төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокурор, цагдаагийн удирдах ажилтан, Засгийн газраас томилогддог төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт холбогдох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харъяалуулсан гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэг, цагдаагийн байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьж ажиллаж байна.

2019 онд шийдвэрлэсэн хэргийн талаар цөөн статистик үзүүлэлт хэлье. Тус Прокурорын газар нь 2019 оны 12 дугаар сарын байдлаар албан тушаалын гэмт хэргийн шинжтэй нийт 371 гомдол мэдээлэл хүлээн авснаас 195 буюу 52.5 хувьд хэрэгт бүртгэлтийн хэрэг нээж, 149 буюу 40.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 27 буюу 7.2 хувийг харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ.

Хэрэг бүртгэлтийн 586, мөрдөн байцаалтын 145 хэрэгт хяналт тавьж ажилласнаас 41 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, 22 хэргийг хэрэгсэхгүй болгож, 310 хэргийг хааж шийдвэрлэн нийт хэргийн 50,3 хувийг шийдвэрлээд байна.

Шүүхэд шилжүүлсэн нийт 41 хэргийн 22 хэргийг шүүхээр шийдвэрлэж, одоо

19 хэрэг шүүхээр хянан хэлэлцэгдээгүй байна.

Авлигын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх явцад дараахь хүндрэл бэрхшээл тулгарч байна. Үүнд:

1. Нийгэмд нэр нөлөө бүхий этгээдүүдийн хэргийг шалгах явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан хуулийн байгууллага улс төрийн зорилгоор хилсээр шалгаж байгаа мэт ойлголтыг олон нийтэд төрүүлж, ард иргэд, нийгэмд хууль хяналтын байгууллага хэн нэгэн эрх мэдэл бүхий албан тушаалтны ашиг сонирхлын үүднээс буруугүй хүнийг буруутан болгож, ял шийтгэл оногдуулдаг мэтээр буруу ташаа мэдээлэл өгч байгаа нь хуульд заасан албаны чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй ажилтнуудыг хуулиар хүлээсэн албан үүрэгт ажлаа хэвийн явуулахад сөргөөр нөлөөлж байна. Хэдийгээр энэ асуудал нь хэвлэлийн эрх чөлөөний асуудал боловч Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд уг асуудлыг анхаарахгүй орхиж болохгүй. Нөгөө талаас гэмт хэрэг болох боломжгүй зүйлийг гэмт хэрэг мэтээр нийтэд мэдээлж, түүний үр дүнг өөрийнхөө төсөөллөөр шаардаж, АТГ болон прокурор, шүүхийн байгууллагуудыг буруутгах хандлага нийгэмд, ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслийн зарим ажилтнууд, улс төрчдийн дунд түгээмэл байна.

2. Авлигын гэмт хэргийн улмаас хууль бусаар олсон эд хөрөнгө олон янз, бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байдаг. Тухайлбал, банк, томоохон аж ахуй нэгж, орд газрын хувь эзэмших эрхийг бэлгэнд авах, түүнийгээ бусдын нэр дээр шилжүүлэх, уг олсон эрхээр дамжуулж ашиг олох, эсвэл хувьцаагаа бусдаар заруулах, офшор дансанд байршуулах, өөрийн гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн нэр дээр үл

хөдлөх эд хөрөнгө, хувьцаа, лиценз худалдан авах зэргээр авлигын хэлбэр дүрсийг хувиргах ажиллагаа ихэвчлэн зохион байгуулалттай явагддаг. Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор алдагдсан хөрөнгийг эргүүлэн авахад манай улсын хууль хяналтын байгууллагаас бусад орны хуулийн байгууллагатай мэдээлэл солилцох ажиллагаа шуурхай бус, тодруулбал хууль эрх зүйн орчин дутагдалтай байгаагаас шалтгаалж, алдагдсан эд хөрөнгийн байршлыг тогтоох боломж нөхцөл байхгүй, цаашлаад алдагдсан эд хөрөнгийг эргүүлэн авах боломжгүй нөхцөл байдалд хүргэж байна. Тиймээс эрх зүйн туслалцааны асуудлыг хөндөж тавихаас өмнө бусад орны хууль сахиулах байгууллагуудтай мэдээллийг шуурхай солилцож, мөрдөж байгаа гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг олж авах талаар хамтарч ажиллан үүний дагуу эрх зүйн туслалцаа харилцан туслалцаа үзүүлэх журмыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Иймд авлигын гэмт хэрэгт бусад орны хууль хяналтын байгууллагатай мэдээлэл солилцох, мэдээлэл авах, хамтарч ажиллах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь нэн түрүүнд шийдвэрлэх ажлуудын нэг болоод байна. Тухайлбал, ARIN-AP зэрэг хууль хяналтын байгууллагуудын бүс нутгийн болон дэлхий нийтийг хамарсан сүлжээний хүрээнд хамтын ажиллагааг улам өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

3. Авлигын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах асуудалд онцгой анхаарах ёстой. Авлигатай тэмцэхэд авлигачдыг шийтгэх нь гол асуудал мөн боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгүүлсэн ч олон хүн, улс хохирсон хэвээр үлдэж байна. Тийм учраас хохирол нөхөн төлүү лэх, хор уршгийг арилгах асуудлыг орхигдуулж

болохгүй юм. Иймд зарим тохиолдолд албан тушаалын хэрэгт төр, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцүүлэн, урьдчилан шийдүүлэх арга замыг эрэлхийлэх хэрэгтэй байна.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхээс хамтран ажиллах этгээдээр тогтоох үндэслэлийг хуульчилсан бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлига, албан тушаалын гэмт хэрэгт хамтран ажиллах этгээдээр тогтоох хууль зүйн боломж байхгүй байна. Үүнээс шалтгаалж, авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдийн эрхийг хэрхэн хамгаалах нь хууль зүйн хувьд ч тодорхойгүй, практик тогтоогүй байна. Авлигын гэмт хэргийн мэдээлэгчийг хамгаалах хууль эрх зүйн орчин бий болсноор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хөшүүрэг болох юм. Олон нийтийн анхаарал татсан, эдрээ төвөгтэй, олон үйлдэл хохирогчтой хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу тал бүрээс бүрэн гүйцэд шалгуулж, шуурхай шийдвэрлэхийн тулд хэрэгт зэрэгцэн хяналт тавих прокуроруудыг томилон ажиллуулж байгаа нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлэхэд тодорхой үр дүнгээ өгч байна. Мөн Эрүүгийн хуульд заасан мөрдөн шалгах хэд хэдэн байгууллагын харъяалан шалгах гэмт хэргийг шуурхай шалган шийдвэрлүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газар,

Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллагын хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулах зэргээр Прокурорын байгууллагаас авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд анхаарч удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн үр дүнгээ өгч байна.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь дан ганц Авлигатай тэмцэх газрын хэрэгжүүлэх үйл ажиллагаа биш бөгөөд үүнд хууль хяналтын бүх байгууллагууд харилцан уялдаа холбоотой ажиллах, хууль, журмыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зэрэг байгууллага бүрийн хүчин зүтгэл нөлөөлснөөр авлигатай тэмцэх үйл ажиллагаанд зохих үр дүнгээ өгөх юм.

Гэмт хэрэг үйлдэх арга нарийсч глобал шинжтэй шинжтэй, улс дамжсан хэлбэртэй болж байгаатай холбоотойгоор мөрдөгч, прокурорууд өөрсдийн үйл ажиллагаанд хандах хандлага, арга барилыг өөрчлөх шаардлага бий болсон. Нотлох баримт цуглуулах арга барилыг өөрчлөх. Үүнд:

- Мэдүүлэгт тулгуурлаж хэргийг шийдвэрлэх арга барилаас татгалзах
- Банк, санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад тулгуурлах
- мөнгөний урсгалыг хөөж шалгах,
- мөрдөгчийн магадлагааг түгээмэл хэрэглэх г.м

Зөвлөгөөнд оролцогч нарт амжилт хүсье. Баярлалаа.

АВЛИГЫН ЭСРЭГ КОНВЕНЦ БА ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

Илтгэгч: Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр



Авилгалын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын Конвенц:

11 дүгээр зүйл. Шүүх, прокурорын байгууллагад хамаарах арга хэмжээ

1.Шүүхийн хараат бус байдал, авилгалын эсрэг тэмцэл дэх түүний шийдвэрлэх үүргийг санан, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авилгалд автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Эдгээр арга хэмжээ нь шүүхийн байгууллагад ажиллагсдын үйл ажиллагааны дүрмийг багтааж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу авсантай адил үр нөлөөтэй арга хэмжээг шүүхийн тогтолцоонд хамрагддаггүй атлаа шүүхийн байгууллагатай адил хараат бус байдалтай прокурорын байгууллага бүхий оролцогч улсын прокурорын байгууллагад нэвтрүүлж, хэрэглэнэ.

Оршил. Хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийн тогтолцоо³ нь НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь баталгаа мөн. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх чадваргүй байдал нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдүүдэд хариуцлага тооцох, зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирол, хор уршгийг арилгахад ноцтой саад учруулж, нийгмийг авлигаас ангижруулах, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлнэ гэсэн хууль сахиулагч, прокурор, шүүгч бид бүхний зорилго хэрэгжих боломжгүй болж энэ талаар гаргасан бүхий л хүчин чармайлт үр дүнд хүрэхгүй. Шүүх эрх мэдлийн байгууллага дахь ашиг сонирхлын зөрчилтэй томилгоо, тушаал дэвшилт болон сахилга, хариуцлага тооцож үл чадах сул механизм нь шүүхийн салбарыг авлигатай тэмцэх чадваргүй болгож улмаар өөрөө ч авлигад өртөх шалтгаан болдгийг авлигын судалгаагаар мэргэшсэн олон улсын байгууллагууд тогтоосон байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар авлигын гэмт явдалтай амжилттай тэмцэхэд шударга үйл ажиллагаатай, өөрөө авлигаас бүрэн ангижирч чадсан шүүхийн үүрэг шийдвэрлэх нөлөөтэй болохыг уг конвенцаар хүлээн зөвшөөрч ийм шүүх эрх мэдлийн тогтолцоог бий болгохыг гишүүн улсуудад үүрэг болгосон. Хууль

3. Монгол Улсын Үндсэн хуульд прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчмыг шүүх эрх мэдлийн хэсэгт зааж өгсөн.

сахиулах үйл ажиллагааны хүрээнд хэрэгждэг дотоод ажиллагаануудаас гадна энэ чиглэлийн олон улсын хамтын ажиллагаа ч гишүүн улсуудын цэвэр тунгалаг, авлигатай тэмцэх хүсэл зориг, чадвар чадамж бүхий шүүх засаглалын дэмжлэггүйгээр хэрэгжих боломжгүй. Авлигын эсрэг конвенцын 11 дүгээр зүйлд гишүүн улс бүр шүүх эрх мэдэл дэх шударга байдлыг бэхжүүлэн авлигаас ангид байлгах талаар үр дүнтэй арга хэмжээ авах үүргийг хүлээлгэж зарим арга хэмжээг нэрлэн зааснаас гадна түүнийг хэрэгжүүлэх техник арга зүйн зөвлөмжид шүүхийг шударга, авлигаас ангид байж чадаж байгаа эсэхийг үнэлэх процедурыг тодорхой тогтоож өгсөн нь чухалд ач холбогдолтой болсон.

Зарим шүүгч авлигын гэмт хэрэг үйлдсэн болон олон нийтийн санал асуулгын журмаар ажлаа явуулдаг судалгааны байгууллагуудын сөрөг дүгнэлт, хэвлэл мэдээлэл, сошиал ертөнц дахь шүүхийн талаарх таагүй коментууд нь шүүх авлигад өртсөн байж болзошгүй талаарх тойм төсөөллийг бий болгож болох боловч шүүхийн авлигын талаар түүнтэй тэмцэх хөтөлбөр гаргах хэмжээний бүрэн дүүрэн мэдээллийг өгч чадахгүй юм. Харин шүүхийн авлига, шударга байдлын иж бүрэн үнэлгээг Авлигын эсрэг Конвенц, түүнийг хэрэгжүүлэх техникийн зөвлөмжид заасан аргачлал, схемын дагуу хийсний эцэст түүнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн авлигын эсрэг тэмцэлд манлайлан оролцох чадавхийг шүүхэд бий болгох нь өнөө үед монгол төрийн зорилго болж тавигдах ёстой гэж үзэж байна.

Энэхүү илтгэлд төрийн албанд нүүрэлсэн авлигын улмаас шүүх эрх мэдэлд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж үүссэн нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийх механизм,

даван туулах арга замуудыг олон улсын туршлага, түүнд тулгуурлан боловсруулсан Нэгдсэн Үндэстний байгууллагаас гаргасан удирдамж, чиглэлүүдийн хамтаар Та бүхэнд танилцуулан тайлбарлахыг оролдсон болно.

Тулгарч буй бэрхшээл. Шүүх авлигатай тэмцэхэд шийдвэрлэх үүрэг хүлээж нийгмийн хөгжил дэвшлийг урагшлуулахад чухал үүрэг гүйцэтгэж чадах боловч бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийн адил мөн чанараараа өөрөө авлигад өртөх аюул бодитой оршин буй. Шүүх эрх мэдлийн байгууллага буюу шүүх, прокурор нь авлигад өртвөл улс орон даяар явуулж буй авлигын эсрэг тэмцлийг сулруулан доройтуулаад зогсохгүй бүр авлигыг хөхүүлэн дэмжих хандлагыг нийгэмд бий болгож авлига цэцэглэн хөгжих үндэс суурь, түүнийг хамгаалах хүчин болж хувирдаг тул засаглалын бусад тогтолцоон дахь авлигаас хор аюулаар олон дахин их аюултай үзэгдэлд тооцогдохоос өөр аргагүй. Тэгсэн хэдий ч шүүх эрх мэдэлд авлига нүүрлэх нь дэлхийн олон улс оронд тохиолдсоор буйг олон улсын судалгааны байгууллагууд судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээрээ харуулсаар байна.⁴

Транспэрэнси Интернэшнл 2011 оны жилийн тайландаа дэлхий даяар судалгаанд хамрагдсан хүмүүсийн бараг тал нь (46 хувь) шүүх засаглалаа авлигажсан гэж үзсэн болохыг тусгажээ. Eurobarometer (2012) судалгаагаар европчуудын 1/3 нь өөрийн улсад шүүн таслах ажиллагаанд авлига өргөн тархсан гэж үзсэн (32 хувь), Бангладешт 88 хувь нь шүүхтэй харьцах явцад авлига өгөх болсон гэж

4. *Аффобарометр, 2010; Latinobarometer, 2010; Eurobarometer, 2011; TI, 2011; GCR, 2012: 303; Дэлхийн шударга ёсны төсөл, 2012*

мэдээлсэн⁵, Перугийн хүн амын 85 хувь нь шүүх засаглалдаа итгэх итгэл бага буюу үл итгэж байсан⁶, Афганистан, Боливи, Болгар, Камбож, Хорват, Этиоп, Гүрж, Молдав, Марокко, Перу, Украин зэрэг улсад хамгийн их авлигад өртсөн төрийн байгууллагаар 2010-2012 онуудад шүүх нь шалгарчээ⁷.

Шүүх дэх авлигын тархац, хэлбэр улс орны онцлогоос хамаараад өөр байгаа боловч давуу байдал амлаж эсвэл бий болгож хахууль авах, хясан боогдуулж төлөөс авах, албаны нэр нөлөөгөө худалдах, непотизм буюу ойр дотнын хүмүүсээ ивээн тэтгэхэд шүүхийг ашиглах хэлбэрүүд түгээмэл байна. Нигери улсад шүүхийн авлига нь хэргээс нотлох баримтыг устгах, шүүн таслах ажиллагааг хэн нэгэнд ашигтайгаар хурдасгах эсвэл удаашруулах аргаар үйлдэгдэх нь нийтлэг бол Йорданд гэр бүл, овог, омгийнхны зүгээс шүүхэд нөлөөлөх, давуу байдал олж авах магадлал өндөр байдаг нь судлаачдад ажиглагдсан байна. Шүүх авлигад өртөхөд улс төр, бизнесийн эсвэл гэмт хэргийн бүлэглэлүүдийн нөлөө, нийгмийн зүгээс үзүүлдэг дарамт шахалт, шүүхийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт сул, шүүгч, шүүхийн ажилтан, албан хаагчдын цалин хангамж бага, авлигаас сэргийлэх эрх зүйн баталгаат орчин бүрдээгүй, сахилга хариуцлагын тогтолцоо сул, нийгэм дэх ядуурал, улс төр нийгмийн тогтворгүй байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг талаар дээр дурдсан судалгааны байгууллагууд мөн мэдээлж байна.

Шүүхийн авлигын үр дагавар нь түүний хэлбэрүүдийн адил олон зүйл, төрөл байна. Гол аюул занал нь хууль дээдлэх ёс буюу хуулийн засаглал үгүйсгэгдэж байгаа явдал болно. Ноцтой гэмт хэрэгтнүүд ял

5. TI, 2012: 23

6. *Latinobarometer*, 2010

7. TI, 2012: 19

завшихаас гадна жирийн иргэд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулах боломжгүй болж буй. Шүүх дэх авлига нь зөвхөн шүүгчдийн нэр хүндийг унагаагаад зогсохгүй шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулснаар шүүхийн шударга байдалд ард олон эргэлзэхэд хүргэж шүүхийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох иргэн, захиргаа, эрүүгийн шүүн таслах ажиллагаагаар дамжин хэрэгждэг иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, зөрчигдсэн эрхийг сэргээх, төрийн байгууллагуудын эрх хэмжээний хязгаарлалт, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн хамгаалалт баталгаагүй болж иргэдийн шүүхээр хамгаалуулах эрх хөсөрдөхөд хүрнэ. Бүр илүү далайцаар авч үзвэл улс төрийн шударга өрсөлдөөн үгүй болж хүний үндсэн эрх, эрх чөлөөний баталгаа алдагдан засаглалын тэнцвэртэй байдал, харилцан хяналтад гажуудал үүсгэснээр төрд итгэх итгэлийг үгүй хийж нийгэмд шударга ёсны гажуудал бий болгон ардчиллын суурь тогтолцоонд хор хөнөөл учруулна. Харин эсрэгээрээ шударга шүүх нь шүүн таслах ажиллагаагаар дамжуулан нийгмийн бүх харилцаанд шударга ёсны баталгаа болон зогссоноороо авлигын эсрэг хүчтэй зэвсэг болж чадах юм.

Шийдлийг эрэлхийлэх нь. Эрлийг Авлигын эсрэг Конвенцын 11 дүгээр зүйлээс эхэлье. Энд авлигатай амжилттай тэмцэхэд шударга, авлигаас ангид шүүх эрх мэдлийн үүргийг тодотгохын зэрэгцээ гишүүн улсуудаас шүүхийн тогтолцоонд шударга байдлыг сайжруулах, авлигыг бууруулах талаар шат дараалсан арга хэмжээ авахыг шаардсан байна. Энэ арга хэмжээ нь шүүгч нараас гадна шүүхийн

бусад ажилтан, албан хаагчдад ч хамааралтай хэрэгжих ёстойг заасан байна. Мөн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад эрүүгийн шүүн таслах ажиллагаанд яллах үүрэгтэй оролцох прокурорын байгууллага нь шүүхээс тусдаа байгуулагдсан⁸ байдаг бол энэ шаардлага бас тавигдана гэжээ. Хэдийгээр шүүх, прокурор нь энэ арга хэмжээг хэрэгжүүлэх гол зорилтот хоёр байгууллага мөн боловч хоёр зүйлийг энд тэмдэглэх нь зүйтэй.

Нэгдүгээрт, 11 дүгээр зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд хэрэгжүүлэх аливаа арга хэмжээ үр дүн өгөх эсэх нь шүүх, прокуророос гадна өргөн хүрээний олон оролцогчдоос хамаарна. Хэрэв тусгай албад, цагдаа, өмгөөлөл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын хамтын ажиллагаа үгүйлэгдэх, эсвэл тэдгээр нь авлигад өртсөн бол авлигатай тэмцэх үр дүнтэй тогтолцоо цогц байдлаар ажиллаж чадахгүй.

Хоёрдугаарт, маргааныг шийдвэрлэх дээр дурдсан албан ёсны тогтолцооноос гадна арбитр, эвлэрүүлэн зуучлал зэрэг шүүхийн бусарга замаар хэрэг, маргааны нэлээд хэсэг шийдвэрлэгддэгийг анхаарч⁹ Конвенцад эдгээрийг нэрлэн дурьдаагүй ч ямар процедураар хэрэг, маргаан хянан шийдвэрлэгдэж байгаагаас үл хамааран тэнд шударга ёсыг тогтоож байх бүхий л нөхцөлийг бүрдүүлэх ёстой гэж ойлгоно. Тиймээс 11 дүгээр зүйлд тусгасан Конвенцийн шаардлагыг хэрэгжүүлэх явцад бий болох бодит үр дүн нь төрөл бүрийн байгууллага, институт,

8. Зарим улсад прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны бүтцэд багтаж байдаг бол зарим тохиолдолд манай улстай ижил шүүх эрх мэдлийн хүрээнд тусдаа бие даасан хараат бус байгууллага байхаар Үндсэн хуульдаа тусгасан. Мөн шүүхийн дотоод бүтцэд хамаардаг прокурортой улс гүрэн ч бий. Олон улсын эрүүгийн тусгай шүүхүүд, Ромын дүрмийн шүүх нь яллах, өмгөөлөх, шүүх департаментуудаас бүрэлдэж, шүүх департамент нь анхан болон давж заалдах танхимуудтай байдаг.

9. Ялангуяа хөгжиж буй олон орнуудад хүн амын 80 гаруй хувь нь шүүхэд хандахгүйгээр маргааныг шийдвэрлэхийг эрэлхийлж байдаг гэсэн судалгаа байна.

албан тушаалтан, тэр бүү хэл хувь хүмүүсийн үйл ажиллагаанаас хүртэл хамаарахаар харагдаж байна.

Шударга байдал ба авлигыг хэмжих. Конвенцийн 11 дүгээр зүйлд тусгагдсан шүүхийн шударга байдал, авлигаас ангид байх гэсэн шаардлагуудыг хангахын тулд бид эхлээд эдгээр ойлголтуудын агуулгыг тодорхойлох, хэмжээг хэмжих шаардлагатай болно. Эдгээр нь хоорондоо хамааралтай боловч ялгаатай ухагдахуун илэрхийлдэг болохыг анхаарах нь чухал. Конвенцын оролцогч улсууд авлигын тодорхойлолтын талаар үндсэндээ санал нэгдэж авлигад хамаарч болох үйлдэл, эс үйлдэхүйн талаар ойлголтын зөрүү гардаггүй боловч харин шүүхийн «шударга байдал» гэсэн нэр томъёог нэг мөр тодорхойлж чадаагүй хэвээр байна. Шүүгч, прокурорын хувьд “шударга бус” гэж тооцогдох зан үйлийг улс орнууд өөр, өөрөөр тодорхойлдог гадна шударга бус бүхэн авлигаас хамааралтай байдаггүй.

Шударга ёсыг юугаар хэмжих вэ? Энэхүү нийтлэлийг бичигчийн хувьд ч энэ асуултын бэлэн хариуг мэдэхгүй боловч нийгмийн аливаа үзэгдлийг хэмжих хэмжүүр нь олонхийн санал бөгөөд олонхийн шийдвэр зөв байдаг гэсэн афоризмоос эрлийг эхлүүлэх нь зүйтэй гэж үзнэ. Олон нийтийн шударга байдлын тухай ойлголтыг шүүх эрх мэдэлтэй хамгийн хүчтэй харьцаатай объектив нөхцөл байдал дээр төвлөрүүлснээр шүүхийн шударга байдал гэсэн ойлголтыг гарган авч болох талтай. Justitia хэмээх латин үг нь шударга ёс гэдэг утгыг илэрхийлдэг бөгөөд энэ ойлголт эрх зүйн харилцаанд өргөн хэрэглэгддэг ба эрх зүйд нийцүүлэн хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэх гэсэн утгатай үг.¹⁰

10. X. Кельзен “Шударга ёс гэж юу вэ?”

Шүүх засаглалын хувьд шударга байдал нь гаднын аливаа нөлөөллөөс ангид хараат бус байдлаар мөн нийгмийн хариуцлагатайгаар олон түмэнд шударга ёсны үйчилгээг хүргэх байдлаар илрэх учиртай.

Шүүхийн шударга байдлын шаардлагын асуудлыг түр хойш тавьж Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн 11 дүгээр зүйлд буй авлигаас ангид байх шаардлагын талаар ярилцъя. Юуны түрүүнд Конвенцын гишүүн улс өөрийн шүүхэд нүүрэлсэн авлигын хүрээ, түгсэн хэлбэр, авлигыг бий болгож буй шалтгаан нөхцөл, тухайлбал нөлөөнд автагдах, сахилга хариуцлагыг сулруулах байдлаар бүхэлдээ шүүх эрх мэдлийг доройтуулахад хүргэсэн хүчин зүйлүүдийг тодорхойлон мэдэхэд төвлөрөх ёстой. Олон улсын түвшинд шинжилгээ, судалгаа явуулдаг хуульч, судлаачдын тайлбарлаж байгаагаар авлигын гэмт хэргийн дотоод мөн чанар, онцлог тухайлбал далд, гэрчгүй үйлдэгддэг, хохирогчгүй, ул мөр үлддэггүй, халуун мөрөөр илрэх нь бараг үгүй, хожуу илэрч үйл баримтыг нөхөж сэргээн тогтооход хүрдэг зэргээс хамаараад түүнийг тоолох, хэмжих, судалгаа гаргах боломж тун хязгаарлагдмал юм байна. Гэвч улс орнууд эхний ээлжинд шүүн таслах ажиллагааг эрхэлдэг, оролцдог, сонирхдог албан тушаалтан, төрийн байгууллага, хувь хүн хуулийн этгээдүүдээс авсан асуумжийн тусламжтайгаар өөрийн хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллага дахь авлигын түвшин, хэлбэрийн талаар чиг баримжаа авч болохыг зөвлөсөн байна.

Тодорхой авлигын гэмт хэргийг мөрдөж хариуцлага оногдуулах гэж буй бус учраас ийм социологийн аргуудаар олж авсан мэдээлэл нь үнэнд ойр байж үр дүнгээ өгч тухайн улс орон дахь хууль, шүүхийн байгууллага дахь

авилгын талаар төсөөлөл бүрдүүлж чаддаг гэж үзсэн байна.

Илүү өргөн хүрээнд системийн шинжилгээ хийхэд хүрвэл USAID, ABA/CEELI, Европын зөвлөл, Вера Институт болон бусад төрийн бус байгууллага, гадаад улсуудын засгийн газар, түүнчлэн эрдэмтэн судлаачдын багуудаас боловсруулан гаргасан шүүх засаглалд хэрэгжиж буй бодлого, тогтсон практикийг зураглах цогц хэрэгслүүдийг ашиглах боломжтой. Трансперенси Интернэшнл байгууллагын Шүүхийг авлигаас ангид байлгах арга хэмжээний үр дүнг үнэлэх хяналтын хуудас¹¹ нь авлигаас сэргийлэх шалгуурууд болон харилцаанд оролцогч субъектүүдийн үүрэг хариуцлагад илүү анхаарсан оношилгооны арга хэрэгсэл бол Глобал Шударга байдлын байгууллагаас¹² боловсруулсан Шүүхийн хариуцлагатай байдлын шалгуур үзүүлэлтүүд нь шүүгч, шүүхийн ажилтан албан хаагчдад тооцох сахилга, хариуцлагын тогтолцоог сайжруулах асуудалд ач холбогдол өгсөн шинжтэй байна. Эдгээр үнэлгээ, оношилгооны хэрэгслүүд нь ерөнхийдөө шүүгчийг томилох, дэвшүүлэх тунгалаг орчин, шүүхийн шийдвэр гаргах ажиллагааг олонд нээлттэй болгох, сахилгын хариуцлага тооцох процессыг ил тод болгох, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх үр дүнтэй механизм, хөрөнгө орлогын мэдээллийг олонд хүртээлтэй байлгах тал дээр анхаарснаараа нийтлэг шинжтэй ажээ. Эдгээр үзүүлэлтүүд нь шүүх эрх мэдэл дэх шударга байдал, хариуцлагатай байдал гэсэн ойлголтын талаар дэлхий нийтээр нэгдмэл ойлголтод хүрэх шинжтэйг илтгэн харуулж буйгаас гадна НҮБ-ын харъяалах байгууллагуудын зүгээс дэмжин баталснаар нийтээр

11. *Diagnostic Checklist for Assessing Safeguards against Judicial Corruption*

12. *Global Integrity*

хүлээн зөвшөөрсөн стандарт болж хэвших хандлагатай байна. Энэ хүрээнд батлагдсан олон улсын бичиг баримтуудын нэг болох Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын суурь зарчмууд¹³ гэх баримт бичигт шүүгчийн албан тушаалын тогтвортой байдал, шүүгчийг томилох, дэвшүүлэх шударга тогтолцооны загварыг санал болгосон нь улс орнуудад өргөн хэрэглэгдэж эхэлсэн байхад хэд, хэдэн улсуудын дээд шүүхийн шүүгчид хамтран шүүгчийн мэргэжлийн хариуцлагын түвшнийг ахиулан тогтоож Банглогрын зарчмуудыг¹⁴ боловсруулан тунхагласан нь одоо ёс зүйт, шударга, чадварлаг шүүхийг эрмэлзэх тулгуур тодорхойлолт болон төлөвшлөө.

Мөн Шүүхийн төгөлдөршлийг тодорхойлох олон улсын шалгуур /ШТТООШ/¹⁵ гэх стандартыг шүүхийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг дээшлүүлэх зорилгоор чанарыг удирдлагыг хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоо болгон ашиглах нь түгээмэл боллоо. ШТТООШ нь шүүхийн ерөнхий гүйцэтгэлийг хянах, сайжруулах, тулж ажиллах шаардлагатай хэсгүүдийг тодорхойлоход туслах сайн аргачлал болох нь туршлагаар батлагдсан бөгөөд шүүхийн “шударга байдал”, “авлигаас ангид буй” гэх ойлголтыг загварчлахыг оролдсон анхны тохиолдолд тооцогдоно.

ШТТООШ нь шүүхийн мөн чанарыг илтгэсэн үнэт зүйлсүүд дээр тулгуурлан шүүхийн шударга, авлигагүй байдлын стандартыг бий болгож улмаар тэдгээрийг хэрэгжүүлэх шүүхийн 7 орчныг тодорхойлсноор үнэлгээний цогц сиситемийг бий болгосон. АНУ-ын мужуудын шүүхийн Үндэсний төв¹⁶, Олон улсын шүүхийн консорциум

(ICCE)¹⁷ зэрэг шүүх дэх шударга байдал, авлигаас ангид байлгах асуудалд идэвхтэй оролцохыг хүсч байгаа байгуулагуудаас стандартыг илүү тодорхой болгох шаардлагын үүднээс Шударга ба авлигагүй байдлын хяналтын хуудсыг нэмж боловсруулсан болно.

Энэ хуудас нь шүүхийн шударга, авлигаас ангид байдлын шалгууруудыг гадаад болон дотоод хүчин зүйлүүдэд хувааж гадаад хүчин зүйлээ тухайн улсын төрийн дэглэмээс хамааран шүүх засаглалд бий болгож буй баталгааг 5 үзүүлэлтээр илэрхийлж харин дотоод хүчин зүйлүүд нь шүүх эрх мэдлийн тулгуур үнэт зүйлс, шүүхийн хараат бус байдал, шүүгчийн ёс зүй, авлигаас ангид байх, шүүхийн сургалт-хөгжил, олон нийтийн итгэл гэсэн 6 орчноос бүрдэж орчин тус бүр хэд, хэдэн үзүүлэлтээр хэмжигдэхээр зохиогдсон байна.

Төрийн 5 баталгаа:

1. Шүүхийн хараат бус байдлын Үндсэн хуулийн баталгааг хэрхэн бүрдүүлсэн¹⁸
2. Шүүгчээр томилох, шүүгчийг дэвшүүлэх процессыг ил тод бөгөөд мерит зарчимд тулгуурлаж тогтоосон эсэх¹⁹
3. Албан тушаалын тогтвортой байдал, шүүгчийн цалин хангамж, халдашгүй дархан байдлын баталгааг Үндсэн хуулиар бий болгосон эсэх²⁰

17. *International Consortium of Court Excellence*

18. НҮБ-ын АЭК-ын 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх үнэлгээний шалгуур ба гарын авлага, UNODC, 2015, 1 дүгээр бүлэг: 4-5 хуудас; Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын зарчмууд 1985 (UNBP) No.1

19. *The United Nations Convention Against Corruption Implementation Guide and Evaluative Framework (IGEF) for Article 11, UNODC, 2015, 11 дүгээр зүйл 2 дугаар бүлэг: хуудас 25-28; UNBP No.10 & 13*

20. IGEF 11 дүгээр зүйл 2 дугаар бүлэг: хуудас 29-31 30, 32 & 36; UNBP No. 11, 12 & 16; Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалогрын зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замууд. *Judicial Integrity Group. 2010 (MEIBP) хуудас 11 9.1-9.5 дугаар зүйл*

13. *The United Nations Basic Principles on Independence of the Judiciary*

14. *The Bangalore Principles (2002)*

15. *International Framework for Court Excellence (IFCE)*

16. *National Center for State Courts, USA*

4. Шүүгчид сахилгын хариуцлага тооцох, албан тушаалаас нь чөлөөлөх шударга процессыг бий болгож чадсан эсэх²¹
5. Шүүхэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хангалттай төсөв хуваарилж буй эсэх²² зэргийг багтаажээ.

Үнэт зүйлс:

6. “Бангалор”-ын зарчмаар тунхагласан хараат бус, хөндлөнгийн байр суурь, үнэнч шударга, зарчимч байдал, тэгш хандлага, мэргэжлийн чадварлаг байх, хичээнгүйлэн зүтгэх зарчмуудыг шүүхийн тулгын чулуу болгон авч үзсэн байх.²³
7. Шүүгчийн дээр өгүүлсэн мэргэжлийн үнэт зүйлсээс гадна ёс суртахууны үнэт зүйлсийг бий болгон ёс зүйн дүрэм, журамд тусган чанд мөрдүүлсэн байх.²⁴

Шүүхийн хараат бус байдал:

8. Шүүгч төрийн бусад салаа эрх мэдлээс, улс төрөөс, бизнесийн сектор, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, хувь хүмүүсээс, мөн бусад шүүгч нарын нөлөөнд орохгүйгээр чөлөөтэй байж ил тод, хөндлөнгийн байр сууринаас бүрэн эрхээ хэрэгжүүлж чаддаг байх²⁵
9. Шүүн таслах ажиллагаа олон

21. Энэ шаардлагын биелэлтийг шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх хөндлөнгийн хараат бус байгууллагыг бий болгож чадсан эсэхээр хэмжигдэнэ. IGEF 11 дүгээр зүйл 2 дугаар бүлэг: хуудас 34-36; UNBP No. 17-20

22. АЭК-ийн 11 дүгээр зүйлд IGEF Art 11 Ch 2: pp 38-39; UNBP No. 5

23. Strengthening basic principles of judicial conduct. ECOSOC 2006/23 Annex Bangalore Principles of Judicial Conduct (BPJC)

24. IGEF Art 11 Ch 1: pp 14-18; BPJC: Value Integrity: 3.1 and 3.2; Value Propriety: 4.1-4.3; MEIBP p.6 Items 1.1-1.3 & 2.1-2.2

25. Шүүгч нар засаглалын бусад эрх мэдэл, тэдгээрийн төлөөний байгууллага, банк-санхүү, бизнесийн төлөөлөл, хувь хүмүүс, албан тушаалтнуудын эрхшээлээс ямагт ангид байж албан үүрэг, хэрэг маргааны нөхцөл байдал шаардсан тохиолдолд тэдгээрийн эсрэг шийдвэр гаргахдаа юунаас ч болгоомжилж эмээдэггүй байх ёстой. Ишлэл IGEF Art 11 Ch 2:pp 40-41; BPJC: Value Independence: 1.1,1.2; Impartiality: 2.2; UNBP No. 2 & 4

нийтэд ямагт нээлттэй байж шүүх хөндлөнгийн байр суурийг баримтлан талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэйгээр шударгаар хандаж байх ёстой.²⁶

Шүүхийн сахилгын стандарт:

10. Шүүгчийн биеэ авч явах болон зохист байдлын хэм хэмжээнүүдийг цогцоор тогтоож мөрдүүлсэн²⁷
11. Шүүгч бүрийн хувийн ашиг сонирхлын бүртгэл хөтлөгддөг, шүүгч ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах асуудлыг журамласан²⁸
12. Шүүгчид итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ албан тушаалынхаа нэр хүнд, шүүхийн хөндлөнгийн байр суурь, хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхөөргүй байдлаар эдлэх боломж бүрдсэн.²⁹
13. Шүүгч, шүүхийн ажилтан, албан хаагчдад холбогдуулан гаргасан гомдлыг шударга, шуурхай шалгаж тогтоох, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлсэн.³⁰

Авлигаас ангид байлгах талаар:

14. Шүүгчийн ажлын ачаалал,

26. IGEF Art 11 Ch 2: pp 53-56; BPJC: Value Independence: 1.3; Impartiality: 2.1, 2.2 and 2.5; and UNBP: No. 6

27. Дээр өгүүлсэн ёс суртахууны үнэт зүйлс, тэдгээрийг зарчим болгон тусгасан хэм хэмжээ нь шүүгчийн ухамсар, үзэл бодол, оюун ухааны төлөвшилтэй илүү холбоотой дотоод хүчин зүйлийн хамааралтай бол энд гарч буй хэм хэмжээ нь шүүгчийн ёс зүйн гадаад илрэл, түүний хувьд өөрөө хүлээн зөвшөөрч буй эсэхээс үл хамааран заавал сахиж мөрдөх, хариуцлагын үр дагавар бүхий сахилгын дүрэм юм. Хэрвээ энэ хоёр хэм хэмжээг нэгтгэж байгаа бол зөрчилд хүлээлгэх хариуцлагын талаар зөвлөмжийн болон албадлагын аль нь болохыг зааглан тогтоож өгөх ёстой. IGEF Art 11 Ch 1: 21-22; UNBP No. 2; UNBP No. 4.1-4.16; MEIBP p.6 Item 1.3

28. Ашиг сонирхлын бүртгэл нь байнга шинэчлэгдэж жилд хамгийн баадаа нэг удаа хянагдаж баталгааждаг байх ёстой. IGEF Art 11 Ch 1: pp 20-22 and BPJC: Value Impartiality: 2.3 and 2.5; Value Propriety: 4.4, 4.7, 4.8 and 4.14; UNBP No. 4.7-4.9

29. IGEF Art 11 Ch 2: pp 37-38; BPJC: Value Propriety: 4.6

30. IGEF Art 11 Ch 2: pp 31-33; MEIBP p.8 Items 4.4-4.5

мэргэшсэн байдлыг харгалзан хэрэг хуваарилах хүнээс үл хамаарах санамсаргүй, нээлттэй, шударга механизмийг бүрдүүлсэн эсэх³¹

15. Шүүхийн захиргааны удирдлага, хэргийн хөдөлгөөний менежмент, дуу, дүрс бичлэг болон бусад бүртгэлийн системийг аль болох авлигын эрсдэлийг багасгах, арилгахад чиглүүлсэн³²
16. Шүүхийн шийдвэр, түүний үндэслэл, шүүхийн тайлан, мэдээ, судалгааны үр дүнг нийтлэх байдлаар шүүхийн шийдвэр гаргах процесс шударга, хараат бус явагдаж байгааг илтгэж олон нийтийн итгэлийг бататгах³³

Шүүхийн сургалт-хөгжил:

17. Шүүгч нар ёс зүйн чиг баримжаа олгох болон мэргэжлийн ур чадварын түвшин ахиулах сургалтад байнга хамрагдаж буй эсэх, тэдэнд хүссэн үедээ энэ талаар удирдамж, зөвлөгөө авах боломж бий эсэх³⁴

Олон нийтийн итгэлийг олж авах:

18. Шүүхийн хүний нөөц, байр, тоног төхөөрөмж, тэмдэгтийн хураамж бусад төлбөрүүд нь иргэн, хуулийн этгээдэд шүүхийн үйлчилгээг жигд, тэгш хүргэхэд чиглэсэн эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болон хэлний саадтай иргэдэд хүртээмжтэй эсэхэд шүүгч нар хяналт тавьж чаддаг³⁵
19. Шүүх нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж тэдгээрийг шүүхийн хараат бус, шударга үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, итгэлийг нэмэгдүүлэх

чухал арга хэрэгсэл гэж үздэг.³⁶

20. Шүүх хэргийн оролцогчид болон иргэд, хуулийн этгээдээс шүүхийн талаархи санал, хүсэлтийг байнга хүлээн авч энэ талаар хариу өгдөг.³⁷

Авлигын эсрэг конвенц нь авлигагүй шүүхийг бий болгохыг гишүүн улсуудад үүрэг болгохын зэрэгцээ дээр өгүүлсэн стандартуудыг заавал дагаж мөрдөхийг шахдаггүй хэдий боловч өөр, өөр эрх зүйн соёл уламжлал, тогтолцоотой олон улс орнуудад хүлээн зөвшөөрөгдөж өргөнөөр хэрэглэгдэх болсон нь эрх зүйн нийтлэг хэм хэмжээний түвшинд хүрч эрх зүйн шинэчлэлийг эрмэлзэгчдийн хувьд үйл ажиллагааныхаа загвар, чиг баримжаа болон ашиглагдсаар байна.

АЭК-ын 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх нь: Шүүх шударга байгаа эсэх, авлигаас ангид байгаа эсэхийг үнэлэхээс түүнийг шударга, авлигагүй болгох, тийм байлгах нь илүү ухаан, хүн хүч, цаг хугацаа ба төсөв шаардсан үйл ажиллагаа болох н хэнд ч ойлгомжтой билээ. Социалист чиг баримжаатай байгаад системийн задралын дараа хөгжлийн чиг баримжаагаа өөрчилсөн улсуудад олон улсын байгууллагуудаас төрийн албыг ялангуяа шүүхийг авлигаас ангижруулах зорилгоор 1990-ээд онд хэрэгжүүлсэн “хуулийн засаглал”, “хууль дээдлэх ёс” гэсэн томъёоллын дор явуулсан эрх зүйн кампаничилсан шинэчлэлийн үр дүн тийм ч сайнгүй байсныг тухайн төслийг санхүүжүүлсэн доноруудын тайланд тэмдэглэсэн үлджээ. Энэ төслийн нэгэн багийн шинжээч Хаммергрэн тайландаа бичихдээ “...шүүхэд тархсан авлигын хүрээ, хэлбэр нуугдмал, илчлэх нийгмийн хүсэл зориг дутмаг, далд нуугдсан улс төрийн ашиг сонирхол зэрэг нь бидний үйл ажиллагаанд байнга саад

31. IGEF Art 11 Ch 2: pp 45-46; UNBP No. 14; MEIBP p.7 Items 3.1-3.3
 32. IGEF Art 11 Ch 2: pp 44-49; MEIBP p.7 Items 4.1-4.2
 33. IGEF Art 11 Ch 2: pp 56-58
 34. IGEF Art 11 Ch 1: pp 16—20; UNBP No. 6.3-6.4; MEIBP p.10 Items 7.1-7.7
 35. IGEF Art 11 Ch 2: pp 49-53; UNBP No. 5; UNBP No. 5.1-5.5; MEIBP pp.8-9 Items 5.1, 6.1, 6.3-6.4
 36. IGEF Art 11 Ch 2: pp 57-58; MEIBP p.9 Items 6.2 & 6.6
 37. IGEF Art 11 Ch 2: pp 56-57

бэрхшээл учруулж байснаас эрх зүйн шинэчлэлийг манлайлагч үндэсний боловсон хүчнүүд хүртэл шүүхэд суурь шинэчлэл хийхээс болгоомжлон зайлсхийсэн нь эцэстээ шүүх гадна төрхөө өөрчилсөн боловч дотоод мөн чанраараа хуучин тогтолцоогоо хадгалсан хэвээр үлдсэн юм”³⁸ гэжээ.

Шүүгчийн цалинг нэмэх болон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх зэрэг нь нийгэмд хангалттай дуулиан шуугиан тарьдаг атлаа авлигыг нэг мөр шийдэх арга замууд болж чаддаггүй нь бусад улсын туршлагаас харагдсан талаар дүгнэлтийг мөн энэ шинжээчийн тайлангаас олж үзэж болно. Мөн “мэс заслын” аргаар шүүхийг шинэчлэх гэж оролдвол урьдчилан тооцоогүй, хор уршиг ихтэй үр дагавар үүсэж ч болохыг 1990-ээд онд Египтэд хэрэгжүүлсэн шүүхийн шинэчлэлийн үр дүнд нийгмийн зөвхөн тодорхой хэсэг, бүлэг хүмүүст үйлчилдэг шүүхтэй болсноос сургамж авч болно.

Энэ бүхнийг эс харгалзан шүүхийг авлигаас ангижруулах, шударга байлгах нь бүтэшгүй зүйл, хүршгүй зорилго биш бөгөөд аль ч улсын өнөөгийн нийгмийн захиалга, шаардлага болоод байгааг шүүгчид ч өөрсдөө хүлээн зөвшөөрнө. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлсны үндсэн дээр шүүх эрх мэдэл оршин тогтнох суурь болсон зарчмуудыг ганхуулахгүйгээр авлигын эсрэг шат дараалан хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүн авчрах нь дамжиггүй. Энэ чиглэлээр хийх ажил нь гишүүн улс бүрийн хувь тэдгээрийн төрийн байгуулал, засаглалын хэлбэр, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, эрх зүйн соёл, тогтолцооноос хамаараад өөр, өөр байх боловч дараахь гурван зүйлд төвлөрөх ёстой нь хүлээн зөвшөөрөгдөөд байгаа болно. Энэ бол

38. Hammergren, Lynn. 2000. “Can Law and Institutions Give Voice to the Poor?” PREM News. June 12. World Bank, Washington, D.C.

эрх зүйн орчныг өөрчлөн боловсронгуй болгох, шүүхийг институцийн хувьд бэхжүүлэх, шүүхийн хараат бус байдал, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд байх ёстой юм. Үүнийг төрийн удирдлага, нийгмийн оролцоо, шүүгчдийн хамтын ажиллагаанд тулгуурлан аль ч хэлбэрээр эхлүүлж болно.

Шинэ эсвэл шинэчлэгдсэн эрх зүйн орчныг бий болгох: Авлигын эсрэг тэмцэл нь эрх зүйн тааламжтай орчинд л амжилт олох бөгөөд юуны өмнө шүүгчдийг томилох, дэвшүүлэх зохицуулалт болон сахилгын дүрмийг эхэлж шинэчлэх ёстой. Дараагийн ээлжинд шүүгчийн халдашгүй байдлын тухай хууль тогтоомжийг сайжруулж болох ба энэ зохицуулалт нь шүүгчийг улс төрийн зорилгоор буруутгаж яллахаас хамгаалах байдлаар хараат бус байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой боловч тодорхой цаг хугацаа, орон зайгаар хязгаарлагдсан дархлаа³⁹ гэдгийг хуульд тусгана. Мөн ашиг сонирхлын зөрчлийн удирдлага, хөрөнгө орлогын мэдүүлэх шаардлага болон ёс зүйн дүрмүүд зэрэг төрийн албан хаагчдад нийтлэг үйлчилдэг дүрмүүдийг шүүгч, шүүхийн ажилтан албан хаагчдын хувьд шинэчлэхийг зөвлөжээ.

Шүүхийг институцийн хувьд бэхжүүлэх: Шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох нь олон нийтэд авлигадах сэдэл төрөх, шүүгч, ажилтнуудын зүгээс авлига авах боломжийг хоёуланг нь бууруулах магадлалтай. Шүүхийг бэхжүүлэх замаар авлигаас сэргийлэх арга хэмжээнд дараахь үйл ажиллагаануудыг хамруулан ойлгоно. Үүнд:

- мэдээлэл, харилцааны технологийн

39. *Functional immunity* буюу *ratione materiae* нь тухайн этгээдийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой дархлаа тул *personal immunity* буюу *ratione personae* болох албан тушаалын дархлаанаас явцуу хүрээнд хэрэгждээ.

дэвшлийг хэргийн хөдөлгөөн болон бусад бүртгэлийн системд нэвтрүүлэх;

- шүүхийн шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд тайлбартай хүргэж түгээх;
- шүүгчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх;
- шүүгчдийн эрх зүйн боловсролыг авлигыг үл тэвчих болон бусад чиглэлээр дээшлүүлэх;
- шүүгч, шүүхийн албан хаагчдын дунд мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг зохион байгуулж байх;
- Хуульчдын холбоо, Шүүгчдийн холбоо зэрэг мэргэжлийн эвсэл, холбоодын үйл ажиллагааг дэмжих;
- Шүүх эрх мэдэлд багтаж буй албадуудын ёс зүй, биеэ авч явах дүрмүүдийг бий болгож сахиулах;
- Иргэдэд эрхийг нь тайлбарлан таниулах, шүүн таслах ажиллагаа болон ерөнхий эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэх;
- Авлигын үйлдлийг мэдээлэх шуурхай механизмийг бий болгох зэрэг нь олон улсын туршлагад түгээмэл байна.

Аливаа арга хэмжээг жижиг гэж үл ойшоох, үл итгэх байдлаар хандах нь учир дутагдалтай, үр дүнг урьдчилан хэлэх аргагүй болох нь олон улсын туршлагаас харагдсан. Зарим энгийн наад захын гэж үзсэн нөлөөллийн арга хэрэгслүүд онцгой үр дүнтэй байж болох нь Нигер улс 2007 онд өндөр өртөгтэй шүүхийн радикал шинэчлэлийн нарийн төвөгтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ажиглагдсан юм. Гомдол хүлээн авах, шийдвэрлэх тогтолцоог үүсгэхдээ санал хүсэлт хүлээн авах хайрцгуудыг шүүхүүд дээр олноор байршуулж гомдлыг хянан шийдвэрлэх хороодын

гишүүдэд иргэдийн төлөөллийг оруулсан нь энэ том хөтөлбөрийн хамгийн амжилттай хэрэгжсэн, авлигыг бууруулахад хүчтэй нөлөөлсөн арга хэмжээ болж шалгарснаар нутгийн иргэдийн сэтгэхүй, ёс заншил, шашин шүтлэг, үнэт зүйлсийн баримжаа аль нэгэн арга хэрэгсэл амжилттай хэрэгжихэд чухал түлхэц өгдөг нь тодорхой болсон.

Гэтэл шууд үр дүнгээ өгөх хүлээлттэй байсан нийтлэг хоёр арга хэмжээ тухайлбал, шүүхийн хүний нөөцийг чадваржуулах болон цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн төслүүд нь хэд, хэдэн улсад үр дүнгээ өгөөгүй эсвэл сөрөг үр дагавар авчирсэн тохиолдлууд гарчээ. Нигер болон Гана улсуудад шүүх хуралдааныг шуурхай явуулах зорилгоор нарийн бичгийн дарга нарын бичиг баримт шивэх хурдыг түргэсгэх эрчимтэй курсуудыг хандивлагч орнуудын санхүүжилтээр хичээллүүлж зохих үр дүнд хүрсэн боловч цалин, хангамжийн асуудлыг хамтад нь шийдвэрлээгүйгээс ур чадвар эзэмшсэн тэдгээр ажилтнуудыг хуулийн фирм, төрийн бусад алба, бизнесын байгууллагад маш богино хугацаанд алдаж явуулсан байна. Энэ туршлага нь шүүгч, ажилтнуудын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэ түвшинд гаргах арга хэмжээг тэдгээрийг ажил, албан тушаалдаа үлдэх баталгааг заавал бий болгохтой хамт хэрэгжүүлснээр хүний нөөцийн ажиллах чадвар, ачаалал даах боломжийг нэмэгдүүлэх зорилгод нийцэх ёстойг нотолсон.⁴⁰

Шүүгчийн цалин, хангамж амьдрал, ахуйд нь хүрэлцээгүй байх нь авлигыг төрүүлэх маш том түлхэц болдог атлаа эргээд түүнийг өсгөн нэмэгдүүлсэн нь авлигыг устгах баталгаа тэр бүр болж чаддаггүй нь нэгэнт илэрхий болсон бөгөөд улс орнуудын туршлагаас

⁴⁰ Piron 2006

үзэхэд шүүгчийн цалин өндөр, ахуй хангамж, хөдөлмөрийн нөхцөл сайн байхад ч авлига цэцэглэн хөгжиж болдог байна. Авлига өгөх сонирхол нийгэмд зонхилж хэмжээ нь байнга өсөж байгаа үед түүнийг давсан цалин хөлс, хангамж эдлүүлэх боломжгүйгээс хойш авлига нь цалингийн өсөлтийг ашигт байдлаараа давамгайлаад байгаа харьцааг авлигыг эрсдэлжүүлэх байдлаар өөрчлөх боломжтой. Өөрөөр хэлбэл ямар ч эрсдэлгүй цалин, өндөр эрсдэл бүхий авлигын хооронд сонголт тодорхой байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

Шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр баталгаажуулах нь: Шүүхийн шийдвэрт улс төр, төрийн өндөр албан тушаалтан, бизнесийн бүлэглэл, хөрөнгө чинээтэй хүмүүс шүүгчийн томилгоо, албан тушаал дэвшихэд оролцох, өөрсдийн гэх хүмүүсийг тавих, хүссэн шийдвэрийг гаргасны төлөө шагнах, урамшууллын тогтолцоо бий болгох нь шүүхийн хараат бус байдлыг ихээр туйлдуулдаг билээ. Шүүхэд төсвийн эрх чөлөөг олгох, албан тушаалын тогтвортой байдлыг хангах, шүүгчийг томилох, дэвшүүлэх, түүнд сахилга, хариуцлага тооцох бие даасан тусдаа байгууллага байгуулах нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй болохыг хэн ч үгүйсгэхгүй. Гэвч энд бас тунг нь тааруулах, тэнцвэрийг хадгалах асуудал үргэлж тавигдсаар ирсэн. Хараат бус байдал нь шүүхийн шударга байдлыг өсгөхөд үйлчилж байна уу, эсвэл эсрэгээр саадгүй авлигажих боломж болж байна уу гэдэг нь улс оронд тогтсон улс төрийн манлайлал, ашиг сонирхол, үнэт зүйлсийн шинж чанараас ихээхэн хамааралтай. Жишээлбэл, Индонезид баталсан шүүхийн хараат бус байдлын талаарх

дагнасан хууль нь шүүхийг хяналтаас бүрэн гаргаж авлигыг шүүн таслах ажиллагаан дахь хэвийн үзэгдэл болтол гажуудсан байхад Латин Америкийн улс орнуудад шүүхэд тавих хяналтыг чангатган улмаар шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх хэмжээнд хамааруулснаар шүүх дэх хөндлөнгийн нөлөөлөл хэрээс хэтэрч шүүн таслах ажиллагаа нь гацаж зогсох хэмжээнд үйл ажиллагаа нь хямарсан юм. Шүүх нь шүүхийн шийдвэр, шүүн таслах ажиллагааны болон төсвийн тайлан мэдээ, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх замаар өөрийн үйл ажиллагааг олон нийтэд байнга танилцуулж байх нь шүүхийн өөрийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэхээс гадна улс төрийн шинжтэй олныг турхирсан гадны дайралт, давшилтаас сайн дархлаажуулалт болдгийг шүүхийн шинэчлэлийг ажиглагчид тэмдэглэсэн байна.

Шүүхийн шударга байдал, авлигаас ангид байх асуудлыг дэмжих АЭК-ын бусад заалтууд: АЭК нь шинэчлэл, өөрчлөлтийн хүрээг зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллагууд шүүх, прокурорын байгууллагаар тогтоосноор хүссэн үр дүнд хүрэхгүй байж болохыг хүлээн зөвшөөрч шүүхийн шударга байдлыг бэхжүүлэхэд 8 дугаар зүйлд заасан төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчийн мэдүүлэг гаргах, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах зохицуулалтыг төрийн бусад албан хаагчдад хэрэглэх, 10 дугаар зүйлд заасан төрийн албаны ил тод байдлыг хангах, 13 дугаар зүйлд заасан авлигатай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог хангах, шүүхийн шинэчлэл өөрчлөлтийн далайцыг нэмэгдүүлэхэд дотоодын ба гадаадын хандивлагчдыг татан оролцуулах нь амжилтын үндэс болно. Иргэний нийгмийн дэмжигчдэд хүний эрхийг

хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, судалгаа шинжилгээний байгууллагууд, их, дээд сургуулиуд, хувийн хэвшлийн байгууллагуудаас гадна хэвлэл, мэдээлэл, хуульчдаас бүрдэх холбоо, эвслүүд ч хамаарч энэ үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Тэдгээр нь судалгаа оношилгоо, төрийн бодлого, хууль тогтоомжийн боловсруулалт, сурталчилгаа, шүүхийн тодорхой шийдвэрт үнэлэлт дүгнэлт өгөх, стратегийн өмгөөлөл явуулах, шүүгч, ажилтнуудад сургалт зохион

байгуулах, олон нийтэд таниулан анхааруулах кампанит ажлыг зохион байгуулж болно.

Эцэст нь хэлэхэд шүүх нэг талаас тусдаа бие даасан эрх мэдэл боловч нөгөө талаас хуулийн байгууллагуудын тогтолцооны нэг хэсэг болж явдаг учраас үр дүнтэй шинэчлэл нь хуулийн бусад салбар байгууллагуудын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай учир тэдгээрийн тусламж дэмжлэг, хамтын ажиллагаагүйгээр бодитой үр дүн гаргах боломж тун хомс гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.



АВЛИГЫН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Илтгэгч: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр юу хийх ёстой, иргэд олон нийт, хэвлэл мэдээллийн салбартай холбоотой асуудлууд юу байна, ямар эрх зүйн шинэтгэлүүдийг хийгдэв, цаашид ямар арга хэмжээг авах вэ? гэдэг асуудлаар товчхон мэдээлэл өгье.

Авлигатай тэмцэх асуудал гэдэг бол хандлагын өөрчлөлт гэдгийг өнгөрсөн цаг хугацаанд өрнөж буй үйл явдалууд харуулж байна. Бид өөрсдөө аливаа зүйлийг зөв ойлгох, хэрэг хянан шийдвэрлэх, тэмцэх арга барилаа өөрчлөх гэх мэт маш олон зүйлс дээр хандлагаа өөрчлөх хэрэгтэйг нийгэм хийгээд шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомж биднээс шаардаж байгаа. Мэдээж Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж сайжруулах асуудал байгаа, гэхдээ ял хариуцлага хөнгөн гэхээсээ илүү ял хариуцлага гарцаагүй байх ёстой гэдэг асуудал нэн тэргүүний асуудал юм.

Авлигатай тэмцэх үндэсний

хөтөлбөрийн 2.1.5-д шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зэрэг том зорилтууд байдаг. Батлагдсан хууль тогтоомжийн хүрээнд энэ зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгийг ярилцъя. Үүнд Зөрчлийн тухай хууль бол авлигатай тэмцэх том алхам болсон гэж үздэг. Зөрчлийн тухай хуулиар бусад 230 хуулиар зохицуулдаг байсан харилцааг төрөлжүүлсэн.

Хуучин захиргааны хариуцлага болоод бусад хуулийг харах юм бол бүгд интервалтай байсан. Жишээ нь 5000-10000 төгрөг, энгийн үгээр хэлбэл, инээсэн хүнийг 5000 төгрөгөөр торгоод, учирласан, хууль сахиулагчтай муухай харьцахаар 10000 төгрөгөөр торгодог байсан. Ийм л эрх зүйн орчинтой байсан. Энэ хандлага нь хууль сахиулагч нарт нь тогтож ирсэн. Үүнийг өөрчлөхийн тулд Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт нэг том алхам болсон.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуультай уялдуулж зөрчил шалган шийдвэрлэх асуудлыг нэгдсэн стандартад оруулах нь чухал байсан. Нэг байгууллагын дарга, эсхүл агентлагийн даргын шийдвэрээр торгууль шийтгэлийг оногдуулах, өөр журам, стандартаар зөрчлийг шалгаж, үүнээс шалтгаалж иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгддөг, ашиг сонирхлын зөрчил гарах зэрэг асуудал байсныг үүгээр эцэс болгож өгсөн.

Прокурорын байгууллагын тухай

хуулийн хувьд Олон улсын хууль хяналтын байгууллагуудтай эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамтын ажиллагааг өрөгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдгээ ухамсарлаж хуулиар зохицуулж, гарцыг нь нээж өгсөн.

Одоо бид цаашдаа энэ чиглэлээр манлайлал үзүүлэх ёстой, зөв зохион байгуулалт хийх ёстой. Илүү их хүчин чармайлт гаргах ёстой гэдгийг хэлмээр байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс аль нэг улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх алхам хийгээгүй байсан ч прокурорын байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шууд харилцах боломжтой болсон гэсэн үг юм. Мөн энэ чиглэлээр Авлигатай тэмцэх газарт ч боломж нээлттэй болсон гэдгийг хэлмээр байна.

Түүнчлэн өнөгөрсөн 3 жилийн хугацаанд батлагдсан гол хуулиудыг та бүгдэд танилцуулахад Улсын бүртгэлийн багц хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд бас дурдаж болно. Мөн Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн боловсруулалтын явц, төслийг товчхон танилцуулая.

Улсын бүртгэлийн багц хууль авлигатай тэмцэхэд ямар ач холбогдолтой вэ гэдгийг танилцуулахад төрд байгаа мэдээллүүд өмнө нь тус тусдаа, уялдаагүй, зөрүүтэй, түүнчлэн албан тушаалтан нь тухайн мэдээллийг хувийн ашиг сонирхолдоо ашигладаг, ашиглах эрсдэлтэй байсан бол улсын бүртгэл дээр нээлттэй хаалттай мэдээллийг бий болгож өгсөн. Улсын бүртгэлийн нэрийн сан, хаягийн сангийн мэдээлэл бүгд нээлттэй болсон. Хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд

бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчдийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, өөрчлөн байгуулагдсан талаарх мэдээлэл зэрэг нь бүгд нээлттэй болсон. Мөн төрийн нууцад хамааруулснаас бусад үл хөдлөх хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээлэл нээлттэй болсон. Тухайлбал: хилийн зааг, талбай, хүний тоо зэрэг мэдээллийг нууцын зэрэглэлтэй болгосон.

Төрд байгаа хаалттай мэдээлэл авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж, хаалттай мэдээллийн цаана бүх хууль бус зүйл өрнөдөг байна. Энэ мэдээллүүдийн нээлттэй болгох ёстой гэсэн суурь гол концепц хийж өгсөн. Тодорхой төрлийн мэдээллийг ил тод болгож байгаа нь олон нийтэд хяналт тавих эрхийг нь нээж өгч байгаа нэг хэрэгсэл юм. Иргэд, олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл сошил эдгээр мэдээллийг ашиглаж маш олон хэргийн үзүүрээс атгаж гаргаж ирэх, хуулийн байгууллагаар шалгуулах зэрэг ажлууд эрчимтэй явагдаж байна. Цаашдаа авлигатай тэмцэх үйл ажиллагаанд мэдээллийн нээлттэй байдал, иргэдийг мэдээллээр хангах гэдэг цогц томоохон ажил хийгдэх юм. Хоёрдугаарт, техникийн ололттой байдлыг ашиглаж авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зайлшгүй нэвтрүүлэх, дэмжих нь чухал юм.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 1997 оны хууль нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болж, агуулгын хувьд өргөжсөн. Хуулийн зорилт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлсэн буюу гэмт

хэрэг, зөрчил шалгах ажилд төрийн бус байгууллага олон нийтийн оролцоог тодорхойлох замаар энэ ажиллагааг хийхээр хуульчлагдсан. Бид бүгд жижиг гэлтгүй зарчлийн шинжтэй үйлдэлтэй тэмцэж байж томоохон үндэстэн дамнасан, нийгэмд хор хөнөөлтэй гэмт хэргүүдтэй амжилттай тэмцэх юм. Бид бүгд урд өмнө жижиг зүйлүүдийг хаядаг байж, жижиг зүйл нь аажимдаа томордог. Хумсалсаар хумсалсаар хулгайч гэдэг шиг, буруу, хууль бус зүйлтэй жижиг гэлтгүй тэмцэх нь чухал юм. Энэ хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон бөгөөд соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, харуцлага хүлээлгэх гэсэн чиглэл шинээр тусгагдсан.

Хүн, хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн цогц арга хэмжээг соён гэгээрүүлэх чиглэл гэж хуульчилсан. Энэ чиглэлээр ойрын өдрүүдэд манай хууль сахиулах байгууллагууд болон тэр дундаа Авлигатай тэмцэх газар нь маш сайн үлгэр жишээ байдлаар хандаж энэхүү зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Гарсан гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх биш хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй юм.

Соён гэгээрүүлэх ажил нь иргэн хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, түүний улмаас хууль ёсны эрх ашиг, сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлж ажиллах явдал юм. Авлигатай тэмцэх газраас иргэд хаана хохироод байна гэдгийг тогтоож өгч байна. Жишээ нь, судалгаанаас харахад газар, гааль, татвар, шүүх

байгууллагыг иргэд онцолж байна. Эдгээр асуудлыг хууль эрх зүйн болон дэд бүтцийн асуудлаар бид яаж шийдвэрлэх вэ гэдэгт анхаарах шаардлагатай. Мөн гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тодорхойлж тэдгээрийг саармагжуулах, арилгах арга хэмжээг авах бололцоотой байгаа. Өөрөөр хэлбэл, хуучин Захиргааны хариуцлагын тухай хуулиас нэг үйдэл дээр 500-10000 мянган төгрөгийн хариуцлагатай байсныг бид хатуу тогтоож өгсөн нь урьдчилан сэргийлэх ажлын бас нэг алхам болсон. Аль нэг хууль сахиулагчийн субъектив байдлаас хамаардаг байсныг таслан зогсоож өгсөн.

Түүнчлэн энэ хуульд зохицуулах зөвлөл чиг үүргийг тодорхой болгож өгсөн. Хуучин Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулах зөвлөл гэж ажиллаж байсан бол Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил Засгийн газрын үйл ажиллагаа гэдэг утгаараа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийг Засгийн газрын шийдвэрээр байгуулна. Мөн энэ хуульд анх удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг, улсын хэмжээнд болон салбар болон дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд дүгнэлт хийх тусгаад байна. Өөрөөр хэлбэл, бид өөрсдийн алдааг мэддэггүй юм байна. Өөрсдийгөө нэг удаа толинд харах хэрэгтэй. Мөн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөлт, хүний нөөц бэлтгэх зэргээр хийх ажлуудыг тодорхой тусгаж өгсөн.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд Авлигатай тэмцэх газар хангалтгүй хэрэгжүүлж

байна. Өөрөөр хэлбэл мэдээлэгчийг юмуу тодорхой төрлийн гэрчийг хамгаалах асууда лд эрх зүйн орчин байхгүй гэж ерөнхий байдлаар яриад байгаа боловч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд бие даасан нэгж ажиллах ёстой, энэ нэгжийг АТГ хараахан байгуулаагүй байна. Энэ асуудал төсөв, хүний нөөцөөс шалтгаалсан байх.

Цаашид бид хууль, эрх зүйн орчинг сайжруулах ажил тасралтгүй үйл явц бөгөөд тооцоо судалгаа, үндэслэлтэйгээр энэ ажлыг хийх нь чухал байна.

Гэмт хэрэг, зөрчлийн судалгааг маш сайнхийххэрэгтэй. Энэчиглэлээрэрдэм шинжилгээний бие даасан байгууллага нээж ажиллуулахаар байгаа. Тус хуульд мөн хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжлага хийх, нэвтрүүлэг бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилгоо болгосон. Мөн хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж нэвтрүүлэх гэсэн зохицуулалт оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн

эрэн сурвалжлах гэх зэрэг ажлуудад тодорхой нийгмийн хариуцлага хүлээхээр тусгасан. Энэ хуульд шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглох тухай заалт орсон тул хэвлэл мэдээллийн байгууллагууд анхаарах ёстой. Бусад оронд бол гэмт хэргийн талаар мэдээлдэг сэтгүүлч нарын бэлтгэдэг. Энэ нь өөрөө мэдээллийг дамжуулахад хэрэглэх үг хэллэгийг зөв хэрэглэх ач холбогдолтой. Ийм хандлага, арга барил сэтгүүлч нарын дунд төлөвших хэрэгтэй байгаа.

Эцэст нь шинээр боловсруулж байгаа хуулийн талаар товч мэдээлэл өгөх гэсэн юм. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинээр боловсруулж байна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг одоогийн байдлаар Засгийн газар дэмжээд байна. Энэ хууль авлигатай тэмцэхэд ямар ач холбогдолтой вэ гэхээр төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдлаар бүрдүүлэхэд чиглэлд зарим зохицуулалтууд тусгагдаад байгаа. Өнөөгийн байдлаар ТББ-ууд авлигын том схемд оролцох, мөнгө угаах гэмт хэрэгт өртөх эрсдэл нэлээдгүй өндөр байна. Иймд төрийн бус байгууллагын санхүүжилт, хандив нээлттэй болох ёстой юм.

Анхаарал хандуулсан Та бүгдэд баярлалаа.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИТГЭЛИЙГ АХИУЛАХ, ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Илтгэгч: Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Чулуунтамир



Юуны өмнө хуулийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх сэтгэл ханамжийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг илэрхийлэн энэхүү арга хэмжээг зохион байгуулж байгаа Авлигатай тэмцэх газрын хамт олонд талархлаа илэрхийлье.

Мөн зөвлөгөөнд оролцогчдод амжилт хүсье.

Цагдаагийн байгууллага бол тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага. Гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд ихээхэн хүч, хөдөлмөр, хөрөнгөө зарцуулан ажилласан бөгөөд гэмт хэргийг илрүүлэх, шалгах, шийдвэрлэх үүргээ амжилттай биелүүлж яваа гэж үздэг. Гэсэн ч гэмт хэргийн тоон үзүүлэлт, төрөл жил ирэх тусам өсч үүнийг дагаад зардал, хүн хүч, ажлын ачаалал нэмэгдэж ирснийг Та бүхэн мэднэ. Цагдаагийн байгууллага 1976 оноос хойш гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг

нийтийн хэв журам хамгаалах албаны бүтцэд 6 удаа байгуулж, мөн тоогоор татан буулгаж байсан. Энэ нь гэмт хэрэг үйлдэгдэх нь нийгмийн үзэгдэл бөгөөд үүнийг бууруулах арга нь зөвхөн гэмт эдгээдүүдэд олноор ял эдлүүлэх нь үр дүнтэй гэж олон, олон цагдаагийн дарга нар үздэг байсантай холбоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нийтийн хэв журам хамгаалах албаны дайвар ажил мэтээр харж ирсэн байдаг. Өнөөдөр шинэ төрлийн гэмт хэргүүд олноор нэмэгдэж, 2000 онд 20000 байсан гэмт хэрэг өнөөдөр 35000 гараад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121-р тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэгч чиглэл болгож, бүтэц зохион байгуултыг бэхжүүлэх, техник технологийг шинэчлэх цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ гэж төлөвлөсөн. Үүний дагуу цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба, нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог бодлогоор хангах, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах бие даасан бүтцийг 2017 онд байгуулсан. Энэ нэгжийн хамгийн анхны ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг боловсруулан 2018 онд батлуулсан явдал юм. Уг баримт бичигт уламжлалт урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлэхийн зэрэгцээ эерэг хүчний бодлогыг томъёолж хэрэгжүүлэхээр болсон. Эерэг хүчний бодлого гэдэг нь хувь хүн, ойр дотны хүний эрхэмлэдэг зүйлсээр дамжуулан

ухамсарт нөлөөлөх нөлөөллийн арга хэмжээ байхаас гадна иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, нээлттэй болгосноор иргэд цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг сайжруулах явдал юм.

Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх зарим төрлийн үйлчилгээг цахимжуулсан. Тухайлбал, лицензийн төвийн үйлчилгээг цахим болгосноор элдэв танил тал, очер дараалал бий болох, бухимдал үүсгэх нь багасч иргэдийн зүгээс үйлчилгээтэй холбоотой хардлага, сэрдлэг арилсан үр дүн гарч байна.

Өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагаас иргэд рүү чиглэсэн 6 төрлийн цахим үйлчилгээг үзүүлж байна.

1. www.edu.police.go.mn жолооны сургалтын төвийн бүртгэлийн програмыг цахимжуулсан, энд жолооны сургалтын төвүүдийн мэдээлэл, шалгагч багш нарын мэдээлэл, сургууль курсуудын мэдээлэл, элссэн сурагчдыг бүртгэх, сургалтын цаг хугацаа, шалгалтын хуваарь гэх мэт;
2. www.torguul.mn цахим хуудас ажиллуулж байгааг та бүхэн мэднэ;
3. www.saaspolice.go.mn энэ нь гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагаа, цагдаагийн байгууллагаас уг зөвшөөрлийг олгож, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг;
4. www.smartcart.mn тээврийн хэрэгсэлтэй холбоотой бүх төрлийн мэдээлэл энд бий. Татвар болон торгуулын мэдээлэл зэргийг харах боломжтой;
5. www.police.gov.mn цахим хуудсаар өргөдөл, гомдол хүлээн авах болсон;

Дээрх цахим үйлчилгээг явуулснаар

цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод болж, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл тодорхой хэмжээгээр дээшилсэн гэж үзэж байна.

Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан, үйлдлийн аргаас хамаарч түүнээс урьдчилан сэргийлэх арга замууд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, нууц далд аргаар хийгдэж байгаа урьдчилан төлөвлөсөн дээрэм, булаалт, хүн амьны хэргүүд дээр ухуулга, нөлөөллийн аргыг ашиглаад үр дүнд хүрэхгүй.

Харин болгоомжгүй үйлдэгддэг, тухайн үеийн сэтгэл хөдлөлөөр хийгддэг зам тээврийн осол аваар, гэр бүлийн хүчирхийлэл, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүдэд нөлөөллийн ажил үр дүнгээ өгч байна.

Цагдаагийн байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал, эрүүл мэндийн эсрэг г.м гэмт хэргээс түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг түлхүү анхаарсан арга хэмжээг авч байгааг Та бүхэн анзаарсан байх аа. Энэ хүрээнд бид нийтдээ 18 арга хэмжээ, акцыг явуулж, эдгээр арга хэмжээнүүд хүнд хүрсэн гэж бодож байна. Энд дурдсан 18 арга хэмжээ, акцуудаас 6 төрлийн акц буюу “unfriend”, “зөв тусгал”, “дураараа бишээ, дүрмээрээ”, “1 хором”, “яараад яахав дээ”, “ойлгоё хүндэлье” хамгийн их үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Харин үлдсэн 12 арга хэмжээ, акц тодорхой түвшинд явсан хэдий ч том үр дүнд хараахан хүрээгүй ээ. Тэгэхээр бид зөв урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөв цагтаа хийж чадах юм бол ард нь нэг ч гэсэн хүний амийг аврах ийм алтан боломж бидний гарт байдагаа гэсэн үг юм.

Эцэст нь хэлэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлын тэргүүлэх чиглэл юм шүү.

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ШИЙТГЭГДСЭН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ, ТУЛГАГДАЖ БАЙГАА АСУУДАЛ

Илтгэгч: ШШГЕГ-ын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Ганчимэг



Өнөөдөр та бүхэнд авлигын гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд тавьж буй хяналт, ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал сэдвээр мэдээлэл хүргэх юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн буюу 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хорихоос өөр төрлийн албадлагын арга хэмжээ авагдсан хоригдол 2017 онд 3155, 2018 онд 18365, 2019 онд 17339 гаруй ялтан этгээдэд хяналт тавьж ажилласан байна.

Үзүүлэлт	Нийт хяналтад байсан ялтан, этгээдийн тоо	Үүнээс авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтан, этгээдийн тоо
2017 онд	3155	16 /0,5%/
2018 онд	13365	35 /0,2%/
2019 онд	17339	19 /0,1%/

Жилээс жилд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн тоо нэмэгдэх, өсөх эрс хандлагатай байгаа ба энэ хэрээр хяналт тавьж байгаа алба хаагчийн тоо, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал эрс нэмэгдэж байна.

Авлигын гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад ял эдэлсэн этгээдийн тоог авч үзвэл 2017 онд 16, 2018 онд 35, 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 19 этгээд байна.

Үүнээс харахад сүүлийн 3 жилийн байдлаар хорихоос өөр төрлийн ял эдлэгсдийн дөнгөж 1 хувийг авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд эзлэж байгаа. Энэ 70 этгээдийг үйлдсэн гэмт хэргээр нь авч үзвэл эрх мэдэл албан тушаалын байдлаар урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдсэн 16, хахууль авах гэмт хэрэг үйлдсэн 30, хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн 27, төсвийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг үйлдсэн 1 байна.

Үйлдсэн гэмт хэрэг /ЭХТА-ийн зүйл, заалт/	Шүүхээр шийдвэрлэгдсэн он			Нийт
	2017 онд	2018 онд	2019 онд	
22.1. Эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах	2	7	7	16
22.4. Хахууль авах	7	11	9	27
22.5. Хахууль өгөх	6	17	3	26

22.8. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	1			1
Нийт	16	35	19	70

Энэ нь нийт шүүхээр шийдвэрлэгдсэн этгээдийн тоо биш юм. Учир нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад ял эдэлсэн этгээдийн тоо шүүхээр шийдвэрлэгдсний дараа шүүхийн гүйцэтгэх хуудас бичигдснээр шүүх дээр торгох ялаа төлсөн тохиолдол байдаг учраас нийт шүүхээр шийтгүүлсэн этгээдүүдийн тоо гэж үзэж болохгүй.

Авлигын гэмт хэрэг үйлдсэн 70 этгээдэд шүүхээс торгох 40, эрх хасах 51, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 18, нийт 109 ял, албадлагын арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Албадлагын арга хэмжээний төрлийг он, оноор нь авч үзвэл 2017 онд торгох ял оногдуулсан 10, эрх хасах ял оногдуулсан 11, 2018 онд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 13, торох ял оногдуулсан 18, эрх хасах ял оногдуулсан 27, 2019 онд торгох ял оногдуулсан 12, эрх хасах ял оногдуулсан 13, ял оногдуулахгүйгээр тэнссэн 5 байна.

Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар үндсэн ял буюу хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах, нэмэгдэл ял буюу эрх хасах, нийтийн албанд томилох эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан тул нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахгүй байгаа.

Шүүхээс торгох ял оногдуулсан байдлыг авч үзвэл ихэвчлэн 2-10 сая төгрөгийн торгох ялаар шийтгүүлсэн байна. Тодруулбал, 10 хүнийг 2-5 сая төгрөгөөр, 18 хүнийг 5-10 сая төгрөгөөр торгосон. Эндээс авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан торгох ялын торгуулийн хэмжээ ямархуу

байна гэдэг нь харагдаж байгаа байх аа.

Торгох ял биелүүлэх хугацааг Эрүүгийн хуульд зааснаар шүүхээс тогтоож өгдөг. Эсхүл шүүхээс хугацаа тогтоож өгөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь 90 хоног хүртэл хугацааг тогтоож болно. Тогтоосон хугацаагаар нь ангилж авч үзвэл 3 жилийн хугацаа тогтоосон 8, 1-2 жилийн хугацаа тогтоосон 9, 1 жил хүртэл хугацаа тогтоосон 23 шүүхийн шийдвэр байна. Эдгээр этгээд шүүхээс тогтоосон хугацаанд торгох ялыг заавал биелүүлэх үүрэгтэй. Хэрвээ тухайн тогтоосон хугацаанд торгох ялыг биелүүлээгүй бол торгох ялыг хорих ялаар солих саналыг прокурорт хүргүүлж, прокурор шүүхээр шийдвэрлүүлдэг.

Торгох ялаар шийтгүүлсэн 40 ялтанд холбогдох 254,0 сая төгрөгийн торгох ялыг биелүүлэхээс 24 ялтанд холбогдох 164,1 сая төгрөгийн бүрэн барагдуулж, 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 16 ялтанд холбогдох 89,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, ажиллагаанд байна. Энэ 16 ялтанд оногдуулсан торгох ялыг биелүүлэх хугацаа дуусаагүй байна. Энэ хугацаанд торгох ялыг хорих ялаар сольсон зүйл байхгүй. Мөн ял эдлүүлэх хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтан байхгүй байна.

Өмнө нь 2002 оны Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар торгох ял эдлүүлэх ажиллагаанд нилээд хүндрэл учирдаг, ялтнууд торгох ялаа биелүүлдэггүй, шийдвэр гүйцэтгэгчид ялтны хөрөнгө, орлогоос албадан гаргуулах замаар гүйцэтгүүлдэг байсан. Энэ хэрээр багагүй цаг хугацаа орж ял бүрэн биелэгддэггүй байсан. Харин 2015 онд шинэчлэн баталж, 2017 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн

хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар торгох ялаар шийтгэх эрх зүйн зохицуулалтыг нилээн нарийвчилж, тодорхой болгож өгсөнөөр ял эдлүүлэх ажиллагаанд гарах хүндрэл нилээн багассан байгаа. Ялын биелэлтэд ч нилээн ач холбогдолтой болж өгсөн.

Авлигын гэмт хэрэг үйлдэж, нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан 51 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаас 11 ялтны ялын хугацаа дуусч, одоогийн байдлаар 40 ялтан ял эдэлж байгаа бөгөөд энэ хугацаанд эрх хасах ялаас зайлсхийсэн, шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалыг зөрчсөн ялтан байхгүй байна.

Нийтийн албанд томилогдох эрхийг 1 жилийн хугацаагаар хассан 3, 2 жилийн хугацаагаар хассан 36, 3 жилийн хугацаагаар хассан 5, 4 жилийн хугацаагаар хассан 3, 5 жилийн хугацаагаар хассан 4 ялтан тус тус байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг нийтийн албанд томилсон, сонгосон, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлэх, томилсон тушаал шийдвэрийг хүчингүй болгох, цаашид нийтийн албанд томилохгүй байх болон ялтны мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавихыг даалгасан мэдэгдлийг хүргүүлдэг. Мөн Төрийн албаны зөвлөлд ялтныг төрийн жинхэнэ албаны шалгалт болон холбогдох сонгон шалгаруулалтад оруулахгүй байх талаар албан бичиг хүргүүлэх, нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг гаргуулах, ялтныг сар бүр бүртгэл хяналтад авах зэргээр хяналт тавин ажиллаж байна.

Нийтийн албан тушаалд сонгох,

томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 178 дугаар зүйлийн 178.2-т зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрх хасах ял шийтгүүлсэн мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн ялтныг албан тушаалаас чөлөөлөхөөс гадна ажил, албан тушаалд нэр дэвшигч тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх эрхтэй холбоотой эрх хасах ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан эсэхийг нягтлан шалгах, энэ төрлийн ял шийтгүүлсэн тохиолдолд хассан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг гүйцэтгүүлэхээс татгалзах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

Харин хахууль авах, хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн аль аль нь нийтийн албанд томилогдох эрх хасах нэмэгдэл ял шийтгүүлж байгаа бөгөөд хахууль авах гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын хувьд төрийн албанд, харин хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын ихэнх нь хувийн хэвшилд ажилладаг. Энэ тохиолдолд ямар байгууллага, албан тушаалтанд ялтныг нийтийн албанд томилохгүй байх талаар мэдэгдэл хүргүүлж, хяналт тавих нь тодорхой бус байдаг нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учруулдаг.

Тийм учраас шийдвэр гүйцэтгэх байгууллага Төрийн албаны зөвлөлд төрийн жинхэнэ алба хаагчийн болон удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад оруулахгүй байх талаар мэдэгдэл, албан бичиг хүргүүлдэг. Мөн нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагааг тодорхой хугацаанд авдаг. Үүнээс гадна албадлагын арга хэмжээ авагдсан буюу хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу сар бүр

бүртгэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх талаар урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дүгнэлт, санал: Авлигын гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны ял эдлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, ялын биелэлтийн мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн биелэлт, энэ талаарх хууль, журмын хэрэгжилт хангалттай гэж дүгнэж болохоор харагдаж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө торгох ялыг гүйцэтгэхэд нилээд хүндрэлтэй, ялтнууд торгох ялыг биелүүлдэггүй, шийдвэр гүйцэтгэгч ялтны хөрөнгө, орлогоос албадан гаргуулах ажиллагааг явуулж, биелэгдэхгүй байх ч тохиолдол гардаг байсан.

Дээрх хуулиудад “**шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоох, шүүхээс хугацаа тогтоогоогүй бол шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор биелүүлэх, ялтан торгох ялыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солих**” талаар заасан нь торгох ялын биелэлтэд нилээд ач холбогдолтой зохицуулалт болсон.

Нийтийн албанд томилогдох эрх хасах нэмэгдэл ялын хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулах зорилгоор ялтны мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой болгох шаардлагатай байна.



ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН УРАМШУУЛЛЫН ЭЭРЭГ БА СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Илтгэгч: ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албаны мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Ч.Өнөрцэцэг



“Шударга ёс ба олон нийтийн итгэл” сэдэвт хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнд оролцогчдын амрыг эрин мэндчилье. Нэгдсэн зөвлөгөөний энэхүү цаг хугацаанд шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын эрх зүйн зохицуулалтын эерэг болон сөрөг үр дагаварт хийсэн дүн шинжилгээ сэдвийн хүрээнд санал хэлэлцүүлэхийг зорилгоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 9, 83 дугаар зүйлүүдэд “шүүхийн шийдвэрийг бодитой гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчид гүйцэтгэсэн мөнгөн дүн, эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10.0 хувиар мөнгөн урамшуулал олгох, шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг уг төвлөрүүлсэн урамшууллаас санхүүжүүлэх”-ээр хуульчилж, уг хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдсанаар 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр урамшууллын хуваарилалтын эрх зүйн зохицуулалтын үйлчлэл дуусгавар болсон.

Эрх зүйн зохицуулалтын үйлчлэл дуусгавар болж, шийдвэр гүйцэтгэгчид

урамшууллын хуваарилалтгүй болсон цаг, хугацаанд урамшууллын эерэг, сөрөг тал, нөлөөллийг өнөөгийн нөхцөл байдлаас судлан үзлээ.

Хууль тогтоогчоос “урамшуулал”-ын албан ёсны шинжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуульд тодорхойлж, шийдвэр гүйцэтгэгч нь төрөөс зөвхөн цалин хөлс авч, төлбөр авагтай байгуулсан гэрээний үндсэн дээр төвлөрүүлсэн урамшууллаас үйл ажиллагааны зардлаа нөхөн төлж, тодорхой хэсгийг урамшуулал болгон авч байсан.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг урамшууллаас санхүүжүүлэхээр заасан ч уг зардалд ямар зардлууд хамаарах талаар эрх зүйн зохицуулалт хуульчлагдаагүй, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актанд хөрөнгө оруулалтын зардал болох-хувцас, тусгай хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, сургалтын эсхүл урсгал зардал болох дулаан цахилгаан, шуудан холбоо, албан томилолтын зардлыг санхүүжүүлэхээр заасан ч уг зардлуудыг урамшууллаас санхүүжүүлэх үндэслэлгүй болохыг Захиргааны хэргийн шүүхээс дүгнэж, холбогдох эрх зүйн актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрүүд хуулийн хүчин төгөлдөр болжээ.

Хууль хүчин төгөлдөр байх хугацаанд үйлчилж байсан урамшууллын давуу болон сул талыг авч үзэхэд нэг талаас, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн

шийдвэрийн биелэлтийг богино хугацаанд шуурхай хангуулах, төсвөөс хараат бусаар үйл ажиллагааны зардлаа нөхөн төлөх, төрд санхүүгийн ачаалал, зардал үүсэхгүй байхад чиглэгдсэн бол **нөгөө талаас**, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх онцлог чиг үүрэг бүхий хүндхэн ажлыг гүйцэтгэж буй шийдвэр гүйцэтгэгчдийг ажлын байранд тогтвортой ажиллуулах, тэдний нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, төлбөр төлөгчид давуу байдал үүсгэсэн, шан харамж авсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоосон, хойшлуулсан гэсэн төлбөр авагчдын өргөдөл, гомдол бүрэн хязгаарлагдах давуу байдлыг үүсгэж байсан байна.

Тэгвэл урамшууллыг сөрөг талыг авч үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нутаг дэвсгэрт нийцүүлэн тогтоосон тойргийн харьяаллаар явагдаж, улмаар бүс, нутаг дэвсгэр, хүн ам, өрхийн амьжиргааны түвшин, үйлдвэрлэл, үйлчилгээ, барилгажилт, суурьшил, төвлөрөл зэрэг нөхцөл байдлаас хамаарч урамшууллын тэнцвэртэй хуваарилалтгүй, шийдвэр гүйцэтгэгчид нь харилцан адилгүй урамшууллын мөнгө авч байжээ.

Тухайлбал: нийслэл дэх Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэг нь гэр хороолол, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй хохирол, төлбөрийн асуудал ихээр шийдвэрлэгдэг бол Хан-Уул дүүрэгт үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явагддагтай холбоотойгоор шүүхээр шийдвэрлэгдэн ирж байгаа төлбөрийн үнийн дүн өндөр, төлбөр төлөгчдийн хөрөнгө, орлого, төлбөрийн чадварын байдал нь мөнгөн урамшууллын тэнцвэртэй бус хуваарилалтыг үүсгэж, үүнтэй холбоотойгоор урамшуулал өндөр хуваарилагдах боломжтой шийдвэр гүйцэтгэлийн тойрогт ажиллах сөрөг хандлага, хүсэл сонирхолыг алба

хаагчдад бий болгосон байна.

Мөн хүүхдийн тэтгэлэг, эрүүгийн хэргийн улмаас учирсан гэм хорын хохирол, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр нь урамшууллаас чөлөөлөгдөж байсан тул шийдвэр гүйцэтгэгчид зөвхөн урамшуулалтай төлбөрийг гүйцэтгэдэг гэсэн сөрөг хандлагыг нийгэмд ихээр бий болгосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөл боловсруулахтай холбогдуулаад чиг үүрэг хэрэгжүүлж байсан шийдвэр гүйцэтгэгчдээс урамшууллын хуваарилалтын талаар санал, асуулга авахад 66.0 хувь нь цэргийн цолтой болж, урамшуулал авахаас татгалзсан байна.

Уг санал, асуулгад дүн шинжилгээ хийхэд шийдвэр гүйцэтгэгчид нь цэргийн алба хаасан хугацаагаа тооцуулж, төрийн албанд богино хугацаанд ажиллаж, цэргийн тэтгэвэр тогтоолгох, нөгөө талаар урамшуулал нь цалин хөлстэй нэгэн адил байнгын тогтмол орлого биш, зөвхөн төлбөр төлөгчдийн хөрөнгө, орлогын байдал, төлбөрийн чадвараас хамаарч шүүхийн шийдвэр биелэгдэх, урамшуулал олгогдох эсэх нь шийдвэрлэгддэг тул цалин хөлсөө нэмэгдүүлэх хүсэл сонирхолтой холбоотой, мөн нийт санал асуулгад оролцсон алба хаагчдын 67.0 хувь нь урамшуулал багахан хуваарилагдаж байсан орон нутгийн шийдвэр гүйцэтгэгч, мөн урамшуулал авдаггүй, төлбөрийн төрлөөр дагнан ажиллаж байсан цэргийн алба хаагчид байсан нь санал, асуулгын дүнд шууд нөлөөлсөн гэж дүгнэхээр байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2012 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хийсэн үнэлгээний ажлын тайлантай танилцахад⁴¹ “шийдвэр

41. Хууль зүй, дотоод хэргийн яамны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлгээ хийсэн ажлын тайлан, 71-72 тал

гүйцэтгэгчид нь цэргийн ба энгийн байх, урамшуулал авах эсэх талаар санал хуваагдаж, орон нутаг, дүүргийн байршил нь тодорхой нөлөөлөл үзүүлж байна. Орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэгчид цэргийн болж, хот суурин газарт ажиллаж байгаа шийдвэр гүйцэтгэгчид урамшууллын системтэй байхыг хүсч байгаа” талаар дүгнэлт хийсэн нь санал, асуулгын үр дүнг баталж байна.

Урамшууллын эерэг, сөрөг үр дагаврыг ярилцахаас гадна урамшууллын хуваарилалтгүй болсон нь үйл ажиллагаанд эерэг эсхүл сөргөөр нөлөөлсөн үү? гэдэг асуудлыг зайлшгүй хэлэлцэх нь гарцаагүй. Тэгвэл урамшуулалтай болон урамшуулалгүй болсон хугацааны ажлын статистик үзүүлэлтээс харахад:

Он	Шийдвэрлэсэн гүйцэтгэх баримт бичиг		Эрх зүйн зохицуулалтын үйлчлэл
	хаасан гүйцэтгэх баримт бичгийн тоо	төлүүлсэн мөнгөн дүн	
2013 он	16077	507.5 тэрбум. төг	Урамшуулал олгож байсан хугацаа
2014 он	13068	333.1 тэрбум. төг	
2015 он	16347	168.2 тэрбум. төг	
2016 он	17721	149.7 тэрбум төгрөг	
2017 он	19648	294.9 тэрбум төгрөг	
2018 он	20054	504.4 тэрбум төгрөг	Урамшуулал-гүй болсон хугацаа
2019-11 сар	16316	240.6 тэрбум төгрөг	

Урамшуулал олгож байсан сүүлийн 5 жил болох 2013-2017 оны дундаж

үзүүлэлтийг харахад жилд 16500 гүйцэтгэх баримт бичгийн 290.6 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн бол урамшуулалгүй болсон хугацаа болох 2018-2019 оны ажлын үзүүлэлтээр 372.5 тэрбум төгрөгийн 18185 гүйцэтгэх баримт бичгийг шийдвэрлэж, 1615 гүйцэтгэх баримт бичгийн 82.0 тэрбум төгрөгийг илүү шийдвэрлэсэн байгаа нь урамшуулал ажлын үр дүнд шууд сөрөг нөлөөлөл, үр дагаврыг үүсгээгүй гэсэн дүгнэлт хийхээр байна.

Ажлын үзүүлэлтэд урамшуулал төдийлөн нөлөөлөл үзүүлээгүй гэсэн дүгнэлтийг дээрх үзүүлэлтээс дүгнэхээр байгаа ч 2018 оны 1 дүгээр сараас эхлэн шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох эрх зүйн зохицуулалтын үйлчлэл дуусгавар болсноор өнгөрсөн 2 жилийн хугацаанд нийт алба хаагчдын 20 гаруй хувь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн нь урамшууллын хуваарилалт алба хаагчдыг ажлын байранд тогтвортой ажиллах эдийн засгийн баталгааг хангаж байсантай холбоотой байна.

Нөгөө талаар ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын байранд шинээр томилогдсон шийдвэр гүйцэтгэгч тодорхой хугацаанд дадлагажих, ажлын ур чадвар, дадлага туршлагагүй байдал нь ажлын үзүүлэлт, шүүхийн шийдвэрийн биелэлтэнд сөргөөр нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь талуудын аль алины эрх ашигт нийцэн явагдах боломжгүй, заавал аль нэг талын эрх заавал хөндөх, хөрөнгийн өмчлөх эрх хязгаарлагдах, бизнес, санхүүгийн үйл ажиллагаа доголдох, эрсдэлтэй байдгаас төлбөр төлөгч, төлбөр авагчдын санал, гомдол, аливаа хардлага тасардаггүй.

Шийдвэр гүйцэтгэгчид өдөр тутам төлбөр төлөгч, бусад этгээдийн

хүч түрсэн эсэргүүцэл, төлбөрөөс зайлсхийсэн үйлдэлтэй тулгарч, тэдний дийлэнх ажлын цаг төлбөр төлөгчдийн хойноос хөөцөлдөх, төлбөр төлөгч, түүний хөрөнгийн мэдээлэл, нотлох баримтыг цуглуулах, өөрийн гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд төлөөлөн оролцох зэрэг ажлын асар их ачаалалтай чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Нийгэмд урамшуулалгүй болсноор шийдвэр гүйцэтгэгчид төлбөр төлөгчдийн нөлөөнд орж шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эсхүл төлбөр авагчаас хууль бусаар урамшуулал авдаг гэсэн хардлага, гомдол, санал гаргах асуудлууд үүсч, үүнтэй холбоотой тодорхой цаг хугацааг гомдол маргаанд хариу тайлбар өгөх, хянаж, шалгуулах асуудалд зарцуулагдаж байгаа ч хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хууль бусаар урамшуулал авсан аливаа асуудал тогтоогдоогүй, энэ талаар зөрчил гараагүй.

Ижил чиг үүрэг бүхий дэлхийн улс орнуудыг тогтолцоог судлахад шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага нь төрийн болон хувийн холимог хэлбэртэй, албадлагын арга хэмжээ бүрт тодорхой үнэлгээ тогтоож, уг үнэлгээний хураамжаас төвлөрсөн орлогоор шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, мэдэгдэх хуудсыг шийдвэр гүйцэтгэгч өөрөө биечлэн өгөхөд баталгаат шуудангаас хүргүүлснээс өндөр хураамж авах, хөрөнгө хураах, дуудлага худалдаа бүрт харилцан адилгүй үнэлгээтэй хураамж авдаг онцлог эрх зүйн зохицуулалттай байна.

Урамшуулал нь хэдийгээр алба хаагчийн үйл ажиллагааг идэвхжүүлэх

эдийн засгийн хөшүүрэг ч нөгөө талаас төрөөс цалин хөлс авч байгаа төрийн жинхэнэ алба хаагчдаас төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг талаас мөнгөн урамшуулал авах нь учир дутагдалтай, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, богино хугацаанд шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлэхэд зөвхөн шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулах эрх зүйн орчин байх шаардлагатай гэсэн дүгнэлт хийх боломжгүй юм.

Урамшуулал нь үр нөлөөтэй, үүнтэй холбоотой эрх зүйн орчин шаардлагатай гэхээс илүүтэйгээр:

- үр нөлөө бүхий албадлагын арга хэмжээг бий болгож, саад учруулсан зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх;
- хөрөнгийн бүртгэлийн болон эрх бүхий байгууллагуудын мэдээллийн сангаас цахим хэлбэрээр шуурхай мэдээлэл татан авах бүрэн эрхийг шийдвэр гүйцэтгэгчид олгох;
- үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, хөрөнгө худалдан борлуулах, аюулгүй байдлыг хангах, чиг үүрэг бүхий оновчтой бүтэц, тогтолцоог бий болгох;
- шуурхай ажиллахад шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр бүрэн хангах;
- шийдвэр гүйцэтгэгчдийг ажлын байранд мэргэшүүлэх, үр чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой ажиллуулах хууль зүй, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг бүрэн дүүрэн, шуурхай хангуулахад урамшууллын зохицуулалтаас илүү үр нөлөөтэй гэж үзэж байна.

Иймээс гадаад улс орнуудад хэрэгжиж буй төрийн болон холимог, хувийн тогтолцоогоор шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх эрх зүйн орчинг бий болгох эсхүл шийдвэр гүйцэтгэгчид мөнгөн урамшуулал олгох эрх зүйн зохицуулалт шаардлагатай юу гэдгийг судалж, шинээр батлагдсан хуулийн тогтоомжийн хэрэгжилтэнд бодитой

дүн шинжилгээ, судалгаа хийж, бусад орны тогтолцоо, чиг үүрэг, туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хэвшүүлэх нөхцөлийг сайтар судалсны үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх гарцыг эрэлхийлэх шаардлагатай гэдгийг энэхүү илтгэлийн хүрээнд эцэст нь дүгнэхээр байна.



ӨМГӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Илтгэгч: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн Б.Ганболд



Өмгөөллийн ажил шударга ёс, олон нийтийн итгэлтэй салшгүй холбоотой байдаг. Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгч нь 1/ эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, 2/ зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, 3/ шударга ёсыг тогтоолгох, 4/ итгэл дааж тууштай ажиллахыг л хүсэмжилдэг.

Өмгөөллийн үйл ажиллагаанд шударга байдал ба олон нийтийн итгэл алдагдсан шалтгаан нь өмгөөлөгчдийн нэр хүнд унасан, өмгөөлөгч нарт иргэдээс итгэх итгэл бага болсон зэрэгтэй холбоотой.

Өмгөөлөгчдийн нэр хүнд унасан суурь шалтгаан нь өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагагүй байдал хэмээн үзэж болно. Өмгөөллийн үйл ажиллагааг мөнгө олох хэрэгсэл болгох, хувь өмгөөлөгчийн биеэ авч явах ёс зүйгүй байдал нөлөөлж байна.

Өмгөөлөгч нарт иргэдээс итгэх итгэл байхгүй болсон гэж үзэх суурь шалтгаанууд нь нийтлэг байдлаар авч үзвэл дараахь хандлагаар илэрч байна. Үүнд: Өмгөөлөгч худал амлалт өгдөг, 2

талд ажилладаг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр элдэв цуу мэдээлэл цацдаг явдлууд юм.

Харин өмгөөлөгч нарт хариуцлага тооцдог механизм сул хаягдсан гол шалтгааныг дурдвал:

- Өмгөөлөгчид тавигдах шалгуур буюу цензургүй болгосон;
- Өмгөөлөгчийн шалгалт гэж байхгүй;
- Өмгөөлөгчийн өөрөө удирдах ёсны байгууллагын тогтолцоог үгүйсгэсэн явдал зэрэг болно.

Олон улсын стандартын жишээ татвал: Өмгөөлөгчдийн үүргийн тухай НҮБ-ын 1990 оны Конвенцийн 13-р зүйлд “Өмгөөлөгч нь мэргэжлийн ёс суртахууны дагуу, өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар, өөрийн итгэлээр явуулна” гэж заасан байдаг.

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо 2018 онд Өмгөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан гаргасан. Судалгааны үр дүнд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдснаар Өмгөөллийн тухай 2002 оны хуульд заасан журмын дагуу өмгөөлөгчийн шалгаруулалтад ороод тэнцдэггүй байсан болон шүүн таслах ажиллагааны туршлагагүй хууль сахиулагч, төрийн албан хаагч гэх мэт 2000 гаруй хуульчийн гэрчилгээтэй хэн боловч мэргэшлийн болон өөр бусад шалгуургүйгээр өмгөөлөгчөөр ажиллах хууль зүйн боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн.

Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо,

Хуульчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгаанаас үзэхэд 2014-2017 он хүртэл хугацаанд 791 гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэсний 96.2 хувь нь өмгөөлөгчдөд холбогдолтой байна. Өмгөөлөгчид хэл амаар доромжлох, эсрэг талд ажиллаж мэдээлэл өгсөн, шүүх хуралдаанд согтуу ирсэн, ялыг нь хөнгөрүүлж өгнө, хэргийг нь хэрэгсэхгүй болгоно, батлан даалтад гаргана, шүүгч, прокурорыг танина, хувийн харьцаа тогтооно, тэдэнд мөнгө өгнө, хохирогчтой тохиролцож чадна гэж амлах буюу мөнгө хөлс илүү авдаг явдал гаргадаг байна.

Хууль сахиулах болон прокурорын байгууллагад ажиллаж байсан хуульчид ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, огцорсны дараа ямар нэгэн хяналт, хязгаарлалтгүйгээр “шүүхэд төлөөлөх эрх” авч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг алдагдуулах, өмгөөлөгчийн мэргэшлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

2017 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн баталсан Өмгөөллийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “хууль сахиулах болон прокурорын байгууллагад ажиллаж байсан хуульчид ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, огцорсны дараа ямар нэгэн хяналт, хязгаарлалтгүйгээр “шүүхэд төлөөлөх эрх” авч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг алдагдуулах, өмгөөлөгчийн мэргэшлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна” гэж үзсэн.

Өмгөөлөгчийн ёс зүй ба хариуцлагыг дээшлүүлэх талаар эрх зүйн орчин

сайжирсаар ирсэн. Тухайлбал: 2019 оны Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлд Өмгөөлөгчид хориглох зүйлсийг маш тодорхой, дэлгэрэнгүй зааж өгөв. Жишээ нь:

- Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өмгөөллийн нууцыг задруулах, нийтэд мэдээлэх;
- Өмгөөллийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх,
- Өмгөөллийн хөлсөд хамаарахгүй мөнгө, бэлэг, шан харамж авах, шаардах;
- Үйлчлүүлэгч олж өгсний төлөө бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах;
- Эсрэг ашиг сонирхол бүхий хэрэг, маргааны талаас шан харамж авах, тэдгээртэй түүний өмгөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр уулзах;
- Хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад баримт сэлтийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэх гэм мэт олон зүйлс тусгажээ.

Дээрх нөхцөл байдлаас дараахь дүгнэлтийг илтгэгчийн зүгээс хийж болохоор байна /дэлгэрэнгүй бичгээр байгаа учир/.

Дүгнэлт 1: Өнөөдрийн байдлаар өмгөөлөгчид тавигдах ямар нэг тусгай шаардлага гэж үзэх зүйл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд байхгүй байна. Жишээ нь: өмгөөлөгчийн шалгалт.

Харин шинэ Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгчийн шалгалтыг сэргээсэн явдлыг зөв гэж дүгнэн үзэж байна. Хууль зүйн сургууль төгсөнгүүтээ, дан ганц онолд суурилсан шалгалт өгчихөөд л шууд өмгөөлөл хийж байгаа явдал нь хүний эрх, эрх чөлөөг хөндсөн сөрөг нөлөөтэй, олон хүнийг

туршилтын туулай болгох нигууртай. Энэ нь мэргэшлийн өмгөөлөгчийн зөв тогтолцоо байхгүйтэй холбоотой.

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Яам эсвэл Улсын дээд шүүх бус Өмгөөлөгчдийн холбоо өгөх болсон нь зохистой юм.

Дүгнэлт 2: Өмгөөллийн тухай 2002 оны хууль хүчингүй болсноор өмгөөлөгчдийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдал зохицуулалтгүй болж орхигджээ.

Энэ нь НҮБ-аас тогтоосон болон ОУ-д тогтсон “өмгөөлөгчид, бие даасан мэргэжлийн холбоо байгуулах түүнд нэгдэн орох” зарчим алдагдахад хүрсэн гэж үзэхэд хүргэж байна.

Дүгнэлт 3: Дан ганц Өмгөөллийн хууль гарснаар асуудал бүрэн шийдэгдэхгүй. Өөрөөр хэлбэл хуульдаа бус хуульчиддаа байгаан биш биз гэсэн үг л дээ.

Боловсон хууль бус харин боловсон залилан болсон өмгөөлөл өнө удаан оршин тогтнохгүй. Хувийн олон тооны хууль зүйн их, дээд сургуулиуд шиг зах зээлийн жамаараа шалгарч үлдэх зүй

тогтолтой.

Иймд энд амь үлдэхийн тулд шударга байдал, үйлчлүүлэгчийн итгэлийг даах нь чухал.

Ингээд дараахь саналыг дэвшүүлж байна:

1. Зөвхөн дүрэм, журам төдийхнөөр бус өмгөөлөгчийн ёс зүй, хариуцлагын асуудлыг бие даасан хуулиар зохицуулах;
2. Өмгөөлөгчдийг дагнан мэргэшүүлэх, зэрэглэл тогтоох, үйлчлүүлэгч нарт хүнд сурталгүй байх тогтолцоог бүрдүүлэх;
3. Өмгөөлөгчид тавигдах суурь шаардлагыг эрс нэмэгдүүлэх, ёс зүйг хүчтэй хариуцлагаар ачаалж өгөх, эрх хасах туйлын санкц тогтоох.

Хэрэв ингэж чадвал хүний хууль зүйн туслалцаа авах эрх хангагдаж, өмгөөлөгчдийн нэр хүнд өсч, хариуцлага сахилга бат нэмэгдэж, шударга ёс тогтож, олон нийтийн итгэл баталгаажих, авлигаас ангид байх боломж бүрдэх нигууртай.



ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ, ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО

*Илтгэгч: МУИХС-ын Хууль зүйн сургуулийн профессор,
хууль зүйн доктор О.Мөнхсайхан*



2014-2018 онд нийт 71 шүүгчид сануулах, цалин бууруулах, огцруулах шийтгэл ногдуулсан. Эндээс хүчин төгөлдөр болсон нь 15 байгаа. Энэ ямар шалтгаанаар хүчин төгөлдөр бус болсон бэ гэдэг дээр илтгэлийн явцад дахин танилцуулна.

Шүүхийн сахилгын тогтолцоог Үндсэн хуулийн түвшинд авч үзэх хоёр үндсэн шалтгаан судалгаагаар гарч ирсэн байд.

Нэг дэх нь: Шүүхийн сахилгын тогтолцоо маш тогтворгүй явж ирсэн. 1993-2002 оны хооронд шүүгчийн сахилгын хороо гэж байсан. Энэ хороо нь дан шүүгчдээс бүрдсэн, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх болон Дээд шүүхийн дэргэд байдаг ийм хороо байсан. Сүүлдээ талийгаач Бямбаа докторын дүгнэснээр дан шүүгчдээс бүрдсэн учраас шүүгч, шүүгчийнхээ асуудлыг хаацалдаг ийм байдалд орж, сүүлдээ хариуцлага тооцох байдал нь нэлээн суларсан. Тийм учраас 2002 оны Шүүхийн тухай

хуулиар шүүгчийн сахилгын хороо, шүүхийн сахилгын хороо гэж нэрийг нь солиод хөндлөнгийн болгосон. Өөрөөр хэлбэл, шүүгчийг томилуулах, шүүгчийн асуудлыг шийдэж эхэлсэн нь шүүгчийн ёс зүй дээр хуульчдын, олон нийтийн төлөөллөөс хөндлөнгөөс үнэлэлт дүгнэлт өгөх маш чухал зарчмын суурь нь тавигдсан.

Тэгэхдээ энэ үеийн нэг онцлог нь Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг шүүхэд давж заалдах эрхийг нь хаачихсан байсан учраас хэдийгээр хариуцлага тооцох тоо нь ихэссэн ч гэсэн хараат бус байдал уруу халдах ийм эрсдэл үүссэн. Өөрөөр хэлбэл, баланс нэг тал уруугаа хэтэрхий дарагдсан гэж харагдаж байна. 2012 оны хуулийн дагуу 2013 онд шүүхийн ёс зүйн хороог байгуулсан. Ингэхдээ 2002 оны хөндлөнгийн бүрэлдэхүүн гэсэн ерөнхий зарчмыг хадгалахын зэрэгцээ энэ хорооны шийдвэрийг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхийг нээж өгснөөрөө хараат бус байдал болон хариуцлага хоёрын балансыг нь олох гэсэн нэг оролдлого болсон. Одоогийн шүүхийн ёс зүйн хороо, өмнөх шүүхийн сахилгын хорооны нэг нийтлэг зүйл юу вэ гэхээр бүх гишүүд болон даргыг нь Ерөнхийлөгчийн зүгээс томилдог байгаа байдал нь өөрөө бас зарим асуудлуудыг бий болгосон байгаа. Үүнийг дараа нь ярина. Тогтвортой байдлыг хангах асуудал гарч ирж байгаа бөгөөд энэ нь тогтолцооны асуудал юм.

Хоёр дахь нь: Шүүхийн ерөнхий зөвлөлд төвлөрсөн эрх мэдэл байгаа.

Үндсэн хуулийн цэцийн 1994 оны тогтоол бий. Шүүгчийн сахилгатай холбоотой, шүүгчийн сахилгын хэрэг үүсгэх, шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг хянах, тодорхой шийтгэлийн төрлүүдээс сонгож хэрэглэх ийм бүрэн эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд өгсөн нь Үндсэн хуулийн 49.4-ийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц шийдсэн юм, уг нь.

Гэвч өнгөрсөн хугацаанд Цэцийн энэ шийдвэр яг бүрэн хэрэгжиж чадаагүй. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн бодлого менежмент төсвийн эрх мэдлээс гадна шүүгчийг сонгон шалгаруулах мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээтэй холбоотой эрх мэдлүүдийг тодорхой хэмжээнд хуулиар авч ирсний дээр шүүгчийн сахилга, ёс зүйн асуудалд нэлээн оролцоотой явж ирсэн. Тухайлбал, өнөөдөр хуулиар хориглосон ажил, албан тушаал эрхэлсэн эсэх, 1 жилийн дотор дахиж сахилгын шийтгэл хүлээсэн эсэх ийм асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө тогтоогоод, шүүгчийг огцруулах саналыг Ерөнхийлөгчид явуулах бүрэн эрх байгаа нь өөрөө Шүүгчийн ёс зүй, сахилгын асуудалд Ерөнхий зөвлөл ороод зогсохгүй, энэ өөрөө Үндсэн хуулийн цэцийн 1994 оны тогтоолтой зөрчилдсөн хуулийн зохицуулалт юм.

Маш олон харьцуулсан судалгаагаар Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхтэй холбоотой бүх эрх мэдлийг төвлөрүүлэх нь өөрөө шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах биш, харин тийшээ үүгээр дамжуулж халдах, урвуулан ашиглах эрсдэл үүсгэдэг учраас шүүхтэй холбоотой эрх мэдлүүдийг аль болохоор өөр өөр институциудад хуваарилж өгөх ёстой гэсэн үр дүн, судалгааны дүгнэлт гарсан.

Хойд Европт манай өнөөдрийн Шүүхийн ерөнхий зөвлөлд байдаг шиг эрх мэдлийг 3 тусдаа институци

хэрэгжүүлдэг. Өмнөд Европын улсуудад 2 тусдаа институци хэрэгжүүлдэг. Манайх болон Унгар, Словак зэрэг улсуудад шүүхийн зөвлөлдөө хэт их эрх мэдэл төвлөрүүлсэн нь өөрөө, хэн нь энд ажиллаж байгаагаас үл хамааран шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулах нөхцөл байдал үүсэж байна. Нэгдүгээрт, шүүгчийн сахилгын тогтолцоо тогтворгүй, 3 удаа өөрчлөгдсөн, одоо 4 дэх удаа өөрчлөгдөх төсөл нь тодорхой хэмжээнд боловсруулагдчихсан явж байгаа. Үүнийг тогтворжуулах ийм шаардлага гарч ирсэн. Хоёрдугаарт, Шүүхийн ерөнхий зөвлөл дээрх төвлөрсөн эрх мэдлийг задлах шаардлага гарч ирсэн.

2019 оны 6 сарын 6-нд өргөн барьсан 62 гишүүний төслөөр шүүгчийн хариуцлагын зөвлөл гэдэг нэртэй байхаар өргөн барьсан. Бүрэлдэхүүнийг нь тодорхой заасан ийм төсөл анх өргөн баригдсан юм. Өөрөөр хэлбэл, энэ институци нь өөрөө 9 гишүүнтэй байна. 3 нь хууль зүйн эрдэмтэн, 3 нь шүүн таслах ажлын туршлагатай хуульч, 3 нь иргэдийн төлөөлөл байна. 6 жилээр 1 удаа томилогдоно. Даргыг дотроосоо сонгоно гэсэн ийм детал байдлаар анх төсөл өргөн баригдсан.

Гэхдээ 7 сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тусдаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, санал гаргасан. Үүгээр ерөнхийдөө энэ институцийг шүүхийн сахилгын хороо гэж нэрлэх ийм санал. Бүрэлдэхүүнийг нь Үндсэн хуульд заахгүй байх ийм саналтайгаар өргөн барьсан. Тэгэхээр энэ хоёр төсөл санал уялдах, уялдуулах зөвшилцлийн үйл ажиллагаа сүүлийн 3-4 сар үргэлжилсэн. Энэ хугацаанд Ерөнхийлөгчийн төсөл, саналаас энэ Шүүхийн сахилгын хороо гэдэг нэрийг нь авсан. Агуулга, чиг үүргийн зохицуулалт нь 62 гишүүний төслийнхөөр батлагдсан байгаа.

Үндсэн хуулийн 49.6-д шүүхийн сахилгын хороо нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэгтэй байна гэдгийг нь зааж өгсөн. Энэ бол зарчмын хувьд маш чухал, ач холбогдолтой зохицуулалт. Эндээс би 4-ийг нь дурдъя.

Нэгдүгээрт, ямар ч байсан шүүгчийн сахилгын тогтолцоог 7-8 жил болоод өөрчилдөг тогтворгүй байдлыг зогсоож, тогтворжуулан залгамж чанарыг нь хангаж өгсөн.

Хоёрдугаарт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн эрх мэдлийг задалж байгаа. Өөрөөр хэлбэл, энэ заалт хүчин төгөлдөр болсноос хойш Шүүхийн ерөнхий зөвлөлийн зүгээс шүүгчийн сахилга, ёс зүйн асуудалд ямар нэгэн байдлаар орох явдал үүгээр дуусгавар болно. Ингэснээрээ энэ эрх мэдлийг урвуулан ашиглах эрсдэл тодорхой хэмжээнд буурна гэж харагдаж байгаа.

Гуравдугаарт, Шүүхийн сахилгын хороог бие даалган байгуулж байгаа нь өөрөө бие даасан байдлыг хангахад чухал үүрэгтэй. Жишээлбэл, өнөөдөр шүүхийн ёс зүйн хорооны ажлын алба бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба Тамгын газарт харъяалагддаг. Шүүхийн ёс зүйн хорооны шийдвэрт гаргасан гомдол заавал Шүүхийн ерөнхий зөвлөлөөр дамждаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тамга, тэмдэг дарагддаг. Тэнд байгаа эрх бүхий өөр, өөр албан тушаалтнуудад шүүхийн ёс зүйн хороонд ирсэн гомдлууд танилцагддаг г.м олон зүйл байдаг. Дээрээс нь Шүүхийн ёс зүйн хороо тодорхой асуудлыг шалгах, томилолт хэрэгтэй болдахиад Ерөнхий зөвлөлөөс томилолт бичүүлж авдаг ч юм уу? Ийм олон байдлаар хамааралтай байдал

багасч Шүүхийн сахилгын хорооны бие даасан байдал дээшилж байгаа юм.

Дөрөвдүгээрт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр шүүгчийг түдгэлзүүлэх, Ерөнхий шүүгчийг огцруулах ийм хууль өнгөрсөн хавар батлагдсан. Энэ хуулийн холбогдох зохицуулалтууд бүгдээрээ үүнийг дагаж хүчингүй болно. Яагаад гэхээр шүүгчийг түдгэлзүүлэх, огцруулах тусгайлан чиг үүрэгтэй институцийг бий болгож байгаа учраас.

Дараагийн чухал ач холбогдол нь Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно гэж зааж өгч байгаа. Өнөөдрийг хүртэл шүүхийн ёс зүйн хороо, өмнөх сахилгын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам, бүрэлдэхүүнийг нь томилох, нэр дэвшүүлэх асуудал хуулиар биш, журмаар зохицуулагдаж байсан. Маш товчхон байдлаар зохицуулагдаж байсан. Тэгэхээр шүүгчийн түвшний албан тушаалтны сахилгын асуудлыг шийдэх гэж байгаа энэ зүйл бол өөрөө хуулиар зохицуулагдах Үндсэн хуулийн зарчим илүү тодорхой болсонд юм. Мэдээж тусгайлсан хууль байх боломжтой. Шүүгчийн сахилгын тухай хууль гэх мэт, нэрийг нь хууль тогтоогч шийдэх байх. Эсхүл одоогийн Шүүгчийн эрх зүйн байдлын хууль, Шүүхийн захиргааны хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар ямар ч байсан журмаар зохицуулахгүй бүх харилцааг хуульд детальчилж оруулах нь. Энэ нь дахиад цаашаа хараат бус байдал, хариуцлага гэсэн хоёр зарчмаа илүү сайн хангах баталгаа болж өгнө гэж харагдаж байгаа юм. Мөн бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журам, бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам гэсэн энэ 5 зүйлийг хуулиар

зохицуулна гэж байгаа.

Энэ асуудал дээр би товчхон, цагтаа багтаагаад гол гол санааг хэлье. Бүрэлдэхүүнд тавигдах шаардлага бол өнөөдрийнхөөс илүү тодорхой болох шаардлагатай. Яагаад гэвэл, өнөөдөр эрдэмтэн, хуульч хүн бүр Шүүхийн ёс зүйн хороонд орж ажиллаж болно гэсэн утгатай заалт байгаа юм. Хэн ч орчих боломжтой. Иймд яг ямар шаардлага тавьж байгаа вэ гэдгийг тодорхой болгох. Нөгөө талаар 2002 оноос эхэлсэн хөндлөнгийн бүрэлдэхүүн байх зарчмаа хадгалах хэрэгтэй, тэгж байж хариуцлага дээшилнэ. Гэхдээ балансыг нь хангах ёстой. Яг хэдэн хувь нь, жишээлбэл гуравны нэг нь шүүгчдийн төлөөлөл, гуравны нэг нь иргэдийн төлөөлөл, гуравны нэг нь хуульчид, эрдэмтдийн төлөөлөл ч гэдэг юм уу, балансыг нь бас зааж өгөхгүй бол болохгүй.

Шүүхийн энэ сахилгын хорооны гишүүний ёс зүйн асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай.

Нэр дэвшүүлэх, томилох журмын асуудал байна. Хуулийн 49.4 дэх заалт батлагдсан гол үзэл баримтлал нь мэргэжлийн холбоо, Засгийн газар, 3 шатны шүүх гэсэн өөр, өөр эх сурвалжуудаас нэр дэвшүүлж томилох байдлаар бүрдүүлэх зарчим үзэл баримтлалд нь тусгагдсан учраас үүний дагуу хууль гарах ёстой.

Бас нэг чухал зүйл бол Үндсэн хуулийн 33.4-т зааснаар Ерөнхийлөгчид Үндсэн хуульд заагаагүй бүрэн эрхийг хуулиар нэмж өгдөг байсан. Үүнийг ерөнхийдөө энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр больж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд байгаа эрх мэдлийг огт хасаагүй, харин өнгөрсөн 27 жил 40 гаруй хуулиар Ерөнхийлөгчид Үндсэн хуульд байхгүй эрх мэдлүүдийг нэмж өгснийг болиулж, зөвхөн 33 дугаар зүйлд заасан үндсэн

бүрэн эрхийн хүрээнд тодорхой бүрэн эрхийг хуулиар Ерөнхийлөгчид нэмж өгч болно гэсэн зохицуулалт орсон. Энэ нь Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүнийг томилох, цаашлаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг томилох гэх мэтчилэн энэ Үндсэн хуульд байхгүй эрх мэдлүүдийг Ерөнхийлөгч хэрэгжүүлэхгүй. Ерөнхийлөгчид шүүгчийг томилох, Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох эрх мэдэл нь байгаа. Үүнээс бусдаар шүүх эрх мэдэлд хэтэрхий нөлөөтэй оролцож байгаа тэр байдлыг хязгаарлах зохицуулалт хийгдсэн.

Мөн бүрэлдэхүүнийг шийдэхдээ сөөлжиж томилох, эсхүл бүрэн эрхийн хугацаа нь дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болдгоор зохицуулахгүй бол өнөөдрийн шүүхийн ёс зүйн хорооны хувьд бүрэлдэхүүн нь тэр чигээрээ 100 хувь бүрэн эрх нь дуусаад, 100 хувь шинэ хүмүүс орж ирэх ийм байдалтай хууль, журмын зохицуулалт явж байна. Үүнээс шалтгаалан олон жил үүсгэсэн сайн туршлага, практик тасалдах нөхцөл үүсч байгаа.

Дээрээс нь гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох журмыг нарийвчилж заахгүй бол өнөөдөр Шүүхийн ёс зүйн хороо "0" гишүүнтэй, ямар ч ажиллагаа хийх боломжгүй, 8 сараас хойш нийт гишүүдийн хурлаа хийх боломжгүй. Яагаад гэхээр нэр дэвшигдсэн субъектүүд томилогдож чадахгүй байгаагаас болоод. Энэ асуудлаар хуулийн зохицуулалтыг нарийвчилж хийх шаардлагатай.

Энэ сахилгын хорооны бүрэн эрхийн хувьд нэг талаас ёс зүй зөрчсөн асуудлыг шийднэ, нөгөө талаас чадамжгүй байдлын асуудал байна. Жишээлбэл, манай Монголын практикт цус харавсан шүүгч, харааны бэрхшээлтэй болсон шүүгч, архины

хамааралтай болсон шүүгч тодорхой хугацаанд ажилласан жишээ бий. Бусад орны туршлагаас үзэхэд ийм байдал үүссэн тохиолдолд асуудлыг шударга процессоор шийдэж, шүүгчийн ажлаа хийх чадамжтай юу гэдгийг авч хэлэлцээд, чадамжгүй гэж үзэх юм бол бүрэн эрхийг нь түдгэлзүүлдэг. Үүнд шүүгчийг буруутай гэж үздэггүй. Харин чадамжгүй байдал нь арилсны дараа тэр нь нотлогдох юм бол буцаагаад бүрэн эрхийг нь сэргээдэг байна. Энэ асуудлыг Шүүхийн сахилгын хороо шийдэх боломжтой. Гол нь энэ өөрөө маргаан шийдэх институци учраас процессын шударга ийм байдал маш чухал.

Зохион байгуулалтын хувьд ажлын албыг бие даалгах, төсвийн болон хүний нөөцийн асуудлыг шийдэх гээд олон асуудал бий. Энэ маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны журамд маш олон зүйл байгаа. Тухайлбал, зөрчил гарснаас хойш 6 сар өнгөрвөл ямар ч ёс зүй, сахилгын шийтгэл хүлээдэггүй, үүнийг өөрчлөх ёстой гэх мэтчилэн процессын хэд хэдэн асуудал байгаа.

Шүүхийн ёс зүйн хорооны хувьд 2 жилийн өмнө Азийн сантай хамтраад олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Тэр хурлын зөвлөмжид энд дурдсан олон процедурын асуудлуудыг шийдэж байж, шүүгчийн хараат бус байдлыг хангах, нөгөө талаар хариуцлагыг нь сулруулахгүй байх эрх зүйн орчин бүрдэх юм.

Үндсэн хууль 2020 оны 5 сарын 24-нөөс эхлээд мөрдөгдөх учраас түүнээс өмнө Шүүхийн сахилгын хороотой холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд саяны дурдсан үзэл баримтлал, нарийвчилсан зохицуулалтууд хуульд тусгагдах юм бол шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшлэх ийм чухал үр дагавартай.

Эцэстээ аливаа хэрэг маргааныг шүүх хараат бусаар, шударгаар төвийг сахиж шийдэх тэр нөхцөл дээшилнэ гэж харж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.



ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Илтгэгч: АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн И.Мөнхжаргал



Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн зөвлөл нь иргэд, олон нийтийн төлөөлөл бөгөөд авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Авлигатай тэмцэх газарт зөвлөмж, санал хүргүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Энэ утгаараа иргэдийн шүүхэд итгэх итгэл болон хууль хяналтын байгууллагын шүүх үйл ажиллагааны талаарх санал бодлыг энэ удаагийн илтгэлдээ товч дурьдлаа.

Монгол улсын шүүхийн байгууллага нь авлига хамгийн их тархсан институц болсныг олон судалгааны ажлын үр дүн болон иргэдийн үзэл бодлоос тодорхой харагддаг. Зарим шүүхийн байгууллагын төлөөлөл ч үүнтэй санал нийлдэг. Шүүх эрх мэдэлд хамгийн сайн жишиг тогтсон улсаар АНУ-ыг нэрлэдэг. Энэ улсын иргэдийн шүүхэд итгэх итгэл 80 орчим хувьтай байдаг

байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 10 жилд тогтвортой байгаа юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт судалгааг явуулж тайлангаа олон нийтэд зарласан ба уг судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 60 хувьтай гэсэн байсан. Энэ нь бодит байдалд нийцээгүй үр дүн юм. Учир нь бид / олон нийтийн зөвлөл/ чиг үүргийнхээ хүрээнд иргэдийн шүүхэд итгэх итгэл болон шүүхийн үйл ажиллагааны талаар дараахь судалгаануудыг хийсэн. Үүнд:

- Асуулгын хуудсаар авсан тоон судалгаа
- Бүлгийн ярилцлага
- Баримт бичгийн шинжилгээ

Нэг. Тоон судалгааг Улаанбаатар хотын хэмжээнд нийт 800 гаруй иргэдийн дунд зохион байгуулсан. Уг судалгааг 5 агуулгын хүрээнд хийсэн бөгөөд үр дүнг нэгтгэхэд иргэдийн шүүхэд итгэх итгэл 17 хувьтай гарсан. Дээрх хоёр судалгааны үр дүнг харьцуулж харахад маш их зөрүүтэй байгаа нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн судалгааны дүгнэлтэд эргэлзэхэд хүргэж байгаа юм.

Судалгааны зарим үр дүнгээс тодруулахад дараахь байдалтай байна.

1. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн шүүхэд итгэх итгэлийн талаар асуухад шүүхэд итгэдэг 17 хувь, итгэдэггүй 45 хувь, мэдэхгүй 21 хувь, эргэлздэг 21 хувь байна.

Зураг №1


Иргэд шүүхэд итгэдэг эсэх



2. Шүүх шийдвэр гаргахад хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлийг та юу гэж тодорхойлох вэ? гэсэн асуултад өндөр албан тушаалтнууд нөлөөлдөг гэж хамгийн их буюу 41 хувь, найз нөхөд, ах дүү, хэлхээ холбоо, хамаатан садан гэж 22 хувь, дээд шатны шүүгч гэж 19 хувь нь хариулсан бол 18 хувь нь шүүгч өөрийг итгэл үнэмшил, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрээ гаргадаг гэж хариулжээ.

Зураг №2

Шүүхийн шийдвэр гаргахад хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл



3. Шүүх Авлига, албан тушаалтын гэмт хэргийг үнэн, зөв шийдвэрлэж чадна гэдэгт та итгэдэг үү гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 2 хүн тутмын нэг буюу 44 хувь нь үгүй, 29 хувь нь мэдэхгүй, 27 хувь нь тийм гэж тус тус хариулсан. Энэхүү судалгааны үр дүнг нэгтгэн, товчоор дүгнэхэд иргэд шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байдаг төдийгүй, тэдний шийдвэрт төдийлөн итгэдэггүй нь харагдаж байна.

Хоёр. Бид дээрх судалгааны зарим үр дүнг тодруулах, зарим иргэдийн үзэл бодлыг тандах зорилгоор бүлгийн ярилцлагыг нийт 40 иргэдийн дунд зохион байгуулсан. Энэ үед иргэд Шүүх болон Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн зөвлөл, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд зарим талаар шүүмжлэлтэй хандаж байгаа хэдий ч сүүлийн үед Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлж байгаа зарим бодлого, арга хэмжээ нь иргэдэд итгэл төрүүлж байгааг дурьдсан.

Бид судалгаанд хамрагдсан иргэдийн санаа бодлыг дараахь байдлаар нэгтгэн дүгнэж иргэний өмнөөс энд дурьдаж байна. Үүнд:

- **Шударга бус шүүгч нараа солих/ хонгилын шүүгч гэж нэрлэсэн байсан/;**
- **Шүүх, хуулийн байгууллагуудад хамаатан садан, танилын холбоогоор ажиллахыг болиулах /Жишээ нь: нөхөр нь шүүгч, эсхүл эхнэр өмгөөлөгч, хүүхэд нь прокурор. Энэ танилын холбоогоор асуудлыг шийддэг байдал хэрээс хэтэрсэн гэж иргэд үзэж байна/;**
- **Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хэрвээ шүүгч хүсвэл хараат бус байдлаа өөрөө хангаж чадна /Хангалттай хуулийн тогтолцоо байгаа гэдгийг хүн болгон**

хэлж байгаа. Шүүгч хууль, ёс зүйн дүрмээ биелүүлж нөлөөллийн мэдүүлэг өгсөн хүн 6 байсан. Маш олон жилийн хугацаанд зургаан хүн надад нөлөөллөө гэж Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдүүлсэн байна/;

- **Шүүгч гаргаж байгаа шийдвэрээ энгийн, ойлгомжтой байдлаар бичиж, танилцуулж байхыг хүсч байна** /Шүүхийн шийдвэрт юу бичсэн, юуг үндэслэснийг иргэд ойлгож чадахгүй байна/;
- **Шүүгчийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх;**
- **Олны анхаарал татсан, нийгмийн дуулиант хэргүүдийг олон нийтэд ил, байнга анхаарлын төвд байлгах** /Эдгээр хэргүүдийн шийдэхгүй, нуугаад байна гэсэн хардлага иргэдэд маш их байна. Одоогийн байдлаар эцэслэн шийдэгдсэн томоохон хэрэг байхгүй ба сэжигтэн, холбогдогч нарыг сүр дуулиантай барьж, хорьж мөрдөн байцаах, прокурорын шатанд явж явж байгаад, шүүх дээр очоод хэрэгсэхгүй болдог гэсэн хардлага маш их байна./

Гурав. Зөвлөлийн гишүүний чиг үүргийн хүрээнд шүүхийн 2019 оны 1, 2, 3 дугаар улирлын бүх тайланд баримт бичгийн шинжилгээг хийсэн. Үүнээс жишээ болгон 2019 оны 3 дугаар улиралд Нийслэлийн Давж заалдах шатны эрүүгийн хэргийн шүүхийн зарим тоон мэдээллийг доор харуулья. Энд шүүгчийн мэдлэг боловсролтой холбоотой дараахь асуудлуудыг хөндөж байна.

Нийт анхан шатны шүүхээр шийдэгдсэн хэргийн 90 хувь буюу 1735 нь давж заалдах шатны шүүхээр шийдэгдсэн. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн 714 байна. Энэ нь 41.1 хувь. Өөрчлөлт

оруулсан 511 буюу 29.5 хувь байгаа бол хүчингүй болгосон 510 буюу 29.4 хувь байна.

Зураг № 3

2019 оны 3 дугаар улиралд давж заалдсан эрүүгийн хэрэг

Нийт шийдвэрлэсэн хэргийн тоо	Хэвээр үлдсэн	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
1735	714	511	510
	41,1%	29,5%	29,4%

Нийслэлийн захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхээр шийдэгдсэн 909 хэрэг, үүнээс хэвээр үлдээсэн 388 буюу 42.7 хувь, өөрчлөлт оруулсан 201 буюу 22.1 хувь, хүчингүй болгосон 320 буюу 35.2 хувь байна.

Зураг №4

2019 оны 3 дугаар улиралд давж заалдсан захиргааны хэрэг

Хянан шийдвэрлэсэн	Хэвээр баталсан	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
909	388	201	320
	42,7%	22,1%	35,2%

Эндээс бид юу олж харах ёстой юм вэ? Нэг бол анхан шатны шүүгч нар мэдрэл муутай юм байна, эсхүл давж заалдах шатны шүүгч нар авлига аваад, шийдвэрийг хүчингүй болгодог. Иргэд ийм байр суурьтай байна. Зарим шүүгч нартай уулзаж энэ талаар тодруулахад “Хэрэг бүхэн шинэ, шийдэж байгаа шүүгч бүхэн өөрийн итгэл үнэмшлээр шийдэж байгаа...” гэж хариулдаг.

Гэвч эдгээр шүүгч нарын хэрэглэж байгаа хууль болон ажиллаж байгаа орчин, ёс зүйн дүрэм чинь адилхан байхад яагаад ийм ялгаатай шийдвэр гаргаад байгаа нь эргэлзээ төрүүлж байна. Анхан шатны шүүх дээр хүнийг 500.000 төгрөгөөр торгосон бол давж заалдах шатны шүүх дээр очоод тэр нь хүчингүй болдог, эсхүл нэмэгддэг, өөрчлөгддөг. Магадгүй 10 хувьд нь

процессийн, бичиглэлийн алдаа гарсан байж болох ч 2 хэрэг тутмын нэгний шийдвэрлэлт өөрчлөгдөж байгаа нь шүүхийн үйл ажиллагааг шүүмжлэхэд хүргэж байна.

Хэрвээ эмчид очиж үзүүлээд 2 эмч тутмын нэгний онош нь өөрчлөгдөөд байвал юу болох вэ. Энэ нь шүүгч нарын мэдлэг боловсролтой холбоотой юм уу, эсхүл авлигатай ч холбоотой юм уу гэдгийг тодорхойлох нь зүйтэй байна.

Дүгнэлт: Хүний алдаа оноог дэнсэлдэг эрх энэ ардчилсан оронд ганцхан шүүгчид л байдаг. Магадгүй шүүгчид дөхөж очих зүйл бол бурхан л байх. Хэрвээ энэ шүүхэд итгэх итгэл байхгүй болвол иргэд бурханд найдаад орхино эсхүл өөрсдөө шүүхийг байгуулах болно.

Энэ бол хамгийн эмгэнэлтэй зүйлийн дохио юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн сайтын мэдээллээс харахад 2 хэрэг тутмын 1 хэргийн шийдвэр алдаатай буюу өөрчлөгдсөн байна. Мэдээж хууль хэрэглээ нь өөр, өөр байж болох ч шийдвэрийн зөрүү маш өндөр байгаа юм. Энэхүү алдаа нь шүүгчдийн мэдлэг боловсрол, ур чадварын дутуугаас уу, эсвэл ёс зүйгээс хамаарч байна уу гэдэг нь эргэлзээтэй. Гэвч алианаас нь шалтгаалснаас үл хамааран иргэдийн шүүх салбарт итгэх итгэл алдарч, үйл ажиллагаанд нь шүүмжлэлтэй хандаж байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

Монгол Улсын хуулиар шүүгч нарт хамгийн их цалин өгч байгаа, хамгийн их хараат бус байлгаж байгаа, хуулиар Олон улсын түвшинд хүртэл хараат бус байдлыг нь хангасан, хадгалж ч байгаа. Шүүгчид 10 жилийн өмнө л бид нарт өндөр цалин хэрэгтэй, бид нарт стандарт хэрэгтэй гэж яриад сууж байсан хүмүүс өнөөдөр ахиад энэ

зүйлээ яриад сууж байна.

Гэвч энэхүү эмгэнэлт байдал нь шүүхийн стандарчилсан зүйл биш харин ёс зүй юм.

Хамгийн их ёс зүй алдагдсан газар л хууль нэмж батлагддаг. Өнөөдөр байгаа хуулийн хүрээнд ёс зүйтэй шийдвэр гаргах боломж бүх шүүгч нарт байгаа. Гэвч Монголын шүүгчдийн явуулж байгаа үйл ажиллагаа, гаргаж байгаа шийдвэр нь иргэдийн дургүйцлийг хүргээд зогсохгүй цаашид тэдний итгэлийг үгүй хийж байна. Үүнийг олон зүйлээс харж болох бөгөөд манай судалгааны үр дүнгээр батлагдаж байгаа юм.

Иргэд шүүхдээ итгэхгүй байх нь олон сөрөг үр дагаврыг нийгэмд бий болгодог.

Гэвч шүүгч нар авлига, албан тушаалтны нөлөөнд автахгүй байх дараахь боломжууд байгаа гэж судлаачид бид үзэж байна. Үүнд:

- 1. Шүүгч хэн нэгэнд нөлөөлөх гэж оролдох боломжийг хаах** /Хэн нэгний нөлөөллийг хаах боломж шүүгч нарт өөрт нь байгаа. Тэд нөлөөлийн мэдүүлгээ өгөөд, хараат бус байж, шийдвэртээ түүнийгээ тусгаж чадвал үүнийг шийдвэрлэх боломжтой юм. Аливаа шинэчлэлт, өөрчлөлт хүнээсээ эхлэх болохоос, ёс зүй, хууль өөрчлөгдснөөр эхэддэггүй тул шүүгч нар өөрсдийн ёс зүйд анхаарах хэрэгтэй байна/;
- 2. Шүүгч өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлж, алдаа гаргахгүй байх** /2 хэрэг тутмын 1 нь хүчингүй болоод байхад хуулиа буруу хэрэглэж алдаа гаргаад байгаа шүүгч нь яагаад ажиллаад байдаг юм. Эсхүл давж заалдах, хяналтын шатандаа ёс зүй нь алдагдаад байгаа юм уу. Хэрэг болгон өөр, шүүгчдийн итгэл үнэмшил, хууль

хэрэглэх арга өөр байж болох ч зарим статистик мэдээний дүн маш олон эргэлзээг дагуулж байна/;

- 3. Шүүгч нар нийгмийн орчин, өөрчлөлтийг мэдэрч ойлгох /** Нийгэм, эдийн засаг, техник технологийн өөрчлөлт, хөгжлийг дагаад шүүгчдийн гаргаж байгаа бүх шийдвэр нийгмийн орчинд, иргэдийн өмнө ил байгаа. Хүн бүр шүүхийн шийдвэрт анализ хийх чадвартай болсон төдийгүй хууль гэдэг хүн болгоны мэддэггүй зүйл биш юм. Шүүгч нар шийдвэрээ янз бүрийн хуулиар тайлбарлаж болох ч иргэд үүнийг чинь хянах бүрэн боломжтой болсон. Иймээс шүүгч нар шийдвэрээ иргэдэд ойлгомжтой гаргаж байх шаардлагатай байна/;
- 4. Шүүгч байнга өөрчлөгдөх улс төрчдийн утсан хүүхэлдэй болохгүй байх /**Шүүгч нарыг 4 жилээр томилдоггүй бөгөөд Монгол Улсад үйлчилж байгаа ажлын байрууд дундаас хамгийн баталгаатай ажлын байр. Иймээс 4

жилийн бүрэн эрхтэй улс төрчдийн нөлөөнд автахгүй байх бүрэн боломжтой юм/;

- 5. Шүүгч өөрийн мэдлэг, ур чадвар болон ёс зүйд эргэлзэж байгаа бол ухамсартайгаа ажлаа хүлээлгэн өгөх /**Шүүгч өөрийгөө дээрх нөхцөл байдлуудад байгаа гэж үзвэл үтэр түргэн ажлын байраа чөлөөлөх хэрэгтэй. Ингэж чадвал иргэдийн шүүхэд итгэх итгэл нэмэгдэж эрхэм шүүгч нарын өөрсдийн нэр хүнд сэргэх болно.

Эцэст нь дүгнэхэд иргэд шүүх, шүүхийн байгууллага, тухайн байгууллагын шийдвэрт нэгэнт итгэхээ больжээ.

Харин энэхүү итгэлийг шүүгч нар өөрсдөө л сэргээж чадах ба гаднаас хэн нэгэн улс төрч, эрдэмтэн судлаач, гоё уран цэцэн ярьсан хэн ч сэргээж чадахгүй.

Шүүхийн салбарын хөгжил гагцхүү шүүгчдийн гарт байна.



ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ШҮҮХИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Илтгэгч: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Мандах



Агуулга:

Ил тод нээлттэй байдал

- Шүүх дэх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.
- Шүүхийн захиргааны байгууллага дахь мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл: Дотоод судалгаа

- “Шүүхэд итгэх иргэдийн итгэл”, “Хөгжлийн эрэлд” судалгааны байгууллагын хийсэн судалгаа
- “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” Бүх шатны шүүхийн тамгын газар, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

Шүүх дэх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: Бүх шатны шүүх өөрийн цахим хаягаар дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг хүргэдэг. Шүүхийн байранд иргэдэд үйлчлэх төв, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг хүлээн авах “киоск” төхөөрөмж, цахим лавлагааны систем ажилладаг. Хэргийн оролцогч болон иргэдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

мэдээлэл өгөх үүрэгтэй мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ажиллаж байна. Шүүх хуралдааны бичлэгийг хадгалах, архивлах ажил хийгдэж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.32-т “шүүхийн иргэдийн төлөөлөгч” гэж шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэнийг хэлэхээр хуульчилж өгсөн.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2.1 дэх хэсэгт заасан шүүх хуралдааныг хаалттай явуулах тохиолдлоос бусад тохиолдолд нээлттэй явуулах хуулийн зохицуулалттай бөгөөд хаалттай шүүх хуралдааны тогтоолыг нийтэд уншиж сонсгодог.

Шүүхийн захиргааны байгууллага дахь мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Шүүхийн шийдвэрийн цахим сан. 2009 оноос хойших эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шатны шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй болгосон. Шүүх хуралдааны зар, тойм, шүүхээс авах зарим үйлчилгээний талаарх мэдээлэл мөн багтсан байдаг.

Хэргийн хөдөлгөөний удирдлагын төв. ШЕЗ-ын төв байрнаас эрүү, иргэн, захиргааны хэргийн бүх шатны шүүхийн

хэргийн хөдөлгөөний урсгалыг харах боломжтой.

Шүүх хуралдаанд онлайн хэлбэрээр оролцох. Орон нутагт болж буй шүүх хуралдаанд хотоос оролцох хэргийн оролцогчийг онлайн хэлбэрээр оролцуулах өрөө, тоног төхөөрөмж ажиллуулж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. Мэдээ мэдээлэл, тогтоол, дүрэм, журам, шүүхийн ёс зүйн хороо, шүүхийн мэргэшлийн хороо, эвлэрүүлэн зуучлах зөвлөл зэрэг бүх үйл ажиллагааны мэдээллийг нэг дороос авах боломжтой.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл, гаднаас авсан судалгаа:

Төрийн байгууллага:

- Монгол Улсын шинжлэх ухааны академийн судалгаа /2005 – 2013 он/
- Монгол авлигатай тэмцэх газрын судалгаа /2008 – 2014 он/
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаа /2013 он/

Олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага /NGO/:

- "Азийн барометр" Олон улсын ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа /2008 – 2014 он/
- Нээлттэй нийгэм Форум, Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа. / 2008 он/
- Дэлхийн банк, Авлигатай тэмцэх газрын засаглалыг дэмжих төсөл судалгаа. /2009он/
- "Азийн сан" , "Сант марал" сангийн "Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох"

судалгаа. / 2010 – 2015 он/

- Эрх зүйт ёс ба авлигаас ангид байх үзүүлэлт судалгаа.
- ГОУХАН-с Монгол Улсын шүүхийн байгууллагад хийсэн судалгаа.
- Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга байдлын судалгаа.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл, дотооддоо авсан судалгаа:

ШЕЗ-ын захиалгаар:

- "Шүүхэд итгэх иргэдийн итгэл" Хөгжлийн эрэлд судалгааны төв. /2015 он/
- 21 аймаг 9 дүүргийн хөдөлмөрийн насны 3290 хүн амын төлөөлөл оролцсон судалгаа.
- "Шүүхэд итгэх иргэдийн итгэл" үйлчлүүлсэн 60,6%, үйлчлүүлээгүй 81.4, %

ШЕЗ, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа:

- "Шүүхэд итгэх иргэдийн итгэл" ШСМСХүрээлэн / 2017 – 2019 он/
- Бүх шатны шүүхийн 41, тамгын газрын нийт 3000 гаруй албан хаагчдаас авсан түүвэр судалгаа.
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл 63,1%- 64,8% -тай байна.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл:

2003-2010 онд явагдсан судалгаанаас үзвэл шүүхийн талаар олон нийтийн үнэлгээнд эерэг хариулт гараагүй, шүүхэд итгэх итгэл улам бүр алдарч байгааг ШУА-ын ФСЭХ-ийн судалгаанд дурьдсан. Мөн дөрвөн хүн тутмын гурав нь буюу 75 хувь нь шүүхэд итгэхгүй байгааг 2010 онд явагдсан "Сант марал сан"-ийн судалгаа болон УТБА-ын "Азийн барометр" судалгаагаар илэрхийлсэн.

Шүүгч, шүүхийн байгууллага нь

засаглалын бусад эрх мэдэл, улс төрчид, албан тушаалтны нөлөөнд өртдөг гэх хандлага байна. ШУА-ын судалгаагаар шүүхийн шийдвэрт албан тушаалтан нөлөөлдөг гэж 2005 онд судалгаанд хамрагдсан иргэдийн 68 хувь нь үзэж байсан бол 2008 онд 75 хувь болж өссөн байна. 2009 онд Нээлттэй нийгэм форумын захиалгаар АНУ-ын Аризонагийн их сургуулийн эрдэмтэн Б.Вайтын судалгаагаар “Шүүгч шийдвэр гаргахдаа ямар нэгэн зүй бус нөлөөнд автдаггүй” гэдэгтэй 77 хувь нь санал нийлэхгүй байна. Олон улсын судалгааны “Херитэйж фаундэйшн” байгууллагын 2015 оны тайланд “Шүүх эрх мэдэл бие даасан боловч улс төрийн нөлөөнд өртөмтгий” байгааг дурдсан байна.

Шүүх эрх мэдлийн хараат бус байдал нь төсөв мөнгөний хүрэлцээ, шүүгчдийн цалин, орлого, бусад хангамжийн асуудалтай холбоотой гэж дүгнэж байна. ШУА-ын ФСЭХ-ийн судалгаагаар шүүх эдийн засаг санхүүгийн хараат байдалтай байна гэж дүгнэсэн байна. Нээлттэй нийгэм форум, Б.Вайтын судалгаагаар шүүгчийн цалинг 1000-3000 долларын хооронд шүүгчийн цалинг хөдөлмөр, зүтгэлээр нь тогтоож байх, хуулиар шүүгчийн цалинг зүй бус үйлдэл гаргасан үндэслэлээр үндсэн цалинг нь бууруулахаас бусад ямар ч тохиолдолд багасгахгүй байх, шүүгчийн цалин хамгийн шилдэг хуульчдыг татахуйц байх, шүүгч авлигад автан ажлаа эрсдэлд орохоос зайлсхийж байх ёстой гэсэн зөвлөмж боловсруулсан байна. Авлигатай тэмцэх газрын 2012 оны судалгааны тайланд “Шүүх хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахын тулд албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэдгийг дурдсан байна.

Транспэрэнси интернэшнл байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын индекс 2013 онд 38 оноо, 2014 онд 39 оноогоор 80 дугаар байранд орж урагшилсан, 2017 онд 36 оноотой болж өмнөх оны үзүүлэлтээс 13 байраар ухарсан.



Харин шүүх эрх мэдлийн үнэлгээ урагшилсан байна. Тодруулбал, авлигын төсөөллийн индексийн 13 эх сурвалжийн нэг болох “Bertelsmann Foundation Transformation Index”-ийн тайланд Монгол Улс 2015, 2016 онд 100 онооноос 36 оноо авч байсан бол 2017 онд 41 оноо авч урагшилсан байна. Шүүхийн нэр хүндийг илэрхийлэх чухал үзүүлэлт нь авлигын түвшин бөгөөд сүүлийн жилүүдэд авлигын түвшин буурсан байгаа боловч ерөнхий хүрээгээрээ буюу Монгол Улсын хэмжээнд авлигын индекс ухарсан үзүүлэлттэй байгаа учир авлигыг бууруулах бодлогыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл /ШСМСХ/

Зорилт:



- Шүүхийн үйлчилгээ, хүндрэл, бэрхшээл;
- Шүүх өөрчлөгдсөн эсэх, шүүхийн өөрчлөлт;
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шударга байдал;
- Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн талаарх иргэдийн төсөөлөл;
- Шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилт.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шүүхийн үйлчилгээ, хүндрэл бэрхшээлийг дотооддоо хийсэн судалгаа:




Шүүхэд итгэх, иргэдийн итгэл тэгш байдлын талаар дотооддоо хийсэн судалгаа:


Шүүх өөрчлөгдсөн эсэх, шүүхийн өөрчлөлтийн талаар дотооддоо хийсэн судалгаа:



Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар:



Шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилт:



Дүгнэлт: Энэ санал асуулгын судалгаагаар иргэдийн 64.8 хувь шүүхэд итгэдэг гэсэн үзүүлэлт гарсан нь шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байгааг харуулж байна. Энэ нь өмнөх онд хийгдсэн судалгааны дүн (67.2%)-ээс 3 орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Харин шүүхийн шинэтгэл эхлэхээс өмнөх 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 орчим хувьтай байсан бол 2015 оны байдлаар иргэдийн итгэл 60-80 хувь болж өссөн гэсэн хөндлөнгийн байгууллагын судалгааны үр дүнг бататгасан хэвээр байна.

Судалгаагаар шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хүнийг ялгаварладаггүй гэж иргэдийн 51.7 хувь нь үзжээ. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн олонх нь буюу 67.9 хувь нь өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн шүүхийн шүүгчийн талаар зэрэг бодолтой байна. Мөн иргэдийн 50 гаруй хувь нь шүүгчийн сонгон шалгаруулалтаар зөв хүнийг олж байна, итгэж байна гэж хариулсан байна.

Энэхүү санал асуулга дахь зарим агуулгыг 2019 оны сүүлээр шинэчилсэн. Тухайлбал, дараах асуултууд санал асуулгад шинээр тусгагдсан. Үүнд:

- Та шүүхээс авсан үйлчилгээндээ хэр сэтгэл ханамжтай байна вэ?
- Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажлын чанар, үр нөлөөг хэрхэн үнэлж байна вэ?
- Шүүгчдийн сахилга, хариуцлага, ёс зүйн түвшний талаарх таны төсөөлөл?
- Шүүхийн шийдвэрийн биелэлт таны бодлоор?

Цаашид энэ чиглэлээр хэрэгжүүлэх ажил:

Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг тодорхойлох ажлыг хөндлөнгийн бие

даасан байгууллагаас гүйцэтгэж байх.

Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг тодорхойлох асуудлыг зөвхөн нэг эх сурвалжид биш хэд хэдэн эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан гаргах боломжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, хөндлөнгийн байгууллагын судалгааны үр дүнг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс авсан санал асуулгын үр дүнтэй хосолмол байдлаар ашиглах боломжтой болгох.

Зөвхөн шүүхэд итгэх иргэдийн итгэл гэж хязгаарлахгүйгээр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шатнаас өмнөх шатан дахь итгэлийн асуудлыг ч тухайн байгууллагууд дотооддоо судлах.

Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг

тодорхойлох ажил нь ерөнхий агуулгаараа зөвхөн шүүхийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бусад байгууллага, хууль сахиулагчид, хуульчдын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч байгаа гэдгийг цаашид анхаарах хэрэгтэй юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэд хэдэн байгууллагын үйл ажиллагааг дамждаг хэрнээ хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэдэг гэдэг агуулгаараа энэхүү ажиллагааны эцсийн үр дүн шүүх байгууллагын нэр хүнд дээр буудаг.

Иймд итгэлийн асуудлыг аль нэг байгууллага гэхээсээ илүү тогтолцооны түвшинд авч үзэх судлах, энэ талаар хамтран ажиллах шаардлагатай байна.



ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТ: ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Илтгэгч: Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар



Шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэлт, олон нийтийн итгэлийн талаар Шүүхийн Ёс зүйн хорооны статистик, судалгаанд тулгуурлан илтгэл тавина.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 онд батлагдаж 2013 оноос хэрэгжиж эхэлснээр Шүүхийн ёс зүйн хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, байгуулах журмыг Шүүхийн захиргааны тухай хуулиар, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Нэг. Шүүгчийн Ёс зүйн гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн, эрх зүйн байдал: Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт Ёс зүйн хорооны гишүүнд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус

бүр нэг, Хуульчдын холбооноос гурав, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүний нэрийг дэвшүүлнэ. Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно. Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт зааснаар Ёс зүйн хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална. гэсний дагуу тус хороо байгуулагдан чиг үүргээ хэрэгжүүлснээр гурав дахь бүрэн эрх хэрэгжиж эхлэх үед энэхүү хуралдаанд илтгэл тавих болсон нь завшаантай хэрэг боллоо.

Шүүхийн Ёс зүйн хороо 2014 оноос чиг үүргээ хэрэгжүүлж эхэлснээс хойш зургаан жилийн хугацаанд өнөөг хүртэл зургаахан сар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас нэр дэвшин томилогдсон гурван гишүүн өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргаж хоёр гишүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган чөлөөлсөн, нэг гишүүний хүсэлтийг нэр дэвшүүлсэн байгууллага уламжлаагүйн улмаас нэг жил идэвхгүй байдалд, зарим гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, гишүүн нас барсан зэрэг шалтгаан бий болж нөхөн нэр дэвшүүлэх ажиллагааны зохион байгуулалт, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүнд суртал, мөн нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилохоос татгалзах зэрэг бодит шалтгаанаар бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах нөхцөлийг бүрдүүлсэнгүй.

Шүүхийн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн дутуу байхын сөрөг

тал нь орон тооны бус гишүүдийн ажлын ачаалал нэмэгдэх, зарим тохиолдолд гомдол, сахилгын хэргийг шийдвэрлэхээс Ёс зүйн хорооны гишүүн татгалзан гарах, мөн гомдол гаргагч, шүүгчдийн зүгээс гишүүнээс болон бүрэлдэхүүнээс татгалзах зэргээр хуралдааны ирцэд нөлөөлж Ёс зүйн хорооны хуралдааны хэвийн үйл ажиллагаа алдагдуулж байна. Түүнчлэн идэвхтэй цөөн гишүүн байнгын шинжтэй гомдол шалгаж шийдвэрлэх нь олон нийтийн зүгээс хардлага төрүүлж, Шүүхийн ёс зүйн

хороо болон шүүхэд итгэх итгэлийг бууруулах эрсдэлтэй байна.

Хоёр. Шүүгчийн Ёс зүйн гомдол хянан шийдвэрлэлт: Шүүхийн Ёс зүйн хороо нь сүүлийн 6 жилд дунджаар давхардсан тоогоор 340 шүүгчид холбогдуулан 230 орчим гомдол шийдвэрлэж тэдгээрийн 80 орчим хувьд нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзан, 12 хувьд нь сахилгын хэрэг үүсгэж, 4 хувьд нь сахилгын шийтгэл ногдуулжээ.

2014-2019 онд хүлээн авсан гомдол шийдвэрлэлтийн тойм

дд	Он	Гомдол хүлээн авсан		Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан		Сахилгын хэрэг үүсгэсэн		Сахилгын шийтгэл оногдуулсан магадлал				Хүчин төгөлдөр шийдвэрээр сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч			Бүгд
		Шүүгч	Гомдол	Шүүгч	Шийдвэр	Шүүгч тоо	Шийдвэр тоо	Сануулах	Цалин бууруулах	Огцруулах	Бүгд	Сануулах	Цалин бууруулах	Огцруулах	
1	2014	326	208	286	129	31	24	3	3	1	7	1	-	-	1
2	2015	284	213	224	165	36	27	11	3	-	14	1	-	-	1
3	2016	376	231	299	153	42	33	4	3	1	8	2	1	1	4
4	2017	378	242	301	153	33	27	9	3	1	13	2	2	-	4
5	2018	342	241	284	135	57	45	17	8	4	29	3	1	1	5
6	2019.11.01.	290	201	277	182	29	24	3	2	-	34	1	3	-	4
	Дүн	1996	1336	1671	917	228	180	47	22	7	76	10	6	2	18

2019 оны байдлаар 290 шүүгчид холбогдох 201 гомдлыг хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал гомдлын тоо 45 буюу 22.88 хувиар өсжээ.

Хүлээн авсан гомдлыг нэг шүүгчид ногдох давтамжаар авч үзвэл: 10 гаруй шүүгчид 4 буюу түүнээс дээш удаа, 50 гаруй шүүгчид 2-3 удаа, 100 гаруй

шүүгчид нэг удаа нийтдээ 160 гаруй шүүгчид гомдол гаргасан нь нийт /503/ шүүгчийн 32 хувьд гомдол гаргажээ.

Нийт шүүгчдийн 68 хувьд Ёс зүйн гомдол гаргаагүй байгаагаас дүгнэвэл, шүүхэд итгэх итгэл 60 гаруй хувьтай байна гэж үзэхээр байна.

Шүүхийн харьяаллаар нь гомдлыг авч үзвэл, Нийслэл дэх Иргэний

хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид 33,8 хувь, орон нутгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Улсын дээд шүүхийн иргэний танхимын шүүгчид тус бүр 12 хувийг эзэлж байна. Хамгийн бага хувийг орон нутаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид 0,19 хувийг эзэлж байна.

Шүүгчийн ёс зүйн гомдолд дурдагдсан шүүгчийн шүүхийн харьяалал

Он	Нийт шүүгчийн тоо	Нийслэл дэх анхан шатны шүүх			Орон нутаг дахь анхан шатны шүүх			Нийслэл дэх давж заалдах шатны шүүх			Орон нутаг дахь давж заалдах шатны шүүх	Сум дундын шүүх	Хяналтын шатны шүүх		
		Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа			Эрүү	Иргэн	Захиргаа
2017 он	315	14	98	28	25	45	12	5	4	15	7	8	4	33	17
2018 он	275	22	102	17	18	26	13	8	20	2	9	7	0	26	5
Дүн	590	36	200	45	43	71	25	13	24	17	16	15	4	59	22
Хувь	35%	6.10	33.8	7.6	7.2	12.0	4.2	2.7	4.0	2.88	2.7	2.54	0.6	10.0	3.72
2019.07.01	131	11	43	20	16	20	16	7	13	2	-	4	5	12	8
Хувь	26.04	2.18	8.54	3.97	0.19	3.97	0.19	1.39	2.58	0.39	-	0.79	0.99	2.38	1.59

Шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн ачааллын судалгаатай харьцуулан үзэхэд хаана ачаалал их байна тэнд шүүгчийн ёс зүйн гомдол их гарчээ.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн талаар гаргасан гомдол хэдий их байгаа ч гэсэн Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны

шүүхийн шүүгчийн талаар гаргасан гомдлын тоотой харьцуулбал сахилгын шийтгэл хүлээсэн хувь хэмжээ бага байна. Өөрөөр хэлбэл Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн талаар гаргасан гомдол их байгаа боловч сахилгын хариуцлага ногдуулсан хувь хэмжээ Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид их байна.

Сахилгын шийтгэл ногдуулсан байдлыг шүүхийн харьяаллаар харуулав

	Сануулах	Цалин бууруулах	Огцруулах
Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	6	1	-
Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	-	1	1
Орон нутгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	3	-	-
Орон нутгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1	3	-
Орон нутгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	-	-	1

Орон нутгийн Давж заалдах шатны шүүхийн шүүгч	1	1	-
Сум дундын шүүхийн шүүгч	1	2	-
Бүгд - 22	12	8	2

Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргасан байдлыг субъектээр нь харуулбал: Монгол Улсын иргэний гаргасан гомдлын тоо буурсан, харин албан тушаалтнаас гаргасан буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл,

Прокурор, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, УИХ, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргаа зэрэг байгууллагад иргэн, хуулийн этгээдийн хандаж гаргасан буюу шилжүүлсэн гомдлын тоо 110 хувиар өссөн байна.

Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргасан байдлыг субъектээр нь харуулбал:

Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан болон шилжүүлсэн		2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019.12.01
Иргэн	Монгол Улсын иргэн	150	118	110	119	115	89
	Гадаад Улсын иргэн	-	-	-	4	1	1
	Итгэмжлэгдсэн төлөөлөгч	44	30	34	21	20	10
	Хорих, цагдан хоригдож буй этгээд	13	3	4	4	4	2
	Дүн	207	151	148	148	140	102
Албан тушаалтан (Шилжүүлсэн)	Ерөнхийлөгчийн Тамгын газар	-	-	-	-	11	27
	Шүүхийн Ерөнхий зөвлөл	-	-	-	-	8	17
	Прокурор	3	-	-	-	1	-
	Авлигатай тэмцэх газар	-	-	-	1	7	9
	Хүний Эрхийн Үндэсний комисс	-	-	-	1	2	-
	УИХ, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага	10	7	14	5	1	10
	Дүн	13	7	14	7	30	63
Хуулийн этгээд	Өмгөөлөгч	14	11	9	17	26	18
	Монголын Хуульчдын Холбоо	-	-	-	-	3	8
	Аж ахуйн нэгж, компани	49	23	28	43	26	28
	Дүн	63	33	37	60	55	54
Нийт дүн		283	191	199	215	175	219

Харин өмгөөлөгч, иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн гаргасан гомдлын тоо 40 орчим хувиар буурсан. Төрийн бусад институцид гаргаж байгаа гомдлын тоо өссөн байдлаас дүгнэвэл

шүүгчийн хариуцлагын тогтолцооны тогтвортой байдал, хариуцлага хүлээлгэх механизмыг илүү оновчтой болгох шаардлага байгааг харуулж байна.

Шүүгчийн ёс зүйн гомдлын агуулга

дд	Гомдлын агуулга (2017-2019.12.01)	2017 он		2018 он		2019.12.01.	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Хууль зөрчиж шийдвэр гаргаж, хүний эрх зөрчсөн	44	18%	50	21%	58	25.10%
2	Шүүхэд мэдүүлэх, хүсэлт гаргах, өмгөөлүүлэх, нотлох баримт гаргах, үнэлүүлэх, татгалзан гарах эрхээр хангаагүй, шүүх хуралдааны журам зөрчсөн	39	16%	50	21%	32	13.85%
3	Итгэл төрүүлээгүй, нэг талд давуу байдал бий болгосон, үйлчилсэн, тэгш бус хандсан, хувийн ашиг сонирхолтой,	75	32%	59	25%	85	36.79%
4	Зохисгүй байдал гаргасан, загнаж зандарсан, ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлээгүй	21	9%	25	10.3%	17	7.35%
5	Хэргийн хугацаанд нь шийдвэрлээгүй, шийдвэр гаргаагүй, хайнга, ажлаа хийдэггүй	36	15%	30	12.3%	15	6.49%
6	Мэдлэг, ур чадвар муу, эргэлзсэн	15	6%	16	7%	16	6.92%
7	Шүүгч бусад шүүгчдэд нөлөөлсөн	3	1%	6	2.4%	7	3.03%
8	Бусад	8	3%	6	2.4%	1	0.43%
	Дүн	244		215		231	

Хууль зөрчиж шийдвэр гаргаж хүний эрх зөрчсөн гэсэн гомдол 25.01 хувь бөгөөд шүүгчийн гаргасан шийдвэртэй холбоотой юм. Энэ төрлийн гомдол сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.

Мөн шүүгч итгэл төрүүлэхгүй, хэргийн нэг талд давуу байдал бий болгож тэгш бус хандсан гэсэн гомдол 36.79 болж өссөн, харин шударга шүүхээр шүүлгэхтэй холбоотой Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангахад чиглэсэн асуудлаар гаргасан гомдлын тоо өнгөрсөн оноосоо 58 хувиар буурсан. Тухайлбал, шүүхэд хүсэлт гаргах, өмгөөлүүлэх, нотлох баримт гаргах, үнэлүүлэх, татгалзан гаргах эрхээр хангаагүй, шүүх хуралдааны

журам зөрчсөн гэсэн гомдлын тоо буурсан. Энэ нь шүүхийн захиргааны байгууллага болон хувь шүүгчийн ажлын хариуцлагатай холбоотой гомдол гэж үзнэ. Ажилдаа хэр зэрэг нягт байж чадна тэр хэмжээгээр энэ төрлийн гомдол буурдаг.

Зохисгүй байдал гаргасан гэх гомдлын тоо өмнөх оноос 20 хувиар буурсан. Мэдлэг, ур чадвар муу, эргэлзсэн, Шүүгчээс бусад шүүгчид нөлөөлсөн гэх гомдлын тоо төдийлөн буурахгүй байна. Шүүгчийн өөрийнх нь итгэл төрүүлэхүйц байдал хүссэн түвшинд хүрэхгүй байгаатай холбоотой гэж үзэхээр байна.

Гурав. Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаан: Энэ онд 34 удаа

хуралдаан товлон зарлаж нэг удаагийн хуралдаанаар 5-8 гомдол хянан хэлэлцэн, нэг гомдлыг шийдвэрлэхэд дунджаар 1 цаг зарцуулжээ. 7 хоногт 1-2 удаа хуралдаж дунджаар 5-8 цаг зарцуулж байгаа нь байнгын шинжтэй үйл ажиллагаа явуулж орон тооны байгууллагын гүйцэтгэх үүргийг орон тооны бусаар гүйцэтгэж байна гэж үзэхээр ачаалалтай ажиллалаа.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт Энэ хуулийн 33.1-д заасан гомдлыг Ёс зүйн хороо заавал хянан үзнэ. мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт Энэ хуулийн 34.1-д заасан шалгалтын дүнг Ёс зүйн хорооны гурван гишүүн хянаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана. заасны дагуу ирсэн гомдол бүрийг ёс зүйн хороо заавал шалгаж 3 гишүүн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж байна.

Энэ онд 277 шүүгчид холбогдох 182 гомдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, 29 шүүгчид холбогдох 24 гомдолд сахилгын хэрэг үүсгэсэн тогтоол гаргаж, талуудын хүсэлтээр 70 шүүгчид холбогдох 39 тогтоолыг хойшлуулан шийдвэрлэжээ.

Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн гомдлыг шийдвэрлэхэд шүүгчийн зүгээс буюу гомдол гаргагчдын зүгээс хуралдааныг хойшлуулах, биеэр оролцох хүсэлт гаргасны улмаас Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд заасан ёсоор хүсэлтийг хүлээн авч хойшлуулснаас гомдол шийдвэрлэх ажиллагааг удаашруулдаг.

Шүүхийн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнгүйн улмаас Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шилжүүлэн ирүүлсэн болон иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс

гаргасан 52 шүүгчид холбогдох 31 гомдол, мөн гомдол хэлэлцэх хуралдааны 38 тогтоолыг эс зөвшөөрч гаргасан гомдол түүний дотор 12 сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолыг нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцэх боломжгүй байдал үүссэн. Эл байдал нь олон нийтийн анхаарал татаж, шүүхэд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байгааг дурдах нь зүйтэй.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүний олонхын ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэж зохицуулсны дагуу энэ онд 6 удаа хуралдаж сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хэвээр баталсан тогтоол 30, сахилгын хэрэг үүсгэснийг хэрэгсэхгүй болгосон 12, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг дахиж шалгуулахаар буцаасан 2, талуудын хүсэлтээр хойшлуулсан 8, сахилгын шийтгэл ногдуулсан таван магадлал гаргаж гурван шүүгчийг сануулах, хоёр шүүгчийн цалин 6 сарын хугацаагаар 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулаад байна.

Шүүхийн ёс зүйн хороо сүүлийн 5 жилд 185 гомдолд сахилгын хэрэг үүсгэснээс 109 гомдлыг ёс зүйн хороо өөрөө хэрэгсэхгүй болгожээ.

109 сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон 76 сахилгын хэрэгт сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэсэн бол нийт гишүүдийн хуралдаанаас сахилгын шийтгэл ногдуулж гарсан 51 магадлал Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Хяналтын шатны шүүхэд хянагдах явцад 75 хувийг хэрэгсэхгүй болгох буюу хүчингүй болгох, дахин шалгуулахаар буцаах зэргээр шийдвэрлэжээ.

Нийт хянагдсан сахилгын хэргийн

60 орчим хувь нь шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу шүүгчийн мэдлэг ур чадвартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болсон. Мөн шүүхийн хяналтын явцад хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн мөн шүүхийн ёс зүйн хороо гомдолд дурдсанаас хальж шалгасан гэх үндэслэлээр ёс зүйн хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Хяналтын шатны шүүхээс Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр үндэслэлтэй байна гэж Захиргааны хэргийн давж заалдах шатны хүчингүй болгосон хэргийг хүчингүй Шүүхийн Ёс зүйн хорооны шийдвэрийг хэвээр баталсан 4 шийдвэр гарсан энэ бол сүүлийн үед шүүхийн ёс зүйн хороо үндэслэлтэй дүгнэж, шийдвэрийг чанар сайжирч байгааг хэлэх нь зүйтэй.

Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулсан магадлалын 13 буюу 25 хувь нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Хяналтын шатны шүүхээр хэвээр баталсан байна.

Шүүхийн ёс зүйн хороо сүүлийн зургаан жилийн хугацаанд нийт шүүгчдийн 22 буюу 15,1 хувьд нь сахилгын шийтгэл ногдуулахдаа 12 шүүгчийг сануулах, 8 шүүгчийн цалинг бууруулах, 2 шүүгчийг огцруулж шийдвэрлэсэн байна.

Хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр жилд дунджаар 4 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан нь нийт шүүгчдийн 4,2 хувь байна.

Дөрөв.Шүүгчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр: Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн шийдвэрийг шүүхийн

ерөнхий зөвлөлийн албан ёсны веб сайтад тавьж байршуулж байна. Мөн Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулж, шүүхээр хянагдсан шийдвэрийг 2014-2017, 2017-2019 оны шийдвэрүүдийг эмхэтгэн гаргаж, судалгааны байгууллагууд, нийт шүүгч, их дээд сургуулиудын номын санд хүргэлээ.

Шүүхийн ёс зүйн хорооноос 2018 оны 4 сард “Шүүхийн хариуцлагын тогтолцоо ба шүүхэд итгэх итгэл” судалгааны асуулгын “Шүүгчийн ёс зүйн түвшингийн талаарх таны төсөөлөл” гэсэн асуулгад шүүгч 9.3 хувь, иргэн 9.5 нь “Маш сайн” үнэлгээ өгсөн бол шүүгч 73,8 хувь, иргэн 37,6 хувь нь “шүүгчдийн олонх нь сайн” гэж өгсөн байна.

Дээрх судалгааны үр дүнгээр шүүхэд итгэх иргэдийн итгэл 40 орчим хувьтай байна. Энэ нь олон улсын шүүхэд итгэх итгэлийн индекстэй харьцуулахад дундаж түвшинд байгаа боловч манай орны иргэдийн хүлээлтийн түвшинд бага гэж үзэхээр байна.

Эцэст нь хэлэхэд иргэдийн зүгээс шүүхэд итгэх итгэл тийм ч сайнгүй байна.

Шүүхийн ёс зүйн хороонд гаргаж байгаа гомдлын тоо буурахгүй байна. Мөн нэг жилийн дотор нэг шүүгчид 2-4 гомдол гаргаж байгаа нь нийт гомдлын 26 хувийг эзэлж байна.

Энэ 26 хувь илүү хичээж ажиллах шаардлагатай юм.

Шүүхэд итгэж шүүхээс шударга ёсны үйлчилгээг хүсэж байгаа нийгмийн хүлээлтийн түвшинд хүрэхийн төлөө шүүх, шүүхийн захиргааны байгууллага зорьсоор байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.



ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН ЗӨВЛӨӨН

